

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-56

***1.Дээд боловсролын тухай хуулийн
хэрэгжилтийн талаарх Боловсролын сайдын
мэдээллийг сонсо*** 3- 56

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Ч.Ундрам ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 15 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 08 цаг 54 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Бямбасүрэн, М.Сарнай;
Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхтуяа.

**Нэг.Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх
Боловсролын сайдын мэдээллийг сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Дээд боловсролын газрын дарга Ж.Ариунболд, Монгол Улсын их сургуулийн ректор Б.Очирхуяг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректор Б.Дамдиндорж, Монгол Улсын боловсролын их сургуулийн ректор Ж.Батбаатар, Хөдөө аж ахуйн их сургуулийн ректор Б.Баасансүх, Соёл урлагийн их сургуулийн ректор Э.Сонинтогос, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор Н.Эрдэнэхүү, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Сургалт эрхэлсэн проректор Д.Цолмонбаатар, Боловсролын зээлийн сангийн захирал О.Сийлэгмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн байлцав.

Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Боловсролын сайд П.Наранбаяр танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, Д.Бум-Очир, Ж.Галбадрах, Д.Эрдэнэбат, Б.Хэрлэн, О.Батнайрамдал, О.Саранчулуун, Н.Алтаншагай, Г.Дамдинням, Ч.Ундрам нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Дээд боловсролын газрын дарга Ж.Ариунболд, Монгол Улсын их сургуулийн ректор Б.Очирхуяг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректор Б.Дамдиндорж, Монгол Улсын боловсролын их сургуулийн

ректор Ж.Батбаатар, Хөдөө аж ахуйн их сургуулийн ректор Б.Баасансүх, Соёл урлагийн их сургуулийн ректор Э.Сонинтогос, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор Н.Эрдэнэхүү, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Сургалт эрхэлсэн проректор Д.Цолмонбаатар, Боловсролын зээлийн сангийн захирал О.Сийлэгмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, А.Ганбаатар, Д.Эрдэнэбат, Б.Хэрлэн, О.Батнайрамдал, Н.Алтаншагай, Г.Дамдинням, О.Саранчулуун, Ч.Ундрaм нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Боловсролын багц хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулах тухай горимын санал гаргав.

Ч.Ундрaм: Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, О.Батнайрамдал, С.Эрдэнэбат, О.Саранчулуун, Б.Хэрлэн, Н.Алтаншагай, Г.Хосбаяр, Ц.Мөнхтуяа, М.Сарнай нар орж ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 55 минут үргэлжилж, ирвэл зохих 15 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн *ирцтэйгээр* 11 цаг 49 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ч.УНДРАМ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
08 цаг 54 минут.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ч.Ундрэм: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос ирвэл зохих 15 гишүүнээс 8 гишүүн ирсэн байна.

Тийм учраас ирц бүрдсэн учраас хурлаа эхэлье. Ирцийг танилцуулъя. Отгоншарын Батнайрамдал, Амгаланбаатарын Ганбаатар, Бадарчийн Хэрлэн, Дуламын Бум-Очир, Дүгэрийн Рэгдэл, Сүхбаатарын Эрдэнэбат, Жанчивын Галбадрах, Чинбатын Ундрэм нар ирсэн байна.

Өнөөдрийн хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Боловсролын сайдын мэдээлэл сонсоно.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу?

Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Өнөөдөр асуудлыг танилцуулах ажлын хэсгийг танилцуулъя. Боловсролын сайд Наранбаяр орж ирж байна уу тээ? Боловсролын яамны Дээд боловсролын газрын дарга Ариунболд ирсэн байна. Энэ Төрийн нарийн Батжаргал ирсэн байна Боловсролын яамны. Монгол Улсын их сургуулийн ректор Очирхуяг ирсэн байна. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректор Дамдиндорж ирсэн байна. Монгол Улсын боловсролын их сургуулийн ректор Батбаатар ирж байгаа ирж байгаа юу тээ? Хөдөө аж ахуйн их сургуулийн ректор Баасансүх ирсэн байна. Соёл урлагийн их сургуулийн ректор Сонинтогос ирсэн байна. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Сургалт эрхэлсэн проектор Эрдэнэхүү ирсэн байна. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Эрдэм шинжилгээ эрхэлсэн проектор Цолмонбаатар ирсэн байна. Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

Сайд яачхав? Та бүхэнд хэлэлцэх асуудалтай холбоотой материалыг хэвлээд хүргүүлсэн байгаа. Аваагүй хүн байна уу? Бүгд авсан тээ?

Өнгөрсөн парламентаар Боловсролын багц хуулийг батлахад бид нар Дээд боловсролын хуулийг бас шинэчилсэн найруулгаар баталсан байгаа. Тэгээд энэ хуулийн хэрэгжилт ямар түвшинд явж байна, цаашид юун дээр анхаарах вэ гэдгийг гишүүд бас өнөөдөр асуулт асууж, үг хэлэхдээ өөрсдийнхөө бас бодлыг илэрхийлэх байх.

Наранбаяр сайд ирлээ. Наранбаяр сайдын микрофоныг өгье. Асуудлаа танилцуулна.

П.Наранбаяр: Та бүхний энэ өглөөний амгаланг айлтгая.

Дээд боловсролын салбарт өнөөдөр явагдаж байгаа бодлого, ялангуяа судалгааны сургууль бий болгох талаар хийж байгаа алхмын талаар та бүхэнд мэдээлэл өгье.

Өнөөдөр Монгол Улсад 65 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж байгаагийн 34 нь их сургууль, 29 буюу 44 хувь нь дээд, 2 буюу 3.1 хувь нь коллеж байна. Нийт суралцагчийн 2620 нь дэд бакалаврын түвшинд, 117344 суралцагч бакалаврын түвшинд, 24830 суралцагч магистрын түвшинд, 5488 суралцагч докторын түвшинд тус тус суралцаж байна.

2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Боловсролын багц хууль батлагдсанаас хойш дээд боловсролын салбарт Монгол Улсын Засгийн газрын тогтоол 7, Боловсролын сайдын тушаал 14, батлуулсан дүрэм, журам нийтдээ 23 баталсан байна.

Судалгааны их сургууль байгуулах ажлыг дараах үе шаттайгаар явуулж байна. Засгийн газрын 2024 оны 253 дугаар тоот тогтоолын дагуу дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалтын хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллын шийдвэрлэж байна. Тогтоолын дагуу Боловсролын сайдын 2025 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн А03 дугаар тушаалаар дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг тогтоох, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлагдаж, удирдамжийн дагуу ажиллаж байна.

Боловсролын ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээрт, Дээд боловсролын тухай хуулийн 6.1-д заасан дээд сургуулийг их сургууль, эсвэл коллеж болгох шилжилтийн үйл ажиллагааг 2025 оны 6 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулна гэж заасны дагуу ангиллын тогтооно.

Их сургуулиудыг судалгааны, сургалтын, мэргэжлийн гэж ангиллын тогтоох ажил хийхээр төлөвлөж байна. Дээд боловсролын хуулийн 7.8-д заасны дагуу судалгааны их сургуулийг байгуулах хуулийг Улсын Их Хуралд Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хуулиар байгуулна.

Элсэлтийн тухайд элсэлтийн шалгалтыг 2024-25 оны хичээлийн жилээс эхлэн жилд 2 удаа зохион байгуулж, 2025-26 оны хичээлийн жилд босго оноог 490 орон нутгийн сургуулийнхыг 430 болгож тус тус 10 оноогоор нэмэгдүүлсэн. Энэ талаар сургуулийн бүх захирлууд багш нартай зөвлөлдөж ингэж 10 оноогоор нэмэгдүүлсэн байгаа.

Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтыг 5 жил тутам шинэчлэн боловсруулж батлуулахаар хуульчлагдсан бөгөөд 2024 оны А120 тоот тушаалаар ажлын хэсгийг баталж, 25 оны эхний улиралд тус жагсаалтыг шинэчлэхээр ажиллаж байна. Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр хөтөлбөрүүдийн элсэлтийг нэмэгдүүлж, суралцагчдад тэтгэлэг олгох ажлыг зохион байгуулж, эдгээр мэргэжлээр 10803 суралцагч өнөөдөр суралцаж байна.

Тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр суралцагчид Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэг нийтдээ 6.9 тэрбум төгрөг, зарим эрэлттэй мэргэжлээр

суралцагчдад 6.2 тэрбум, сургалтын төлбөрийн зээл 4.3 тэрбум төгрөгийн тэтгэлгийг тус тус олгоод байна.

Төгсөлтийн тухайд дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөлтийн журамд төгсөлтийн баримт болох дипломоо сапплементийг олон улсын жишгийн дагуу сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, үнэлгээ, мэргэжлийн шаталсан бүтэц, уялдаа зэрэг мэдээллээс гадна төгсөгчийн сургалтын хугацаандаа эрдэм шинжилгээ, судалгаа, нийгмийн хариуцлагын чиглэлээр хийсэн үйл ажиллагаа, ололт амжилтыг нарийвчлан тусган олгож эхэлсэн.

Төрийн өмчийн их сургуулиуд хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөрүүдийн төгсөлтийн дараах мөшгөх судалгааг жил бүр хийж, цаашид бүх төгсөгчдийн мөшгөх судалгааг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэхээр ажиллаж байна. Дээд боловсролын сургалтын байгууллагад насан туршийн боловсрол олгох тогтолцоог төрөөс дэмжин ажиллана.

Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн тухайд Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрмийг 2023 онд шинэчлэн баталж, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай А52 дугаар тушаалаар Зөвлөлийн бүрэлдэхүүн, чиглэл, хөтөлбөрийн жагсаалт, дэд зөвлөл байгуулах шаардлага хангасан их сургууль, хөтөлбөрийн жагсаалтыг тус тус тогтоосон.

Докторын зэрэг хамгаалуулах 39 зөвлөл, докторын зэрэг хамгаалуулах дэд зөвлөл байгуулах шаардлага хангасан 19 сургууль, 180 орчим хөтөлбөр өнөөдөр үйл ажиллагаагаа явуулж байна. Дээд боловсролын тухай хуулийн 23.1-д заасны дагуу эрдэмтдийн нэгдсэн санг Шинжлэх ухаан технологийн сантай хамтран бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна. Дээд боловсролын санхүүжилтийн тухайд төрөөс, төсвөөс дараах дэмжлэгийг үзүүлж байна.

Нэгдүгээрт, тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцагчид олгох сургалт, судалгааны тэтгэлэг нийтдээ 9.6 тэрбум төгрөг, төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардал нийтдээ 13 тэрбумыг олгож байна. Дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ тогтоох ажлыг зохион байгуулсан.

Засгийн газрын шийдвэрээр шинээр байгуулагдсан их, дээд сургуулийн дэргэдэх хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны татаас 1.8 тэрбумыг тус тус олгохоор ажиллаж байна.

Ингээд мэдээлэл өглөө. Та бүхний асуултад хариулахад бэлэн байна. Баярлалаа.

Ч.Ундрам: Сайдын мэдээлэлтэй холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгөөрэй.

Дарж болж байна уу? Эрдэнэбат гишүүнээр тасалъя. Рэгдэл гишүүн асуулт асууя.

Д.Рэгдэл: Наранбаяр сайдад баярлалаа. Тэгэхээр өнөөдөр бид нар гол нь энэ Боловсролын тухай багц хуулиас дээд боловсролын салбарыг нь онцолж авч танилцуулга хийж байгаа юм байна гэж ойлголоо. Тэгэхээр энэ дээд боловсролын

шинэчлэлийн хүрээнд өнөөдөр танилцуулж байгаа асуудал дотор хамгийн чухал асуудал нь энэ дарааллын хараад үзэхээр ер нь судалгааны их сургууль байгуулах чиглэл рүү анхаарч байгаа юм байна уу даа гэж ингэж ойлголоо. Тэгээд ч удахгүй дээд, их сургуулиуд, коллеж гэсэн хоёрхон ангилалтай болгох хуулиа хэрэгжүүлэх ийм ажлууд бас хийгдэх гэж байгаа юм байна. Тэгэхээр би 2 асуулттай байгаа юм.

Нэгдүгээрт, энэ дээд боловсролын салбарын хамгийн нэг чухал хэсэг яах аргагүй шинжлэх ухаан эрдэм шинжилгээний ажил мөнөөс мөн байгаа юм. Тэгээд ноднин энэ зөвлөл энэ тэр шинэчлэгдээд энэ 30 хэдэн зөвлөл байгуулагдаад, дэд зөвлөлүүд ажиллаад ингээд яваад байгаа. Тэгэхээр зэрэг үүнийг байгуулахдаа энийг 1 жилийн хугацаатай байгууллаа нөхөд. Тэгэхээр 1 жилийн дараа үзээд энэ журам энэ тэрдээ шинэчлэл оруулаад зөвлөлийн бүрэлдэхүүн энэ тэрээ авч үзнэ гэсэн ийм яриа хөөрөөтэйгөөр хийсэн ажил.

Яагаад вэ гэвэл энэ журам дотор доктор хамгаалах гэж байгаа оюутан бүтээл хэвлүүлэхдээ тухайн сургуулийнхаа нэрийг заавал энэ бүтээл энэ сургуулийн бүтээл гэж оруулж байх ёстой гэдэг нэлээн асуудал дээр маргаан гарсан. Энэ оюуны өмчийн тухай асуудал байгаад байдаг юм. Тэгэхдээ зэрэг одоо энэ жилийн дараа шинэчилнэ гэсэн энэ ажлын хүрээндээ энэ оюуны өмчийн маргаантай асуудлыг нэг тийш нь шийдмээр байгаа юм. Яагаад вэ гэвэл оюуны, эрдмийн бүтээл хэвлүүлээд гарч байгаа энэ бүтээл оюуны өмч байдаг. Тэгэхээр тэр докторын зэрэг горилогч оюутны оюуны өмчийг хамгаалуулах эрх авсан сургууль нь манай дээр бүртгэ гэж шаардах бол оюуны өмчийн зөрчил үүсгэнэ. Тэгэхээр зэрэг энэ тал дээр ер нь ямар ажил хийе гэж ингэж бодож байгаа юм бэ гэдэг ийм асуулт байна.

Хоёрдугаарт, ер нь энэ дээд боловсролын шинэчлэл гээд ярихтайгаа зэрэг бид нар судалгааны их сургууль гэж шинэлэг юм оруулж ирж байна. Нөгөө талаас ерөөсөө энэ дээд боловсролд их сургуулиудын рангийн асуудал, ранкингийн асуудлууд нэлээн яригддаг.

Гэтэл хамгийн чухал асуудал дээд боловсролын олголтын зэрэг, дээд боловсрол олголтын чанарын асуудал манай дээр ерөөсөө яригдахгүй байгаа юм. Энэ дэлхий дээр чинь их сургуулиудын чинь бас улс их сургуулийг байтугай тухайн улсыг дээд боловсрол олголтын зэргээр нь.../минут дуусав./

Ч.Ундрам: Нэмж 1 минут. Рэгдэл гишүүнд 1 минут өгчих.

Д.Рэгдэл: Тэгэхээр манайх бол энэ дээд боловсрол олголтынхоо чанарын асуудал дээр ер нь юу хийж болмоор юм? Ер нь энэ тухай ярих уу, эсвэл нөгөө л ярьдаг юмнуудаа, хуучин юмаа яриад яваад байх уу? Уул нь дээд боловсрол шинжлэх ухаан хоёрыг чинь бол Монголын онцлог гэж ярихаасаа илүүтэй бид нар дэлхийн жишиг рүү л ойртуулах гэж үзээд байвал энэ амжилтад алгуур боловчиг ийм хүрэх асуудлууд. Тэгэхээр дээд боловсролын боловсрол олгох энэ чанарынхаа асуудлыг яаж сайжруулж болох энэ талаар та нөхөд маань юу бодож байдаг юм бэ гэсэн ийм асуулт байна.

Наранбаяр сайд 3 номерын микрофон.

П.Наранбаяр: Рэгдэл гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр үнэхээр энэ оюуны өмчийн асуудал үүсэж байгаа. Тэгээд бид журмаа өөрчлөх ажлын хэсэг гараад явж байгаа. Тэгээд энэ дээрээ яригдаж байгаа зүйл таны хэлсэнчлэн заавал тэр сургуульд нь бүртгүүлэх биш, тэр тухайн хүний оюуны өмч гэдэг утгаар нь хүндэтгэлтэй хандах ёстой гэсэн утгаар энэ заалтыг байхгүй болгох энэ чиглэл рүүгээ явж байгаа гэж танд хэлье.

Хоёрдугаарт нь чанарын асуудал та дурдаж байна. Үнэхээрийн энэ чанарыг дээшлүүлэхэд энэ техникийн зохицуулалтаар нэг бол их сургууль, нэг бол коллеж болно гэсэн ийм юугаар техникийн зохицуулалтыг нэлээн сайн шахаж хийж байгаа. Тэгээд энэ оны 6 сарын 15 гэхэд тийм ээ техникийн зохицуулалтаар энэ ангилал бүрэн явагдаад дуусах, бүртгэлийг нь цэгцлэх ийм ажил явагдаж байгаа.

Энэ их, дээд сургуулийн юун дээр бол Монгол Улсын их сургууль анх удаа дэлхийн Таймс Хайер Эдүкэйшний/Times higher education/ энэ эрэмбээр 1500 дотор орж ирсэн. Энэ бас нэлээн бидний бас хүлээж байсан ийм үр дүн. Цаашдаа бас энэ их, дээд сургуулийн Монголын дотоодын их, дээд сургуулийнхаа эрэмбийг, чансааг тогтооход яг ийм цэвэр хөндлөнгийн байгууллагаар хийлгэх ийм ажлыг Боловсролын яам гардан зохион байгуулна гэж. Энэ бас чанарт бас нөлөөлөх ийм сайн нөлөөлөл гэж харж байгаа. Баярлалаа.

Ч.Ундрам: Бум-Очир гишүүн асуулт асууя.

Д.Бум-Очир: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Залуучууд маань ер нь Монголд их, дээд сургуульд сурахаасаа илүү гадаадад сурахыг илүүд үздэг болсон. Зүйрлэж хэлбэл энэ юутай адилхан бэ гэхээр эрүүл мэндийн салбарт бас их яригддаг Монголдоо биш гадаадад эмчлүүлэх гээд явчихдагтай төстэй зүйл юм байгаа юм. Төстэй зүйл. Монголд байгаа сургуулиудаа голоод байна гэсэн үг. Яах вэ дэлхийн шилдэг сургуулиуд байгаа. Их, бага хэмжээгээр манай сургуулиуд гологддог байх.

Гэхдээ гологдмооргүй байна. Хэзээнээс гологдохоо болих юм? Бид бол ийм асуудлыг яриад байдаг шүү дээ. Энэ гадагшаа чиглэсэн иргэд эмчлүүлэхээр явж байгаа урсгалыг дотооддоо авч үлдье. Мөнгө санхүүгийн хувьд ч гэсэн, боловсон хүчний хувьд ч гэсэн энэ салбаруудаа дэмжиж, дэлхийн олон улсын жишигт хүргэх талаар авах арга хэмжээнүүдийг бодож үзэх хэрэгтэй байна гэдэг. Яг үүнтэй адилхан бид дотооддоо дэлхийн хэмжээнд боловсрол эзэмшүүлдэг, дээд боловсролыг эзэмшүүлдэг болох шаардлагатай байгаа. Сургуулиуд маань олон улсын дэлхийн жишгийн сургуулиуд болох хэрэгтэй байна.

Тэгэхгүй бол үндсэндээ Монголын их, дээд сургуулиудаа алгасаад шууд гадаадад явчихдаг ийм зүйл маш түгээмэл болсон. Энгийн болсон. Энэ нь байх ёстой зүйл юм шигээр бид нар ханддаг болсон. Ийм байх ёсгүй шүү. Монголын сургуулиуд өнөөдөр дэлхийн жишгийн сургуулиудтай өрсөлддөг байх. Залуучууд маань Монголдоо сурч эзэмшсэнээрээ, дээд боловсрол эзэмшсэнээрээ бахархдаг байх ёстой юм гэдгийг нэгд хэлмээр байгаа юм. Энэ ойлголтыг бид нар хэзээ, яаж бий болгох юм бэ? Дараагийн нэг зүйл юу вэ гэхээр энэ дээд боловсролыг, их сургуулиудыг шинжлэх ухаан гэж ерөөсөө харахгүй юм. Шинжлэх ухааны байгууллага гэж ерөөсөө харахгүй юм. Үүний нэг тодорхой жишээ сая тэр Эдийн засаг, хөгжлийн яаманд шинжлэх ухааныг салгаад аваачиж байгаа байдал шүү дээ. Тэгээд их сургуулиудыг Боловсролын яаман дээр нь үлдээсэн. Тэгээд их

сургууль чинь гол нь нэг талаасаа боловсрол, нөгөө талаасаа шинжлэх ухаан шүү дээ. Энийг бид нар бүгдээрээ мэдэж байгаа.

Гэтэл шинжлэх ухаан гэдгийг нь бид нар харахгүй хаячхаад байдаг. Шинжлэх ухаан гэхээр зөвхөн Шинжлэх ухааны академийг гэж ойлгоод байдаг. Энэ маш буруу. Маш ийм түгээмэл ойлголт байна. Энэ 2 хандлагаас бид нар салах хэрэгтэй байна. Дотооддоо сургадаг байх, их сургуулийг шинжлэх ухаан гэж хардаг байх.

Ингээд би 3 зүйлийг асууж тодруулмаар байна. Би 1 минутаа бас авчихъя даа. Нэгдүгээрт, энэ миний ойлгож байгаагаар багшийн хомсдолд орсон олон шалтгаан байгаа. Тэрний нэг нь их төрийн өмчит их, дээд сургуулиуд дээр багш бэлтгэж байсан тэр тогтолцоог үндсэндээ халаад, тэгээд жишээ нь Монгол Улсын их сургууль дээр ч юм уу нийгмийн ухаанаар ч юм уу, түүхээр сурлаа гэхэд дахиж багшийн хэдэн сарын чинь дамжаанд сураад багш болох тусгай үнэмлэх авч байж багшилдаг болсон. Үүнээс болоод тухайн цагт бөөн асуудал гарсан.

Тэгэхээр одоо эргээд яамаар байна вэ гэхээр төрийн өмчит их, дээд сургуулиуд маань багш бэлддэг болмоор байна, багшийн ангиудаа нэммээр байна. Энд бусад төрийн өмчит их, дээд сургуулиудын удирдлагууд ирсэн байна. Тэр индекс тэр юмнуудаа аваад багш бэлтгэх энэ үйл хэрэгт хүчин зүтгэмээр байна. Энэ бололцоо, эрх зүйг нь яам хангаж өгөх хэрэгтэй байна. Нэгдүгээр зүйл. Энэ ажил хэр явж байгаа вэ?

Дараагийн зүйл болохоор юу вэ гэхээр энэ төрийн өмчит их, дээд сургуулиудыг нэгтгэнэ гээд хэсэг бужигнасан. Энэ юу болсон бэ? Нэгтгэж чадах юм уу? Чадахгүй юм бол болиод өөр алхам руу орвол яасан юм бэ? Энэ тал дээр хариулт өгөхгүй юу.

Ч.Ундрам: 1 минутаа нэмж авах уу? Дараа нь тодруулах юм уу? Наранбаяр сайд хариульъя 3 номер.

П.Наранбаяр: Тэгэхээр Бум-Очир гишүүний яг хэлсэнчлэн үнэн л дээ. Бакалаврын түвшиндээ Монголдоо бэлтгэгдээд, хэрвээ гадаадад сурах шаардлагатай бол магистр, доктортоо очиж сурвал хамгийн хамгийн зөв ийм хэлбэр гэж харж байгаа. Тэгээд Боловсролын зээлийн сангаас зөвхөн бакалаврын түвшинд зээл олгож байгаа. Магистр, докторт сурч байгаад буцалтгүй тусламж буюу тэтгэлэг шууд олгоод явж байгаа юм. Энэ бодлогын үзүүр нь ингэж.

Нөгөө талдаа ер нь Боловсролын зээлийн сангаар гадагшийгаа сурч байгаа оюутнуудыг ингээд харах юм бол Ерөнхийлөгчийн илгээлт энэ нь илүү голлож байгаа. Ер нь бид бас энэ их, дээд сургуулиудаа оюутнуудад, залуучуудад илүү сайн ингэж түлхүү мэдээллэх ийм шаардлагатай юм байна лээ л дээ. Механик тээврийн сургууль дээр би ШУТИС дээр яваад очсон. Тэнд жишээлбэл Боингийн яг ингээд нислэг үйлддэг яг ийм юу гэдэг юм тэр чинь ийм бүхээг, симуляц нь байж байгаа юм. Энэ яг энэ бүс нутагтаа 5000 км дотор ганцхан манайд л байгаа гэж ярьж байгаа.

Тэгэхээр энэ дээр ингээд гадагшийгаа нисгэгчээр сурах биш энд ингээд сурах юм бол хамаагүй хямд төлбөрөөр чанартай сургалт хийх бүрэн боломжтой болчихсон. Тэнд тоёотагийн төв ч байна гэх мэтээр ингээд бас энэ мэргэжлийн сургуулиуд ч гэсэн сүүлийн үед их хүчтэй хөгжиж ирж байна. Тэгэхээр энэ элсэлт

тал дээр нь бас энэ их, дээд сургуулиудтайгаа яам өөрөө хамтраад бас энэ бакалавраа энэ дотооддоо бэлдэх дээр онцгой анхаарах шаардлагатай юм байна гэж харсан.

Тэгэхээр их, дээд сургуулиудыг ер нь сургалтын сургуулиасаа судалгааны сургууль, судалгаанаасаа инновацын сургууль гэж харахад цаашдаа бас энэ профессоруудын бие даасан байдал их, дээд сургуулийн академик эрх чөлөө энэ бол маш чухал юм байна гэж харсан. Багшийн хомсдолын тухайд өнөөдөр МУИС дээр бусад төрийн өмчийн сургуулиуд дээр хос мэргэжлээр багшийг бэлдэж гаргаж байгаа. Энэ тал дээр бас манай МУИС-аас бас ректор нь ирсэн байна. Очирхуяг захирал тодруулаад хэлээрэй.

Төрийн өмчийн сургуулиудыг яг нэгтгэх бодлого байхгүй. Дундын менежментийн зөвлөл гэж байдаг. Тэгээд Удирдах зөвлөлд түүнээс гадна бас хөрөнгийг нь бас дундын менежмент хийж лаборатори эд нарыг дундаа ашиглах иймэрхүү зүйлүүдийг хийж байгаа тал бий. Ер нь төрийн өмчийн сургуулиуд хоорондоо өрсөлдөж ингэж явж байж л илүү сайн болно. Тэрнээс биш Монгол Улс даяар ганцхан сургуультай болчихсон гэдгийг ийм утопи юм байж болохгүй. Хоорондоо өрсөлдөж, хоорондоо өөр өөрийн онцлог, соёлоо хадгалж ингэж явна. МУИС-ийн төгсөгч нэг өөр, МУБИС-ийн төгсөгч бас их өөр. Ингээд ийм өөрийн гэсэн соёлтой ийм байдаг гэж би боддог. Тэгэхээр зэрэг ийм бодлого байхгүй гэдгийг хариуцлагатайгаар хэлье. Очирхуяг захирал.

Ч.Ундрам: Очирхуяг захирал 5 номер дээр суучих.

Б.Очирхуяг: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын их сургуулийн хувьд нийтдээ 8 мэргэжлээр багшийн хөтөлбөр бэлдэж байгаа. Уламжлалт 4 жилийн хөтөлбөрөөс гадна саяхнаас эхэлсэн байгаа 45 хоногоор бид нар 2 дахь бакалавр буюу 2 дахь багшлах эрхийн курсүүд эхэлчихсэн байгаа. Энийг албан ёсоор Боловсролын хүрээлэнгээс хөтөлбөрөө батлуулаад энэ сургалтуудыг нийтэд зарлаад процесс нь эхэлчихсэн байгаа. Яг энэ процесс бараг төрийн өмчийн сургуулиудаар бүгдэд нь явагдаж байгаа учраас харьцангуй багшийн орон тоо нэмэгдэнэ гэж найдаж байгаа. Тийм.

Ч.Ундрам: Яг ямар 8 мэргэжлээр багшилж байна?

Б.Очирхуяг: Байгалийн ухааны 5 байгаа. Физик, хими, биологи, газар зүй, математик, нийгэм, түүх, Англи хэлний багш гэсэн ийм 5 байгаа, 8 байгаа. Тийм. Баярлалаа.

Ч.Ундрам: Бум-Очир гишүүн нэмж асууя.

Д.Бум-Очир: Бусад төрийн өмчийн их, дээд сургуулиуд маань багш бэлдэж байгаа юу? Анагаах бэлдэж байгаа юу? Анагаах жишээ нь магадгүй биологийн чиглэлээр ч юм уу, биологийн багш магш их дутмаг байдаг. Энэ дээр бас их сургуулийн ректоруудад хариулж өгөөрэй. Нэгдүгээрт, тодруулмаар байна.

Хоёрт, МУИС-ийн ректор байна, бусад ректорууд ч байна. Суурь шинжлэх ухааны салбарууд элсэлт цөөтэй байдаг. Сая 11 сард манай МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн удирдлага багш нар хэвлэлийн бага хурал хийсэн. 6 тэрбумын ч илүү алдагдалтай байдаг гээд ийм энийг би бас маш тодорхой мэдэж байна. Энэ зовлонгууд бас бусад их сургуулиуд дээр их, бага хэмжээгээр байгаа байх. Бас

сонсогдож байсан. Энэ суурь шинжлэх ухааны салбаруудад оюутан элсэж орж ирэхгүй байсан ч, 1, 2 оюутантай байсан ч энэ салбарыг хэрвээ ирээдүйд бид нар судалгааны их сургууль болно хөгжинө гэвэл авч үлдэх шаардлагатай байдаг. Энэ дээр төрөөс ямар нэгэн дэмжлэг энэ тэр үзүүлэх үү? Яаж энэ их сургуулиудын суурь шинжлэх ухааны хөгжлийг авч үлдэх вэ?

Ч.Ундрам: Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректор биологийн багш ч юм уу, химийн ч юм уу ийм багш танайх бэлдэж байна уу гээд хариулах юм байна. Дамдиндорж ректор 5 номер.

Г.Дамдинням: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Анагаахын хувьд бакалаврын 27 мэргэжлээр элсэлт авч, сургаж байгаа. Яг багш бэлдэхгүй байгаа. Яагаад гэвэл анагаах жишээ нь мэс засал гэдэг юм уу, дотоод шүүрлийн эмч гэдэг юм уу ийм чиглэл дээр байгаа учраас бид өөрсдөө орж байгаа багш нартаа зориулаад 3 сарын кредиттэй сургалтыг Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд дотооддоо яг тэр нарийн мэргэжил дээрээс суурилж бэлдэж явдаг тийм зүйл байгаа. Тэрнээс биш яг биологийн гэдэг юм уу, химийн багш гэдэг зүйл бэлдэхгүй байна.

Ч.Ундрам: Байгалийн ухааны салбарууд алдагдалтай байгаа. Энийг яах ёстой юм бэ гэнэ ээ? Наранбаяр сайд 3 номер.

П.Наранбаяр: Асуултад хариулъя. Байгалийн ухааны салбар дээр үнэхээрийн элсэгч цөөн байдаг. Ерөөсөө квотоо дүүргэдэггүй. Сургуулиудаар яваад очихоор ер нь элсэгч нь их хэцүү гэсэн ийм л юм дүр төрх байгаад байгаа. Тэгэхээр зэрэг ер нь төр талаасаа бид байгалийн ухааныг тэргүүлэх ийм мэргэжлийн эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн чиглэлд оруулсан байдаг. Тэгээд энэ чиглэлээр оюутан болж элсэж орж ирвэл зээл, мөн буцалтгүй тусламж буюу тэтгэлэг бас олгож байгаа. Мөн төрийн өмчийн сургуулиудын тогтмол зардал нийтдээ 13 тэрбум төгрөгийг ингээд хуваарилж өгсөн явдал бас энэ төрийн өмчийн сургуулиуд элсэлтээ нэмэгдүүлэх энэ тал дээр бас хөрөнгө оруулах ийм боломжийг бий болгож байна гэж харж байгаа.

Цаашдаа бас Монгол Улсын Ерөнхий сайд бас Монгол Улсын их сургууль юм уу, ШУТИС дээр очиж ажиллаж яг байгалийн ухааны чиглэлээр суралцаж байгаа хүмүүсийг дэмжих тодорхой бас бодлогоо.../минут дуусав./

Ч.Ундрам: Хариултаа гүйцээчих 3 номерт.

П.Наранбаяр: Ийм бодлогыг зарлана гэж байгаа. Тэгэхээр нэг дорвитойхон хөтөлбөр, төслийг бас бэлдэх шаардлагатай юм болов уу гэж бодож байна. Тийм. Галбадрах гишүүн яриад байдаг мега төсөл гэдэг шиг энэ дээр байгалийн ухааны чиглэлээр үндсэндээ энэ цаашдын энэ ирээдүйг авч явах, энэ улс орны хөгжлийг авч явах инженерүүдийг бэлдэх чиглэл дээр бид ингэж анхаарч ажиллана.

Монгол Германы хамтарсан инженерийн сургууль байна. Хөшигийн хөндийд Олон улсын инженерийн сургуулийг Хятадын талтай хамтран байгуулахаар ингээд явж байна. Энэ ингээд сургуулиуд үйл ажиллагаа нь жигдрээд ингээд ирэх юм бол байгалийн ухаанаар мэргэших ийм хүмүүс олон болно. Гагцхүү бид ерөнхий боловсрол дотроо байгалийн ухааны сургалтыг чанаржуулах, хүүхдүүдэд

карьерын, мэргэжил сонголтын ийм чигийг 9 дүгээр анги дээр нь өгдөг байх ийм шаардлагатай байгаа. Энэ 9 дүгээр ангид нь өгдөг энэ ажил эхэлж байгаа.

Ч.Ундрам: Энэ байгалийн ухааны мэргэжлээр хүүхдүүд мэргэжлийг сонгохгүй байгаа учир нь 10 жилд ЕБС-даа байгалийн ухааны хичээлийг ойлгохгүй. Тэрнээс болоод дургүй болчихоод байгаа шүү дээ. Тэгээд ойлгохгүй байгаа нэг шалтгаан нь лаборатори байхгүй. Тэгээд лабораторигүй ангид хими ч юм уу, физик заах үнэхээр багшид нь ч хэцүү, хүүхэд ч ойлгохгүй. Тэгээд ойлгохгүй юм чинь мэдээж дургүй. Ингээд нийгэм, хүмүүнлэгийн чиглэлийн мэргэжилдээ илүү дуртай, сонирхолтой болоод тэгээд тэр хичээлүүдийг сонгоод, улмаар тийм мэргэжил сонгоод яваад байгаа.

Тэгэхээр ерөнхий боловсролын сургуулиудыг зайлшгүй бүгдийг нь лабораторитой болгох асуудлыг бид нар шийдэхгүй бол цаашид байгалийн ухааны багш нар ч байхгүй болно. Ингээд нөгөө тахиа анхдагч уу, өндөг анхдагч уу гэдэг шиг энэ чинь хоёулаа хоорондоо ийм холбоотой зүйл байгаа. Тэгэхээр мэргэжлийн чиг баримжаа өгнө гэдэг нь мэдээж хэрэгтэй ажил. Гэхдээ энэ лабораторижуулах ажил үнэхээр чухал шүү. Тэгээд Наранбаяр сайд би танд шпос-ын уралдаан, тэмцээн явуулах ёстой гэдгийг бас хэлээд байгаа тээ? Угаасаа хийгээд явж байгаа байгууллагууд төрийн бус байгууллагууд байгаа юм байна лээ. Дэмжээд л, хамтраад өгөхөд л өөрсдөө хийгээд явчих ийм газрууд байгаа шүү. Энийг сайн анхаараасай гэж хүсэж байна.

Дараагийн асуултыг Галбадрах гишүүн асууя.

Ж.Галбадрах: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Өнөөдөр бид нар маш чухал асуудал ярьж байна.

Монгол Улс маань угаасаа хүний нөөцийн дутагдалд орчихсон. Бүүр ялангуяа ийм нарийн мэргэжлийн багш, эмчээс эхлээд, инженерүүд гэсэн энэ мэргэжил дээр үнэхээр хүний дутагдалд орчихсон хүний нөөцийн. Хүмүүс маань сая Бум-Очир гишүүний хэлсэнчлэн ингээд гадаадад сурахаар явдаг. Тэгээд тэр чигтээ эргэж ирдэггүй нэг ийм байдал бий болоод байна. Энэ нь манай энэ үндэсний дотоодын их, дээд сургуулиудын маань чанартай үнэхээр холбоотой. Тэгэхээр та бүхэн үнэхээр сургалтынх нь чанарын асуудлын маш тодорхой зорилготойгоор, бүүр хэмжихүйц зүйлээр ингээд хийх шаардлагатай байна. Одоо их сургууль маань судалгааны их сургууль, сургалтын их сургууль, интерпренер их сургууль гээд байдаг. Тэгээд одоо манай сургуулиуд маань судалгааны их сургуулийг зорино гэж байна.

Тэгээд тэрний өмнө энэ сургалтын их сургууль гэдэг энэ чанар дээрээ их анхаарна. Судалгааны их сургууль эд нар судалгааны их сургууль болоход бас олон нөхцөл шаардлагууд байгаа. Энийг тодруулаад хэлээд өгөөч Ариунболд даргаас бас асууя. Яг судалгааны их сургууль гэдэг дээр сургалтын их сургуулиас шилжиж ороход ямар шаардлагыг хангасан байхаар үзээд байна? Тэнд профессорын баг гээд л байна. Тэрийг ямар дэмждэг юм, ямар судалгаанууд хийдэг юм, лаборатори эд нарын хангамж нь ямар байх юм гэдгийг талаас хэлж өгөөч.

Тэгээд дээд сургууль гэдэг статус байхгүй болж байгаа. Энийг яг хэдэн онд зөндөө л дээд сургууль байгаа. Энэ дээд сургуулиудыг коллеж юм уу, их сургууль болгоно гэж байгаа. Энэ их сургууль болгох, коллеж болгох энэ процесс яаж

байна? Жишээлбэл, СЭЗДС дээр Гурван-Эрдэнэ гээд багшийн сургууль ороод л энэ 2 маань ингээд нийлээд ийм их сургууль болсон гэсэн. Ийм механик нэгдэл яваад байх юм. Энэ тэгээд зөв юм уу? Түрүүн Наранбаяр сайд хэлж байна энэ өрсөлдөөн л байх ёстой гэж байна. Өрсөлдөөнийг яг ямар шалгуураар юунаас гаргаж ирж байна? Манайх чинь ингээд мэргэшсэн ШУТИС гэхэд л төрийн сургууль нэг байж байна гэж байна. Тэгвэл энэ сургуулийн өрсөлдөөнийг нь бодитоор бий болгохын тулд ямар арга хэмжээнүүд, яах ёстой юм бэ?

Хамгийн гол нь төгсөгчдийн мөшгөх судалгааны талаар сая хэлж байна. Энэ мөшгөх судалгааг маш сайн хийх ёстой. Би сая МУБИС-ийн ректор орж ирж байна. Энэ дээр бид нар МУБИС-аас юу авсан юм л даа судалгаа авсан. Тооцоог нь авсан. Тэгэхэд манай төгсөгчид 70 хэдэн хувьтай ажлын байран дээр очиж байгаа, багш хийж байгаа л гээд байгаа юм. Би яг ингээд нарийвчлаад тэрнийх нь дараа бүх яг төгссөн хүүхдүүдээр нь одоо яг ажиллаж байгааг нь бүгдийг нь ингээд судалгаа үзэхэд өнгөрсөн жилийнх ердөө л 26 хувьтай л багш болсон байна лээ шүү. Өмнөх жил 44 хувьтай. Энэ судалгаагаа бид нар тулгаж үзэх ёстой байна. Энд би бас 1 минутаа нэмээд авъя.

Ч.Ундрэм: 1 минут нэмье.

Ж.Галбадрах: Хөдөө аж ахуйн их сургууль, Анагаахын их сургууль дээр ч гэсэн ерөөсөө ялгаагүй. Энэ нарийн энэ мэргэжлийн Хөдөө аж ахуйн их сургууль бүр орон нутагт маш их дутаж байгаа. Энэ судалгаагаа хэр их хийдэг юм бэ? Ер нь хэдэн хувьтай яг ажил дээрээ очдог юм элсэлт нь ямар байгаа гэдгийг Хөдөө аж ахуйн их сургуулиас асууя.

Тэгээд бид нар бас хяналтын тоо гэж байгаа шүү. Тэдэн багш дутаж байна гээд байдаг. Математикийн багш тэд, байгалийн ухааны багш тэд дутуу гэж байгаа бол тийм багшийг тэдэн онд гаргахын тулд 4 жилийн дараа дутагдах багшийн тоо нь гарч ирээд мастер төлөвлөгөөгөөр гарчхаад байгаа бол тэр тоогоо барьсан 100 багш хэрэгтэй гэвэл 150 хүүхэд элсүүлж аваад. Тэрнээсээ замдаа 20, 30 нь төгсөж чадахгүй болоод, төгсөж гарсны дараа бас 20, 30 нь багшийнхаа ажлыг хийсэнгүй гэдэг тооцооллоор 100 багшаа хүргэнэ гэдэг юман дээр энэ дээр их хариуцлагатай ингэж хандаж элсэлт авдаг байх ёстой.

Өөрөөр хэлбэл, хяналтын тоогоо маш сайн барих ёстой. Энэ тал дээр ямар төлөвлөгөө байдаг юм бэ гэдгийг бас нэмж асууя.

Ч.Ундрэм: Хэн хариулт өгөх вэ? 2 номер Ариунболд дарга.

Ж.Ариунболд: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Би 2 үндсэн асуултад хариулъя гэж бодож байна. Нэгдүгээрт, нь судалгааны их сургуультай холбоотой асуудал байгаа. Дэлхий нийтийн түвшинд энэ судалгааны их сургууль гэдэг бол улс орны хөгжлийн түвшнийг авч явдаг, улс орныг чирч явдаг хамгийн гол ийм оюуны байгууллага байдаг. Ингээд та бүхэн мэдэж байгаа байх АНУ нийтдээ 5200 сургуультай. Үүнийхээ 200 орчим сургуулийг судалгааны их сургууль болгох ийм зорилго тавьж явсан. БНХАУ 3600 орчим сургууль байгаа. Эндээсээ бас 9 сургуулийг ингээд Судалгааны их сургууль болгоё гэдэг ийм зорилгыг дэвшүүлээд явсан байгаа.

Яг үүнтэй уялдаад Монгол Улс 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр энэ Боловсролын багц хуульдаа Судалгааны их сургууль гэдэг нэр томъёог бас оруулсан. Энэ хүрээнд 2 үндсэн ажлыг бол хийж байна. Эхний ажил нь бол 2023 оны 7 сарын 7-нд батлагдсан Хуулийг дагаж гарах журмын тухай хууль дээр дээд сургуулийг их сургууль, эсвэл коллеж болох эхний ангиллын хийж байна. Үүний дараагаар их сургууль болсон одоогоор 34 их сургууль байна. Энэ 34 их сургууль дээрээ бас 30 орчим дээд сургууль байгаа. Энэний тодорхой хэсгүүд нь их сургууль дээр орохоор, түүний дараагаар их сургуулиудыг бид нар сургалтын, судалгааны, мэргэжлийн гэж 3 түвшинд бас ангилах энэ ажил хийгдэх ийм үндсэн процесс явагдаж байна.

Судалгааны их сургууль дээр таны асуусан яг гол зүйл нь юу юм бэ? Гол хамгийн гол зүйл нь энэ төрөөс олгодог санхүүжилт. Судалгааны их сургуулиудын дэлхий нийтэд судалгааны их сургуулийг бий болгоход нийт орлогын нөгөө 70-90 хувийг төр өөрөө дэмжиж байж судалгааны их сургуулийг бий болгож чаддаг гол зүйл нь энэ.

Ч.Ундрам: МУБИС-тай холбоотой асуултад Монгол Улсын боловсролын их сургуулийн ректор Батбаатар хариу өгнө. Дараа нь Хөдөө аж ахуйн их сургууль хариу өгнө. 5 номерын микрофоныг өгөөрэй.

Ж.Батбаатар: МУБИС-тай холбоотой асуултад хариулъя. Мөшгөх судалгаа бол манай сургууль жил бүр хийдэг. Тэгэхдээ мөшгөх судалгаанд төгсөгчдийг хамруулахад бол хамгийн төвөгтэй байдаг. Судалгаа янз бүрийн ангийн багш, групп, төгсөгчдийн групп олон зүйлийг олон хэрэглэгдэхүүнүүдийг ашиглаад мөшгөх судалгааг хийдэг боловч нөгөө асуултад хариулахдаа бол маш хойрго байдаг.

Тийм учраас бид нар жилд төгсөгчдийн 30-40 хувийг хамруулаад тэгээд судалгаа хийдэг. Энэ судалгаагаар дунджаар 78-80 хувьтай багш мэргэжлээрээ ажиллаж байна гэсэн ийм судалгаа гардаг ийм дүнтэй байгаа.

Ч.Ундрам: Багш хөтөлбөрөөр сурч байгаа хүүхдүүд чинь тэтгэлэг авч байгаа тээ Боловсролын зээлийн сангаас? Авч байгаа. Тэгэхээр тэр гэрээн дээр заавал татвар төлөгчдийн мөнгөөр сурч байгаа учраас эргээд багшаар тэдэн жил ажиллаж байж энэ өрнөөсөө сална гэсэн ийм заалт байгаа юу?

Ж.Батбаатар: Байгаа. Нийслэлд бол 5 жил, хөдөө орон нутаг.../минут дуусав./

Ч.Ундрам: Нийслэл 5 жил, хөдөө орон нутагт 3 жил ажиллаж байж Боловсролын зээлийн сангаар сурсан тэтгэлгийнхээ үүрэг, хариуцлагаас мултарна гэсэн үг байх нь байна шүү дээ. Тэгэхээр энэ заалтын дагуу хүүхдүүд чинь бүгдээрээ багш болох ёстой байх нь байна шүү дээ төгсөөд? 5 номерын микрофон. Энэ микрофон дээр ярьж байж протоколд үлдэнэ.

Ж.Батбаатар: Өнгөрсөн жилийн шинэчилсэн гэрээгээр бол саяын 3 жил, 5 жил гэдгийг тусгасан. Энэ хичээлийн жилээс бол 2700 хүүхэд бол энэ гэрээг байгуулсан байгаа суралцагчдаас, багш мэргэжлээр суралцагчдаас.

Ч.Ундрам: Тэгэхээр энэ тэтгэлэг бас Боловсролын их сургуулийг бас дэмжиж байгаа нэг хэлбэр шүү дээ. Оюутнуудыг дэмжиж байна, бас танай

сургуулийг. Тэгэхээр эргээд та хэд хариуцлагатайгаар хүүхдүүдээ ажлын байранд зуучлах, араас нь мөшгөх, төгсөгчтэйгөө холбоо харилцаатай байх ийм үүргийг давхар хүлээгээд явах ёстой шүү гэдгийг хэлмээр байна.

Хөдөө аж ахуйн их сургууль Баасансүх ректор хариулт өгье. 5 номерын микрофоныг өгье.

Б.Баасансүх: Хөдөө аж ахуйн салбарт сүүлийн жилүүдэд мэргэжилтний эрэлт хэрэгцээ маш их дутмаг байгаа. Өнгөрсөн жил бид нар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хөдөө аж ахуйн салбарт дутагдаж байгаа мэргэжилтний хэр хэрэгцээ, өнөөгийн хангамж, цаашдын дэвшүүлэх зорилтын тухай бид нар ярилцаад бас ажлын хэсэг байгуулаад ажилласан. Ингээд өнөөдөр хөдөө аж ахуйн салбар дээр дутагдаж байгаа гол мэргэжлийн хэрэгцээг тодорхойлоход өнөөдөр бол яг орон нутагт ажиллах мэргэжлийн хэрэгцээний 25 хувь нь л мэргэжлийн ажиллах хүчнээр хангагдсан байна гэсэн дүгнэлт гарсан.

Ингээд сүүлийн жилүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгч болон төр засгаас хүнс, хөдөө аж ахуйн талаар маш олон урт болон дунд хугацааны хөтөлбөрийг дэвшүүлээд байгаа. Тэр хүрээнд цаашид энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бас мэргэжлийн эрэлт хэрэгцээ дахин нэмэгдэх юм байна гэсэн судалгаануудыг бид нар гаргаад ажиллаж байгаа.

Аймаг, орон нутгийн ЗДТГ-тай орон нутаг, сумдад дутагдаж байгаа мэргэжлийн эрэлт хэрэгцээг бид нар бас хамтран гаргаад ажиллаж байгаа. Одоо Их Хурлын даргын дэргэд хөдөө аж ахуйн үйлдвэрүүдийг дэмжих ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа. Энэ ажлын хэсэгтээ бид нар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт дутагдаж байгаа мэргэжлийн хэрэгцээг тодорхойлох улмаар бид нар бас энэ хэрэгцээг хангах үндэсний хөтөлбөр боловсруулах чиглэлээр бид нар ажиллаж байгаа.

Ч.Ундрам: Баасансүх ректор оо энэ ХААИС-ийг Дархан, Сэлэнгэ рүү шилжүүлж тэнд байгуулах асуудал Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орчихсон байгаа тийм ээ. Тэгэхээр энэтэй холбоотой төлөвлөгөө, зураг ийм ажлууд ямар түвшинд явж байна? Та ер нь энэ ХААИС-ийг удирдаж явж байгаа ректорын хувьд ямар бодолтой байна?

Б.Баасансүх: Засгийн газрын 23 оны 231 тоот тогтоолын хэрэгжилтийг бид нар хангах зорилгоор бид нар ажлын хэсэг байгуулаад ажиллаж байгаа. Энэ дээр Дархан-Уул аймагт сургуулийг хөдөө аж ахуй, газар тариалан, техникийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх гээд заачихсан байгаа. Бид нар одоо бол манай салбар сургуулиуд Дархан-Уул аймагт байдаг. Мөн политехник коллежууд маань Дархан, Төв аймаг, Сэлэнгэ, Булган аймгуудад газар тариалангийн төв бүс дээр байдаг. Мөн бас холбогдох хүрээлэнгүүд маань бас Дархан-Уул аймагт байдаг.

Бид нар Дархан-Уул аймгийн салбар сургуулийг хөтөлбөрийн давхардлаа арилгах, шаталсан сургалтыг хэрэгжүүлэх, зарим хөтөлбөрүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх ийм бодлогуудыг бид нар одоогоор хэрэгжүүлээд явж байгаа.

Ж.Галбадрах: Хариулт хангалттай юу Галбадрах гишүүн ээ? Тодруулъя Галбадрах гишүүн 1 минут.

Ж.Галбадрах: Тэгээд минут ч хаанаа ч хүрэхгүй л юм байна л даа. Сая судалгааны их сургууль гэхээр тэр Америк, Хятадын тухай яриад байна. Одоо яг манай Монголд яах юм бэ? Судалгааны их сургууль болъё тэнд 70-80 хувийг нь санхүүжүүлж дэмждэг гээд байгаа бол манайд яг бодит байдал ямар байгаа юм гэдгийг би Ариунболд даргаас сонсох гээд байна л даа.

Тэгэхээр хэдүүлээ ийм болж байгаа, бүтэж байгаа юм шиг ярихаасаа илүү болохгүй, судалгааны их сургууль зорьж байгаа яг төрөөс ийм дэмжлэгүүд, ийм юм хэрэгтэй байна гэдэг асуудлуудаа бас та бүхнийг аль ч сургуулиуд ингээд тавиасай гэж бодоод байна. Тэгээд бид нар төрөөс энэ үнэхээр л энэ дээд боловсролоо бодитоор дэмжих ёстой. Зөвхөн төлбөрөөр амьдарцгаагаад тэгээд юмаа хийе гэхээр засвараа ч хийж чадахгүй юун засвараа хийж чадахгүй байгаа сургууль ч энэ тэр шинэлэг лабораториуд хийгээд цаашаа явна гэсэн ийм боломж муутай байгаа. Тэгэхээр бүгдээрээ ингээд та бүхэн маань яг бодит байдлаа хараад яг авах арга хэмжээнийхээ талаар саналуудаа тодорхой хэлбэл бас дэмжээд явъя л гэсэн ийм зүйлийг хэлье. Хариуцлагын тогтолцоо сайж.../минут дуусав./

Ч.Ундрам: Эхлээд их сургуулиуд саналаа хэлчих. Тэгээд дараа нь Ариунболд дарга хэлье. Баасансүх ректороос эхэлчих.

Б.Баасансүх: Судалгааны их сургууль болохын тулд бид нар зайлшгүй өөрийн материаллаг орчин, материаллаг бааз, мэргэжлийн багш нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай байгаа. Мөн бид нар дундын лабораториудыг бий болгох, хамтарсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хамтарсан агшин түвшнүүдийг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх мөн сая Засгийн газрын тогтоолоор манай 4 хүрээлэн маань Эдийн засаг, хөгжлийн яам руу шилжсэн байгаа.

Ер нь судалгааны их сургууль болохын тулд зайлшгүй бид нар дэргэдээ бас эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгүүдтэй байх ёстой. Тэгэхээр сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, үйлдвэрлэлийн цогцолбор болохын тулд бид нар бас дэргэдээ бас судалгааны төв, хүрээлэнгүүдтэй байх ийм бодлогыг бариад ажиллаж байна.

Ч.Ундрам: Очирхуяг ректор Монгол Улсын их сургууль 5 номерт.

Б.Очирхуяг: Судалгааны их сургууль гэдэг их сургуулийн гол хэв шинж бол судалгаанд зарцуулж байгаа орлогын хувь гол чухал байдаг. Яг өнөөдөр МУИС-д судалгааны орлого нийт орлогын 10 орчим хувьтай байгаа. Засгийн газрын баталчихсан байгаа 24 оны 6 сарын техникийн зохицуулалтаар судалгааны шинжтэй их сургуулиудын судалгааны орлого 30-аас багагүй байж байж энэ шинж рүү орно гэсэн ийм байдалтай журам баталчихсан.

Тэгээд өнөөдөртөө бид нар энэ өөрсдөө хөөцөлдөөд яваад жилдээ 10 орчим тэрбумыг л судалгаагаар олж байна. Энэ харьцангуй бага тоо. Дээд боловсролын хууль дээр 32.2 дээр байгаа. 32.2 дугаар бүлэг тэр чигтээ төсвөөс төрийн өмчийн байгууллагуудыг дэмжих зардлын ангиллыг тавьсан байдаг. Энэний 32.2.2 дээр ялангуяа судалгааны захиалгат ажлууд, инновац болон технологийн ажлуудаар төрийн өмчийн дээд боловсролын сургуулиудыг дэмжиж болно гэсэн заалттай. Энэ заалт хэрэгжихгүй байгаа. Энэ заалтыг хэрэгжүүлэх

гэхлээр доор нь 32.7 дээр гүйцэтгэлд суурилж хэрэгжүүлнэ гээд тэр хуулийн заалт нөгөөгөө ороо.../минут дуусав./

Ч.Ундрам: Хариултаа гүйцээчихье. 5 номерт нэмэлт.

Б.Очирхуяг: Тэгэхээр бид нарын хувьд хуулийн заалтаар боломж нь байгаа мөртөө энийгээ хаачаад байдаг ийм асуудлууд байдаг. Тэр утгаараа тэр жишээ нь түрүүний хэлээд байгаа тэр судалгааны ажлыг гүйцэтгэлд нь суурилж байж санхүүжүүлнэ гэж ерөөсөө байх боломжгүй энэ өөрөө. Эхнээс нь бид нар тодорхой ажлуудыг улсын захиалгаар авч ирэх боломж гарч ирвэл энэ ажил нэмэгдэнэ. Тийм учраас юун түрүүнд судалгааны ажлын санхүүжилтээр төрөөс дэмжлэг хүсэж байгаа. Энэ бас бид нар өөрсдөө хөөцөлдөөд нэмэгдэхгүй байна.

Хоёрдугаарт, Шинжлэх ухаан технологийн хууль дээр бас байгаа 18 дугаар заалт дээр нь дээд боловсролын байгууллагуудыг эрдэм шинжилгээний байгууллага гэж батлах, тэрийг хэрэгжүүлэх тухай асуудал үүсчихсэн байгаа. Тэгтэл энийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газар журам гаргаж байж батлах юм байна лээ. Одоо тэр журам нь гараагүй байгаа учраас төрийн өмчийн ямар ч их сургуулиуд өнөөдөр албан ёсны эрдэм шинжилгээний байгууллага гэж батлагдаж чадаагүй байгаа. Тэр утгаараа улсын захиалгат ажлуудыг бас хийх боломж гараагүй байгаа. Тэгээд энэ дээр бас анхаарч өгнө үү гэж хүсэж байна.

Ч.Ундрам: Маш тодорхой санал хэллээ. Энэ Дээд боловсролын тухай хуулийн 32.2-ыг хэрэгжүүлэх, 32.7 нь болохоор гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлнэ гэхчхэн байна. Энэ асуудлыг яаж шийдэх ёстой юм бэ гэдгийг Наранбаяр сайд анхаарах ёстой. Эдийн засаг, хөгжлийн яамны Гантөмөр сайдад Байнгын хорооноос Лхагвасүрэн ахлах аа бичиг явуулаад тэр журмаа хурдан боловсруул гэж үүрэг өгөх ёстой шүү.

Дараагийн Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн хэн нь хэлэх юм? Эрдэнэхүү проектор гэх юм уу, Цолмонбаатар? Эрдэнэхүү, Цолмонбаатар проектор. 5 номер.

Д.Цолмонбаатар: Өглөөний мэнд. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, технологи эрхэлсэн проектор Цолмонбаатар байна. Би товчхон танилцуулъя. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн хувьд бид бүхэн 4 чиглэлээр судалгааны их сургууль болох бэлтгэл ажлаа хангаад явж байна. Үүнд:

Нэгдүгээрт, бодлогын түвшинд Шинжлэх ухаан, технологийн их сургууль ШУТИС 2030 стратеги төлөвлөгөөний 5 тэргүүлэх чиглэлийн 2-ыг нь судалгаанд зориулж тусгайлан гаргасан. Тухайлбал, судалгааны төгөлдөршил, нөгөөдөх нь технологи, инновац, арилжаалалт гэсэн ийм 2 бүлгээр бодлогын түвшинд бодлогын бичиг баримтаа бид нар гаргаад хэрэгжүүлээд явж байна.

Хоёр дахь нь хүний нөөцийн асуудал байна. Хүний нөөцийн асуудал манай Шинжлэх ухаан, технологийн их сургууль дээр Засгийн газрын дэмжлэгээр мянган инженер Японтой хамтарсан төслөөр бид бүхэн сүүлийн жилүүдэд 70 орчим эрдэмтдийг бид нар Японтой хамтарч бэлтгэлээ. Нийтдээ эрдмийн зэрэгтэй эрдэмтдийн тоо 48 хувьд хүрсэн. Ер нь бол бас хүний нөөц.../минут дуусав./

Ч.Ундрам: Хариултаа гүйцээчихье. Товч ярихгүй бол.

Д.Цолмонбаатар: Би товчхон. Дараа нь энэ судалгааны орчин дэмжих орчны хувьд бол лабораторийн бааз нөхцөл манайх бол их сайжирсан. Нийтдээ бол судалгаанд дан суурилсан 33 лаборатори үйл ажиллагаа, мөн судалгааны улсын төсөвт 5 хүрээлэн, 42 судалгааны төв үйл ажиллагаа явуулж байна. Тэгэхээр манай орчин сайн бүрдсэн.

Дөрөв дэх асуудал болохоор энэ санхүүжилтийн хувьд байгаа. Төрийн дэмжлэг. Санхүүжилтийн хувьд бол ер нь нь түрүүн Галбадрах гишүүн хэлээд байгаа их сургуулиудын нөхцөл байдал маш хүнд байгаа. Манай сургуулийн хувьд цалингийн нэмэгдлийг сая 30 хувь нэмлээ. Он гараад дахиад 20 хувь нэмэхээр төлөвлөж байна. Яагаад вэ гэхээр бид хэд энэ сайн эрдэмтдээ энэ боловсролын салбартаа авч үлдэхийн тулд цалинг үнэхээр нэмэхээс өөр аргагүй.

Гэхдээ бид бүхэн төрийн дэмжлэгийг зөвхөн мөнгө гэж харахгүй байгаа. Тухайлбал бид Засгийн газрын бодлогоор хэрэгжүүлж байгаа 14 мега төслийн яг тэргүүлэх чиглэлүүдийн зураг, төсөл.../минут дуусав./

Ч.Ундрам: Ажил өгвөл хийе гэж байна. Мега төсөлтэй холбоотой ялангуяа ажлуудыг хийх боломжтой. Санхүүжилт ерөөсөө гол асуудал байна гэж хэлж байна тээ. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректор Дамдиндорж. 5 номер.

Б.Дамдиндорж: Анагаахын сургуулийн хувьд яах вэ Дээд боловсролын тухай хуульд их сургуулийн эмнэлэг гэдэг ойлголт орж ирсэн. Тэгэхээр сургуулийн хувьд их сургуулийн эмнэлгийн тогтолцоог бий болгох чиглэлд ажиллаж байгаа. Тэгэхээр өнөөдөр 4 эмнэлэгтэй, 2 сувилал байна. Дээрээс нь энэ Засгийн газрын нөгөө бүсчилсэн хөгжлийн хүрээнд Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, тэгээд Архангайд гээд ингээд 4 салбар сургуулиуд дээр үйл ажиллагаанууд явж байгаа. Тэгэхээр мэдээжийн хэрэг санхүүжилт байна.

Хоёрдугаарт, энэ оюутны төлбөрөөс хамааралтай байдлыг бууруулахын тулд анагаахын салбарт энэ их сургуулийн эмнэлгүүдийн санхүүжилтийн асуудлууд, эндээс олж байгаа орлогыг эргээд эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах тэр хууль, эрх зүйн боломжийг нь бас нэлээд сайн олгох асуудлууд байгаа.

Өнөөдөр Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол Япон эмнэлэг байна. Бусад эмнэлгүүд нийтдээ 240 гаруй мянган хүнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа юм. Тэгээд тэр үзүүлж байгаа тодорхой орлогоос эргээд сургуулийн эрдэм шинжилгээ, судалгаа, эмнэл зүйн болон нийгэм.../минут дуусав./

Ч.Ундрам: Хариултаа дуусгая. Товч хариулна шүү.

Б.Дамдиндорж: Нийгмийн эрүүл мэндийн судалгаанд бол тодорхой зарцуулах ийм боломж бүрдэж байгаа. Тэгэхээр хууль, эрх зүйн хүрээндээ болон тодорхой санхүүжилт өгөхөд хүний нөөцийн болон их сургуулийн чадавх ер нь бүрдсэн байгаа гэж хэлж байна.

Ч.Ундрам: Бас л санхүүжилт. Монгол Улсын боловсролын их сургуулийн ректор Батбаатар.

Ж.Батбаатар: Бид нар бол судалгааны их сургууль болох бэлтгэлийг олон улсын их сургуулиудын эрэмбэ, чансаа тогтоодог шалгуурууд болоод судалгааны их сургуулийн шалгуурт баримжаалаад явуулж байгаа. Гэхдээ бол олон улсын жишгээр судалгааны их сургууль байгуулахын тулд эсгүй бол аль их сургуулиа сонгож авч, тодорхой хөрөнгө оруулалт хийж, дэд бүтэц судалгааны дэд бүтэц бүрдүүлж явдаг энэ жишгийг барих, эсгүй бол цоо шинээр их сургууль байгуулаад явуулдаг гэдэг энэ 2 жишгийн аль нэгийг нь сонгож тодорхой хөрөнгө оруулалтууд хийж ажиллах ийм шаардлага байгаа. Тэгэхгүй бол их удаашралтай явна гэсэн ийм бодолтой байна.

Ч.Ундрам: Нэг бол шинээр байгуулах аль сургуулийг сонгож авахгүй бол бүгдийг нь болгох боломжгүй шүү дээ зэрэг.

Сонинтогос ректор Соёл урлагийн их сургууль. Тэгээд болчхож байгаа тээ? 5 номерын микрофон.

Э.Сонинтогос: Сайн байцгаана уу Соёл урлагийн их сургуулийн тухайд бид нар судалгааны их сургууль болох зорилт тавиагүй байгаа. Бид нар мэргэжлийн их сургууль байлгана гэж энэ ангиллын дагуу ийм зорилт тавиад ажиллаад тэгээд энэ дээр бид нар стратеги төлөвлөгөөндөө ингээд оруулчихсан ингээд явж байгаа.

Соёл урлагийн их сургуулийн тухайд хуримтлагдсан асуудал зөндөө байгаа. Манайх бол бусад их сургуулиудыгаа бодвол оюутны төлбөр маш бага, багш нарын цалин энэ хэмжээгээрээ бага байдаг. Тэгээд ер нь бол бид нар яг мэргэжлийн сургууль болох бэлтгэлийн тухайд бол 27, 8-н яг мэргэжлийн том лабораториудыг байгуулаад бэлтгэлээ хангаад явж байгаа.

Гэхдээ манайд энэ хөрөнгө, санхүүгийн асуудалтай холбоотойгоор бид нар тэр эрэмбэд олигтой явж чадахгүй байгаа ийм проблем байна. Тийм учраас эрэмбэд олигтой явж чадахгүй байгаа учраас бид нар тогтмол зардлаа жишээлбэл авч чадахгүй байна шүү дээ. Жишээлбэл Их Хурлын дарга яриад байгаа та ч гэсэн манай дээр очихдоо ярьж байсан хууль давсан журмууд үйлчлээд байна гэж.

Ч.Ундрам: Хариултыг нь дуусгая. Энэ тогтмол зардал хуулиар заавал олгох ёстой шүү. Ямар нэгэн цензургүйгээр. Энийг Наранбаяр сайд аа. Сонинтогос ректор хариултаа дуусгая.

Э.Сонинтогос: Энэ жил манайх ердөө 422 сая төгрөг л тогтмол зардалд хэрэгтэй байна гээд тооцоо манай бүх юм тоолууртай. Тийм учраас бусад их сургуулиудыг бодвол манайд оногддог мөнгө нь бага. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, тэр багш бэлтгэх асуудлыг сая Их Хурлын гишүүд их сонирхож байна манай дээр 4 хөтөлбөрөөр багш бэлддэг. Соёлын яамтай манай хамтарч хийсэн судалгаагаас Соёлын яамны захиалгаар хийсэн судалгаагаар ер нь дуу хөгжмийн багшийн дутагдал 40 хувь мэргэжлийн биш байгаа. Манай дээр дуу хөгжмийн багшийн хөтөлбөр, дүрслэх урлагийн багшийн хөтөлбөр, бүжгийн багшийн хөтөлбөр гээд ийм 3 хөтөлбөрөөр манайх оюутан сургаж байгаа.

Дээр нь нэмээд бид нар энэ 45 хоногийн энэ багш бэлтгэе гэдэг энэ юманд бид нар нэгдээд нэгдэж орохоор хөтөлбөрөө хийчхээд Боловсролын ерөнхий газар Боловсролын хүрээлэн хоёрт 4 хөтөлбөр явуулчхаад хүлээж байгаа. Тийм учраас энэ гараад ирэхээр манайх энд яа нэмэгдэх байх. Дараа ярьсан энэ асуудал энэ монголын их сургуулиудыг бас голоод хүүхдүүд элсэхгүй байна гэж байна шүү дээ. Би үнэндээ бол сүүлийн үед Солонгос, Хятадын их сургуулиуд, Монгол улсын их сургуулиудаас илүүтэйгээр энэ хөдөөгийн боловсролын газрынхантай их нийлж их ажиллаж байна.

Ч.Ундрам: Болсон Сонинтогос ректор. Товчхон ярихгүй бол бүгд үг хэлэх учраас. Ариунболд дарга базаад дүгнэлт хэлчих. 2 номерын микрофон.

Ж.Ариунболд: Ер нь судалгааны их сургууль болоход үндсэн 3 аягүй чухал зүйл бий. Дэлхийн улс орнууд дээр авьяастай хүмүүсийг яаж татах вэ гэдэг асуудал хамгийн чухал.

Хоёр дахь нь Англи хэл дээрх сургалт үндэсний их, дээд сургуулиудын.

Гурав дахь нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн лабораториуд. Энэ 3 зүйлийг бид нар хийж чадсанаараа судалгааны их сургууль болох суурь үндсийг тавина гэж харж байгаа. Энэ хүрээндээ 64 их, дээд сургууль, төрийн өмчийн 6 их, сургууль болон бусад сургууль дээр бид нар юу хийсэн бэ гэхээр техникийн зохицуулалтын дагуу үнэлж үзсэн. Энэ үнэлгээний дагуу бол одоогоор яг техникийн зохицуулалтын дагуу бүх шалгуур, шаардлагыг нь хангаад судалгааны их сургуулийн тэр нөгөө зарчим, нөхцөлийг нь хангаж байгаа сургууль хараахан байхгүй байгаа. Монгол Улсын их сургууль дөхөж очиж байгаа. 2 зүйл дээр дутагдалтай байгаа. Тэрний нь бол нийт олж байгаа орлого нь энэ 30 хувь нь судалгаанаас олно гэдэг энэ зүйл дээр 10 хувьтай явж байгаа ийм зүйл байгаа.

Гурав дахь зүйл нь бид нарын хувьд гол зүйл бий. Түрүүн хэлсэн Шинжлэх ухаан их

Ч.Ундрам: Хариултаа товчхон дуусгая. 2 номер нэмж минут.

Ж.Ариунболд: Шинжлэх ухаан шинжлэх ухаан, их сургууль хоёрыг тусад нь байлгана гэдэг өөрөөр хэлбэл судалгааны их сургууль болоход бас тээгтэй асуудал үүсэх болов уу гэж бодож байна.

Дөрөвдүгээрт нь бид нар бас ахиц гаргасан. Олон улсад үнэлэгддэг энэ Таймс хайр эдукэйшн/Times higher education/ олон улсын байгууллагаар үнэлэгдэхэд 1500 руу, 500 плас/plus/ дээр орж ирсэн. Гэхдээ энийг цааш нь нэмэгдүүлэх зорилгоор бид нар энэ жил бас тодорхой санхүүжилтийг МУИС-д бас дэмжлэг болгож өгсөн байгаа.

Ч.Ундрам: Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

Д.Эрдэнэбат: Энд дандаа нөгөө их төрийн өмчийн их, дээд сургуулиуд байгаад байх шиг байна. Хувийн хэвшлийн бас болон бусад өмчийн сургуулиудад их, дээд сургуулиуд бас байгаа. Тэд нараас бас тодорхой бас мэдээллийг бас сонсмоор байна. Дараагийн удаад.

Хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны судалгаа гаргахад манайд энэ дээд боловсролын хэрэгцээ бас нэлээн их гарсан. Манайх чинь илүүдээд байна энэ тэр гээд л ингээд ярьдаг шүү дээ. Ерөнхийдөө таамгаараа яриад л сэтгэл хөөрлөөр яриад л. Энийг чинь яг судалгаа хийж байгаа байгууллагууд хараад ирэнгүүт Монголд өшөө илүү хүний нөөц хэрэгтэй байна, өшөө илүү тэр боловсрол сургах тийм хэрэгцээ байна гэдэг чинь судалгаагаар гарчихсан. Тэгэхээр манайх бол математик тооны араас хөөцөлдөөд цөөлөх, өөрчлөх, тэрийгээ бараг үр дүн энэ тэр гэж харах гээд явчихвал их буруу тийшээ явчхаж магадгүй юм байна лээ.

Тийм учраас энэ их, дээд сургуулиудыг нэгтгэх, зохион байгуулах, зарим чаддаг зүйлээр энэ улсын дээд сургуулиуд ч гэсэн нийлэх ёстой гэдэг тэр материаллаг баазаа нэгтгэж байгаа. Дан дангаар чадахгүй шүү дээ яг үнэнийг хэлэхэд санхүүжилт гээд л. Бүгд санхүүжилт ярьж байгаа. Энэ тал дээр бас яам ямар бодлого баримталж байгаа вэ гэдгийг бас хармаар байгаа юм.

Хоёрдугаарт, энэ төгсөж байгаа оюутнуудын судалгаа гээд ерөнхийдөө асуулгын аргаар л авдаг л байх л даа. Тэгэхээр энэ тал дээр манай яам энэ төгсөж байгаа төгсөгчдийн хөдөлмөрийн зах зээл дээр нийцэж байгаа нийцлийн судалгаа, энийг хариуцдаг тодорхой бодлого боловсруулдаг ийм зүйлүүдийг бас давхар авч үзэх хэрэгтэй байгаа. Би тэгэхээр Боловсрол, шинжлэх ухааны яам дээр яг энэ төгсөх гэж байгаа хүмүүсийн зах зээлд, хөдөлмөрийн зах зээл дээр нийцэж байгаа нийцлийн асуудлыг судалдаг тийм нэгж, мэргэжилтэн хүн байна уу? Дараа нь багшийн ур чадварын асуудал их чухал. Их, дээд сургууль дээр байгаа энэ багш нарыгаа чадавхжуулах, дэлхийн тийм топ сургуулиуд руу явуулах ийм юм бас би их дутмаг байдаг юм уу гэж бодоод байгаа юм. Улсын ганц, хоёр сургууль дээр ямар байдгийг би мэдэхгүй байна. Тэгэхээр тэр Боловсролын зээлийн сангаас харахад манай энэ чиглэлээр сурсан хүмүүс хэр зэрэг байгаа вэ? Дээрээс нь хүмүүсийг сургаад 3 жил багшилбал болоо, тэгээд тэрнээс цааш өөрөө юугаа бод гээд явчихвал бас энэ цаашаа их явахгүй бас бодлого.

Тийм учраас дараа дараагийн залгамж халаа бодлого, тэр нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх, тэр өөр юу байдаг юм тэр багш нарыг уяж барих гэдэг ийм асуудал их чухал байгаа.

Гол дээд боловсрол элсэгчдийн алдаад байгаа асуудал гадаадын сургуулиуд. Тэгэхээр бид нар өрсөлдөхөөс өөр арга байхгүй. Хятад, Солонгос юу руу яагаад яваад байна гэхээр тэд нар чинь их тэтгэлэг өгч байгаа. Дээрээс нь бас манай тэтгэлгийн дийлэнх санхүүжилт нь гадаад руу яваад байгаа учраас тийшээ мэдээж хүүхдүүд явна. Тийм учраас энэ тал дээр хэр зэрэг харж байгаа вэ?

Дараа нь энэ хөдөө орон нутаг руу бас их, дээд сургуулиудыг шилжүүлнэ гэж байгаа. Тэгээд энэ дээр хэр зэрэг дээд сургуулиуд маань бэлтгэл хэр зэрэг хангаж байгаа юм? Тэр чинь хүний амьдрал баахан дагасан олон хүнээс ингээд дагуулаад явуулна гэж. Тэгэхээр нэлээн олон цаанаа дагах энэ асуудлуудыг шийдэх ёстой байгаа. Тэгээд энэ тал дээр хэр зэрэг итгэл үнэмшилтэй байгаа юм, тулгамдаж байгаа бэрхшээлүүд нь юу байгаа юм?

Ч.Ундрам: Ариунболд дарга хариулья.

Ж.Ариунболд: Нэгдүгээрт, нь их, дээд сургуулиудын хоорондын уялдаа холбоог яаж хангаж байна вэ гэхээр ер нь хөрөнгийн менежментийн төв байгуулагдсан манай яамны дэргэд. Энэ төвөөрөө дамжуулаад их, дээд

сургуулиудын хөрөнгийн нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлыг хийгээд явж байгаа.

Сургалтын үйл ажиллагаа талаасаа бол 2021 оноос эхлээд бид нар кредит солилцох энэ ажлыг хийгээд явж байгаа. Одоо 2025 оноос бүх төрийн өмчийн 6 их сургуулиуд хоорондоо кредитээ солилцох энэ ажлыг бол зайлшгүй хийх ёстой гэсэн ийм чиглэлийн дагуу бид нар явж байна.

Хөдөө орон нутагт шилжүүлэх асуудал дээр бол манай хэн түрүүн бас хариулсан. Баасансүх захирал хариулсан. ХААИС-ийг нүүлгэх гэдэг энэ бодлогын хүрээнд хүнс Хүнс, хөдөө аж ахуйн яамтай бид нар бас удаа дараа уулзаж бас энэ дээр бас маш олон судалгаануудыг хийсэн. Оюутнуудын оюутнууд ихэнх нь бас одоо нүүхгүй гэсэн ийм судалгааны үр дүн гарсан. Багш нар ч гэсэн ХААИС-д багшилдаг ихэнх багш нар бид нар хөдөө орон нутаг явах боломжгүй гэдэг ийм судалгааны үр дүнг бас Баасансүх захирал манай яаман дээр бас танилцуулсан байгаа.

Дэлхийн топ сургуулиудад явуулж байгаа бодлогууд гээд энэ дээр маш том бодлого бол хэрэгжсэн байгаа 2014 оноос ЭМЖИ-д гээд төсөл хэрэгжсэн Монгол Улсад мянган инженерийн. Энэ төслийн хүрээнд бол бараг 600 орчим хүмүүс Японы томоохон их, дээд сургуулиуд дээр зэргийн болон зэргийн бус сургалтад хамрагдлаа. Энэ хүрээнд бас 14 сая долларын 62 томоохон лабораторийг Монгол Улсын их сургууль, ШУТИС дээр бол бий болгож чадсан нь бидний хувьд бас нэлээн том амжилт байсан. Үүнийг бид нар цааш нь 2 дахь үе шатыг нь бас явуулах нь бас манай боловсролын салбарт нэлээн чухал бус ийм хэрэгтэй ийм зүйл тулгамдсан асуудал бас болоод байгаа гэдгийг бас манай ректорууд бас хэлдэг.

Боловсролын зээлийн сангаас явж байгаа нийт хүмүүс ер нь их, дээд сургуулиудаас тодорхой тооны хүмүүс ахисан түвшний сургалтад хамрагддаг. Яг энэ дээр бол нарийн тоо алга. Яг төрийн өмчийн их, дээд сургуулиудаас Боловсролын зээлийн сангаас доктор болон пост докторын түвшинд суралцсан оюутнуудын тоо яг одоогоор надаар алга байна.

Ч.Ундрам: Хөдөлмөрийн зах зээлтэй яаж уялддаг юм бэ? Батжаргал дарга 4 номер.

Х.Батжаргал: Хөдөлмөрийн зах зээлийн асуудал яах аргагүй салбар дундын маш том асуудал. Тэгээд Засгийн газрын 2024-28 оны үйл ажиллагааны хөтөлбөр дээр бас энэ салбар дундын асуудлыг шийдвэрлэхээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам хоорондын энэ дундын их өгөгдөл зүйд тулгуурласан дата баазыг бий болгож, энэ цахим шилжилтийг хийж, нөгөөтээгүүр яг эрэлтэд нийцсэн боловсон хүчин, хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр энэ үр дүнгээ ашиглаж зохион байгуулахаар ажиллаж байгаа.

Үүний нэг том эхлэл ингээд 14 мега төслийн боловсролын салбараас хамаарах хүний нөөц бэлтгэх энэ боловсон хүчний судалгааны том ажил энэ хавар бас эхэлж байна. Мөн том төсөл, мега төслүүдийн ТЭЗҮ боловсруулах ажлууд бас эхэлж байгаа. Үүнтэй зэрэгц үзээд бас энэ ажил явагдаж байгаа. Тэгэхээр үндсэн гол Хөдөлмөрийн яам.../минут дуусав./

Ч.Ундрам: Хариултаа гүйцээе 4 номер.

Х.Батжаргал: Тэгэхээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яамны дундын дата бааз нөгөөтээгүүр зөвхөн их, дээд сургууль биш энэ ажиллах хүчний хөдөлмөрийн зах зээлийн нөөцийг бэлтгэхэд бас мэргэжлийн болон техникийн боловсролын суралцагчдын энэ төгсөгчид бас томоохон байр суурь эзэлдэг байгаа. Тэгэхээр энэ дээр бас хүний нөөцийн шилжилтийн энэ хамтын ажиллагааг 2 яам дундын том судалгааны ажлыг хийж, судалгааны үр дүнд тулгуурласан төлөвлөлтүүдийг хийхээр энэ хавраас эхэлж ажиллаж байна.

Ч.Ундрэм: Судалгааг нь хэн хийж байгаа юм?

Х.Батжаргал: Одоо төсвийг нь хоёр яамны хоёр сайдын багц дээр тавигдаад бусдаар гүйцэтгүүлэх ажил буюу эрдэмтэн судлаачдын баг сонгон шалгаруулж ажиллуулна гэсэн үг.

Ч.Ундрэм: Ийм сонгон шалгаруулалт явах гэж байгаа юм байна тээ? Ер нь энэ Эрдэнэбат гишүүн маш чухал асуулт тавилаа шүү дээ. Бид нар өчнөөн хүүхэд жил болгон төгсгөөд л байдаг. Нөгөөдүүл маань ажлын байран дээр очоод шаардлага хангахгүй байна гээд ажилд авдаггүй. Тэгэхээр манай их, дээд сургуулиуд ч гэсэн хөтөлбөрийн хороо нь, хөтөлбөрийн хороондоо ажил олгогчийн төлөөлөл заавал оруулах ёстой. Оруулаад ямар мэдлэг, чадвартай хүүхэд танайд хэрэгтэй байгаа юм бэ гэдгийг судалсны үндсэн дээр хөтөлбөрөө боловсруулаад ингээд шаардлага хангасан хүүхдүүд гаргахгүй болохоор нэг талдаа ажил олгогч чинь хүн олдохгүй байна, шаардлага хангасан хүн олдохгүй байна гээд байдаг.

Нөгөө талдаа баахан ажлын байргүй, халамж авсан ийм хүмүүс бэлтгэгдээд байгаа. Тэгэхээр энэ дээр яамнаас гадна их сургуулийн ректорууд ч гэсэн маш сайн анхаарах ёстой гэж бодож байна. Элсэгчид их гадаад яваад байна. Энэ тэтгэлгийн бодлогоо яаж явуулах ёстой юм бэ гээд Сийлэгмаа дарга хариулт өгье. 5 номерын микрофон.

О.Сийлэгмаа: Гишүүний асуултад хариулъя. Нийт Боловсролын зээлийн сангаас олгогдсон 24 оны санхүүжилтийн суралцагчийн хувьд 26 хувьд буюу дотоодын суралцагчдад, 13.5, хувийн гадаадад элсэн суралцагчдад санхүүжилт олгосон байгаа. Олгосон санхүүжилтийнхээ хэмжээгээр 50.9 хувийг гадаадад суралцагчдын санхүүжилт ноогдож байгаа. Энэ маань суралцагчдын сургалтын төлбөр болон бусад холбогдох зардлын хэмжээнээс хамаарч олгосон санхүүжилтийн 50.9 хувь нь гадаадад суралцагчид байгаа.

Эрдэнэбат гишүүний асуусан хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой санхүүжилтийн дүнд гэх юм бол Засгийн газрын 24 оны 120 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлээр 4.1-ээр нь Засгийн газрын тэтгэлгээр мэргэжлийн чиглэлийн ахисан түвшний суралцагчдын санхүүжилтийг олгохоор зохицуулсан байгаа. Энэ тохиолдолд тодорхой тулгамдаж байгаа асуудлууд нь мэргэжлийн чиглэлийн ахисан түвшний суралцагчдын судалгааны эх сурвалж зэрэг зардлуудыг нь нарийвчилж тодорхой.../минут дуусав./

Ч.Ундрэм: Хариултаа дуусгая.

О.Сийлэгмаа: Зохицуулах шаардлага байгаа. Энэ талаар Байнгын хорооны ажлын хэсгийн гишүүдэд Зээлийн сан дээр ажиллахад нь хүсэлт уламжилсан байгаа. Засгийн газрын тэтгэлгийн буюу тус журмын 4.2-оор төрийн албан

хаагчийн сургалтын асуудлыг санхүүжилт нь тус зохицуулагдсан байгаа. 25 оноос хэрэгжиж эхлэхээр төсөв тусгагдсан байгаа энэ чиглэлд.

Ч.Ундрам: Хэрлэн гишүүн асуултаа асууя.

Б.Хэрлэн: Бүгдэд нь энэ өглөөний мэнд хүргэе. Тэгэхээр надад 3 асуулт байна.

Нэгдүгээрх нь болохоор энэ Боловсролын ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4-д зааснаар Дээд боловсролын тухай хуулийн гээд нөгөө их, дээд сургуулийг их сургууль эсвэл коллеж болгох шилжилтийн үйл явцыг 6 сарын 15-ны өдрийг хүртэл хэрэгжүүлнэ гэсэн тээ. Тэгэхээр сая энэ дээр Ариунболд дарга ерөнхийдөө энэ яг их сургууль болгоход бас тавигдаж байгаа техникийн шалгуурууд тэрнээс хэдийг нь хангаад, хэд дээр нь асуудал үүсэж байгаа тухайд ингээд түрүүн товчхон хэлж байлаа л даа.

Тэгэхээр энийг яг өнөөдөр их сургууль болгож шилжүүлэхэд зүгээр илэн далангүй ярихад, хамгийн судалгааны санхүүжилт 30 хувь хүрэхгүй байгаа гэдэг бол хамгийн энгийн хэлчих зүйл байх л даа. Өөр өшөө бүүр цаашаа бас яг нөгөө их сургуулийн тэр яг жинхэнэ тэр шалгуурыг хангахад үнэндээ өнөөдөр манай их, дээд сургуулиудад ийм асуудал тулгамдаад байна гэдгийг ингээд чин сэтгэлээсээ хэлэх боломж байна уу? Илэн далангүй хэлэх боломж байна уу гэж би асуумаар байна.

Хоёрдугаарх нь ингээд энэ эрэлттэй болон тэргүүлэх чиглэлийн, тэргүүлэх мэргэжлийн чиглэлийг гаргаад тэгээд энэнийхээ дагуу ер нь сургалт судалгааны тэтгэлэг гээд 9.6 тэрбумыг олгож байгаа гэсэн. Тэгэхээр энэ яг ямар мэргэжлүүд рүү явчхаад байна? Өөрөөр хэлэх юм бол аль их сургууль эндээс арай түлхүү хүрт дөж байна вэ? Энийг асуумаар байна. Энэ дээр тэгээд ерөнхийдөө ер нь их, дээд сургуулиудын чинь үйл ажиллагаа мэдээж хэрэг оюутнуудын төлбөрөөс маш их хэмжээгээр хамаарч байгаа. Тэгэхээр ингээд энэ оюутны төлбөрөөс хамаарч байгаа тохиолдолд багш нарын асуудал, багш нарын ялангуяа багшаа хөгжүүлэх, багшаа бэлтгэх, багшийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх гэдэг асуудал ерөнхийдөө жаахан орхигдоод байдаг тал байдаг болов уу гэж би боддог.

Бас дээр нь сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх тухай асуудал бас 2, 3-д тавигддаг болов уу? Тэр лаборатори, тэр тоног төхөөрөмжийн тухай асуудал хойш нь тавигдчихдаг болов уу? Тэгээд ингээд ирж байгаа тохиолдолд яаж нөгөө багшийг хөгжүүлэх вэ? Багш судлаач болох, багш сайн бүтээл гаргах судалгаа, шинжилгээ гаргахад төвөгтэй асуудал үүсэж байгаа байх л даа. Хоёр дахь асуудал энэ байна.

Гурав дахь нь болоод ирэхээр тэргүүлэгч мэргэжлээр төгсөгчдийг авч ажиллуулж байгаа тохиолдолд компаниудад татварын хөнгөлөлт үзүүлнэ гэсэн байна. Тэгэхээр энэ дээр хэрвээ их, дээд сургуулийн оюутнуудыг авч дадлага хийлгэж байгаа, энэ байгаа л даа дадлага хийлгэх юм байгаа. Гэхдээ яг үйлдвэрлэлийн дадлагыг арай жаахан урт хугацаагаар хийлгэж байгаа ч гэдэг юм уу, их, дээд сургуулийн багш, судлаачидтай хамтарч ажиллаж судалгааны төсөл хэрэгжүүлж байгаа тохиолдолд тэрийг нь татвараас хөнгөлдөг болох тийм зохицуулалтыг оруулах замаар их, дээд сургуулиудын судалгааны санхүүжилтийг эх үүсвэрийг бий болгох боломж байх уу гэж би асуух гээд байгаа юм.

Ч.Ундрам: Эхлээд хэн хариулах юм? Ариунболд дарга 2 номерын микрофон.

Ж.Ариунболд: Нээлттэй яг тодорхой хэлээрэй гээд. Тэгэхээр манай их, дээд сургуулиуд яг судалгааны их сургууль болоход дараах тулгамдсан асуудал бий болж байна.

Нэгдүгээрт, нь бол Монгол Улсын их сургууль дээр 3 жилийн дунджаар Боб сайнс/BOB science/дээр бүртгэлтэй өгүүллэгийн тоо сая бас хүрээд тодорхой босгоод авсан. Бусад сургуулиуд дээр энэ хүрэхгүй байгаа. Маш бага байгаа. Нэг дэх асуудал нь.

Хоёрдугаарт нь 1 багшид ноогдох оюутны тоо гэж байгаа. Монгол Улсын их сургууль дээр нэгийг харьцах нь 22-той явж байгаа. Бусад сургууль дээр энэ нэлээн өндөр байгаа. Үүн дотроо ахисан түвшний оюутны тоо. Өөрөөр хэлбэл манай их, дээд сургуулиудын нийт оюутнуудын ихэнх нь бакалаврын түвшинд сурч байгаа. Учир нь юу байна вэ гэхээр эндээс ямар зүйл харагдаж байна вэ гэхээр нөгөө бакалаврын түвшнийхээ оюутнуудаар дамжуулж сургалтын орлогоо бүрдүүлдэг. Улсын хэмжээнд 5400 оюутан докторын түвшинд сурч байгаа 152 мянган оюутнаас. Тэгэхээр энэ ахисан түвшний оюутны тоо маш бага байна.

Гурав дахь гол асуудал санхүүжилт. Өөрөөр хэлбэл, санхүүжилтийн олж байгаа орлогоо бол 100 хувь бараг өөрсдөө үйл ажиллагаа явуулж олдог. Эндээсээ харахад судалгааны үйл ажиллагаа явуулаад олж байгаа орлого нь дунджаар манай улсын төрийн өмчийн их, дээд сургуулиуд дээр 5-7 хувьтай байгаа.

Ч.Ундрам: Аль их сургуулиуд эрэлттэй мэргэжлийн тэтгэлэг аваад байна? Ямар мэргэжлүүд байна аа? Сийлэгмаа дарга 5 номер.

О.Сийлэгмаа: Гишүүний асуултад хариулъя. Нийт төрийн өмчийн 11 их сургууль зарим эрэлттэй мэргэжил дээр сувилагч, хөдөлмөр засалч, хөдөлгөөн засалч, хэл засалч, номын сан судлал, нийгмийн ажил гээд энэ 8 мэргэжлийн 6 мэргэжлээр нь санхүүжилт авч байгаа. Нийтдээ 4875 оюутанд 6.2 тэрбум төгрөгийг 24 онд зарцуулсан.

Үүнээс сувилагч мэргэжлээр 4529 оюутанд зарцуулсан байгаа 5.5 тэрбум төгрөгийг. Энэ 5.5 тэрбум төгрөгийг анагаахын их сургууль, зорилтот тэр. Үүнээс гадна энэ зарим эрэлтийн мэргэжлээр санхүүжилтийн 397 оюутанд нийтдээ Анагаахын их сургууль дээрсалбар 5 сургууль дээр байгаа. Багш мэргэжлээр МУИС-ийн 9 сургууль, МУБИС-ийн 9 сургууль, Хөдөө аж ахуйн 7 сургууль, Шинжлэх ухаан, технологийн 14 сургууль, Соёл урлагийн 6 сургууль дээр тус бүр оюутнуудад.../минут дуусав./

О.Сийлэгмаа: Хариултаа дуусгая. Тэргүүлэхээ бас хэлээд, тэгээд яг сургуулиуд дээрээ дүн нь хэд байгааг хэлчих. 5 номер.

О.Сийлэгмаа: Нийт зээлийн сангаас олгосон сүүлийн 3 жилийн судалгаагаар тэргүүлэх мэргэжлээр 10 мянган оюутанд олгосны яг нийт олгосон санхүүжилтийнх нь 2129 оюутанд 42 тэрбум төгрөгийг, эрэлттэй мэргэжлээр 10255 оюутанд 17.9 тэрбум төгрөгийг сүүлийн 3 жилд зарцуулсан байгаа.

Ч.Ундрaм: Аль сургууль хэд вэ гэсэн задаргаа?

О.Сийлэгмаа: Саяын энэ санхүү эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлийн санхүүжилт гадаад, дотоод санхүүжилттэй нийт дүнгээр байгаа. Эдгээрээс яг дотоодод олгосон санхүүжилт нь мэргэжил тус бүрээрээ, багш мэргэжлээр гэхэд анагаахын, МУБИС-ийн нийт 9 салбар сургууль гээд нэлээн өндөр дүнтэй санхүүжилтүүд байгаа.

Ч.Ундрaм: Сийлэгмаа дарга та тэргүүлэх мэргэжлийн жагсаалтаа, эрэлттэй мэргэжлийн жагсаалтаа, тэгээд хэдэн төгрөг сүүлийн 3 жил жил болгон гарсан юм, аль мэргэжил рүү гарсан юм, аль сургууль руу хэд гарсан юм гээд ийм мэдээ бэлдээд тэгээд Байнгын хороо руу хүргүүлчих. Би гишүүддээ хүргүүлчихье.

Компаниуд татварын хөнгөлөлт үзүүлнэ гэсэн. Энэнтэй холбоотой Батжаргал дарга 4 номерын микрофон.

Х.Батжаргал: Өнгөрсөн жил татварын хуульд нэмэлт, өөрчлөлт ороод энэ компаниудын аж ахуйн нэгжүүдийн татвар 1 хувьтай тэнцэх албан татваруудтай тэнцэх хэмжээний хөнгөлөлт аливаа ялангуяа хүний хөгжил боловсрол, эрүүл мэнд энэ чиглэлээр оруулсан бол хөнгөлөхөөр заасан байгаа. Тэгээд энэ бол боловсролын салбарт маш том дэмжлэг болсон ийм заалт болсон. Ялангуяа тэтгэлэг, мөн их сургуулиудад эрдэм шинжилгээ, судалгааны ажилд нь бас энэ аж ахуйн нэгжүүдийн дэмжлэг орж ирэх бололцоо, мөн түүнчлэн зөвхөн их сургуулиуд төдийгүй ерөнхий боловсролын сургуулиуд ч гэсэн энэ хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжийн зардал ч гэсэн энэ мөн орохоор ийм шаардлага, шалгуурыг бид нар бас хууль дагасан журам буюу энийг бас боловсруулж бэлэн болгосон байгаа.

Гагцхүү энэ оны тухайд, 2025 оны төсвийн жилийн тухайд Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр энэ татварын хөнгөлөлтийн асуудлыг хэрэгжүүлэхээр шаардлага, шалгуурыг нь тавиад ингээд явж байгаа. Тэгэхээр.../минут дуусав./

Ч.Ундрaм: Батжаргал дарга 25 он болохоор энэ боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт хэрвээ компаниуд, аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт хийх юм бол татвараас чөлөөлөгдөх юм уу, үгүй юм уу? 4 номерын микрофон.

Х.Батжаргал: Энэ хуулийн хэрэгжилтийг хангах яг ямар шаардлага, шалгуур хангасан, яг ямар стандарт, яг ямар хөрөнгө оруулалт байх вэ гэдгийг нь тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд батлахаар хуульд заасан байгаа.

Гэхдээ яг хэрэгжилт нь 2025 оны тухайд энэ шаардлага, шалгуур, энэ стандарт зөвхөн агаар, орчны бохирдол руу чиглэж байгаа юм 25 оны тухайд. Гэхдээ зөвхөн бас боловсролын салбар огт үгүй гэж бас орхиж болохгүй. Ялангуяа хөрсний бохирдлыг бууруулах чиглэл дээр ялангуяа манай ерөнхий боловсролын сургуулиуд дээр байдаг ариун цэврийн байгууламжийн асуудал дээр хөрөнгө оруулж байгаа. Энэ асуудал бол хөнгөлөгдөнө. Энэ бол шалгуурт нь ороод явж байгаа. Бусад нөгөө тэтгэлэг, судалгаа, эрдэм шинжилгээ гээд энэ тодорхой заалтууд 2025 онд биш, түүнээс хойш.

Х.Батжаргал: Тэгэхээр боловсрол, шинжлэх ухаанд жишээлбэл орчны бохирдлыг бууруулах судалгаа, тэгээд ариун цэврийн байгууламжийн асуудал руу

хөрөнгө оруулалт хийх юм бол татвараас хөнгөлөгдөх юм байна тээ? Яг ийм нэгдсэн журам гараагүй байна лээ шүү дээ. Засгийн газрын тэмдэглэл гарчихсан байна лээ. Тиймээ? Яг ийм журам гарах юм уу Татварын ерөнхий газар дээр? 4 номерын микрофон.

Х.Батжаргал: Энэ журам Сангийн яамнаас Сангийн сайдаас оруулж журам бол тэмдэглэлийн дагуу гарсан байгаа. Гэхдээ энэ журмын гол хэрэгжих асуудал нь болохоор стандартуудаа, шаардлагаа жишээ нь агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлийн хөрсний бохирдол дээр нь яг юу юунд хөрөнгө оруулах юм, яг ямар шаардлага нь хангагдаж байж татвараасаа чөлөөлөгдөх юм бэ гэдэг асуудлыг нь нарийвчлаад энэ шаардлага, шалгуур дээр нь нь зааж өгч байгаа. Энэ Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хороон дээр шийдвэрлэгдээд ингээд явж байгаа.

Ч.Ундрам: Хэрлэн гишүүн тодруулъя. 1 минут.

Б.Хэрлэн: Тэгэхээр ерөнхийдөө яг нөгөө их, дээд сургууль бизнесийн байгууллага хоёрын хамтын ажиллагааг урт удаан хугацааны цалинтай дадлага хийх, эрдэм шинжилгээний чиглэлд ингээд хөгжүүлэх тухай дээр тодорхой бодлого хэрэгтэй байна гэж.

Хоёрдугаарх нь миний бас дараагийн асуулт жаахан бүрхэгдүү хэлчих шиг боллоо. Өөрөөр хэлэх юм бол та бүхний жилийн зардлын хэдэн хувь нь яг багшийг цалин хөлс, багшийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаанд зарцуулагдаж байгаа вэ? Энэ асуудлаа би бас арай жаахан тодорхой.

Б.Хэрлэн: Их сургуулиуд бараг хариулах юм биш үү тээ? Саяын хэдэн хувь нь багшийн цалинд явдаг вэ? Ихэнх нь л багшийн цалинд явж байгаа даа. Ариунболд дарга хариулчих. 2 номер.

Ж.Ариунболд: Задаргааг нь яг дэлгэрэнгүй мэдэхгүй байна. Гэхдээ нийт яг үйл ажиллагааныхаа олж байгаа орлогынхоо 70-80 хувийг яг цалинд зарцуулж байгаа.

Ч.Ундрам: Бараг тийм дээ. Эсвэл бараг 90 хувь болж байж ч магадгүй тээ? Багшийн цалин нийт зардлын тийм 80, 90 хувь л бараг байгаа даа.

Дараагийн асуулт Батнайрамдал гишүүн асууя.

О.Батнайрамдал: Баярлалаа бүгдэд нь өглөөний мэнд хүргэе.

Харин сайд гараад явчихлаа. Гол нь сайдаас бас асуулт асууя гэж бодож байсан юм.

Ч.Ундрам: Өнөөдөр Засгийн хурал болоод наашилчихсан байгаа юм.

О.Батнайрамдал: За за. Урьд нь бараг 3 сарын өмнө асууж байсан юм. 2023 оны аудитын гүйцэтгэлүүд бүгдээрээ гарсан тээ? 109 төрийн өмчит хуулийн этгээдийн аудит танилцуулагдсан дотор Монголын 5 төрийн томоохон өмчийн их сургуулиуд байсан тээ? Энэ дотор бүгдээрээ ректорууд нь байх шиг байна. Монгол

Улсын их сургууь, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, МУБИС, Хөдөө аж ахуйн их сургуул, Соёл урлаг их сургууль.

Тэгэхээр энэ ер нь хар даа аудитор хязгаарлагдмал гарч байна гэдэг чинь менежментийн асуудал байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энэ дээр би дахиад фоллов ап/follow up/хиймээр байгаа юм. Энэ дээр ямар нэгэн шийдвэр гарсан уу, хариуцлага яригдсан уу, тухайн сургуулиуд дээр энэ дээр ямар алхам, ямар төлөвлөгөө гаргаад, юу хэрэгжүүлээд явж байгаа вэ? Нэгдүгээрт.

Тэгэхгүй бол аудитын дүгнэлт гардаг. Тэгээд л нэг чуулганаар үг болоод хоцорч ингээд болохгүй л дээ. Ер нь Улсын Их Хурал ч гэсэн цаашаа ингээд хяналтаа хэрэгжүүлэхийн тулд энэ чинь аудитын дүгнэлтүүд гардаг. Энэ нь буцаад заавал ингээд ажил хэрэг болж байх ёстой. Тэрний ардаас бас бид нар ч гэсэн энэ дээр бас ардаас нь хөөцөлдөх ёстой гэж бодож байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ректоруудын хариултуудыг сонсож байна л даа. Тэгэхээр энэ ялангуяа дээд боловсрол энэ явж явж Монгол Улсын, ер нь аливаа улсын ирээдүйг тодорхойлдог хамгийн том сүнс нь болсон салбар. Тэгэхээр та бүхний хэлж байгаа, ярьж байгаа яг үнэнийг хэлэхэд энэ дээр ялт ч үгүй менежментийн шинэчлэл зайлшгүй хийгдэх ёстой гэсэн дүр зураг л харагдаад байгаа юм л даа. Яг тэрийг л баталгаажуулаад байна. Өнөөдөр санхүүжилт байхгүйгээс болоод л болохгүй байна гэсэн л хариултууд өгөөд байгаа байхгүй юу. Аягүй хоцрогдсон байна шүү. Одоо энэ чинь сурагчдын, оюутны төлбөрөөс гадна төсвөөс өгч байгаа хөрөнгө оруулалт.

Гэхдээ нэг том зүйл хүртэл хаягдаад энэ дээр ерөөсөө ажиллаж байгаа их сургууль ерөөсөө харагдахгүй байгаа юм. Энэ юу вэ гэхээрээ аливаа сургуульд ялангуяа энэ төрийн өмчийн 6 дээд сургуульд, их сургуулиудад хүний нөөцийн томоохон өвийг бэлдэж байгаа. Эд нарт карьер девелопмент центр/career development centre/буюу карьер хөгжлийн маш том төвүүд байх ёстой. Аж ахуйн нэгжүүдтэйгээ хамтарч ажиллаж байх ёстой. Төгсөгчдөдөө өөрсдөд нь ажил олж өгөх гээд ардаас нь ректорууд нь бүх юм нь хөөцөлдөж байх ёстой байхгүй юу. Буцаад тэр төгсөгчид өөрсдөө сургуульдаа хандивын журмаар, өөр бусад сурагчдыг ажилд авах, ажилд оруулах журмаар ингэж хамтарч эргэх холбоотой ажиллах ёстой байхгүй юу. Яг энэ Монголын их сургуулиуд дээр хамгийн дутагдаж байгаа нэг зүйл яг энэ байгаа шүү. Дарга нэмэлт минут авчихъя тэгэх үү.

Ч.Ундрам: 1 минут нэмж өгье.

О.Батнайрамдал: Энэ хувийн их, дээд сургуулиудаар илүү хэрэгжиж байгаа байх. Гэхдээ явж явж төрийн их, дээд сургуулиуд хамгийн сайн хэрэгжүүлэх ёстой байхгүй юу. Буцаад энэ Америкийг аваад үзсэн ч гэсэн ер нь барууны, барууны ч гэлтгүй л дээ Азийн сургуулиуд бас ийшийгээ орж байна. Энэ юу вэ гэхээрээ санхүүжилтийн томоохон эх үүсвэр танай сургуулийн төгсөгчид өөрсдөө байхгүй юу. Энийгээ ерөөсөө олж харахгүй байна. Энийгээ та бүхэн олж хараач. Төгсөгчдийн гол зорилго бол зэрэгтэй болгоод төгсөхдөө гол нь биш шүү. Энэ ажлын 50 хувь байхгүй юу. Дараагийн 50 хувь юу гэхээрээ тэр хүүхдийг ажилтай, орлоготой болгоод, буцаад сургуульдаа хэрэгтэй зүйл хийх тэр эргэх холбоог үүсгэн та бүхний ажлын 50 хувь байх ёстой байхгүй юу.

Тэгэхгүй болохоороо яадаг вэ гэхээрээ нөгөө хүүхдүүд нь тэгээд л аав, ээж нь хөөрхий хүүхдүүддээ ажил олж өгөх гээд л таньдаг, мэддэг хүн рүүгээ залгаад

л, хэдэн гишүүд рүүгээ залгаад энэ та бүхний нөгөө эргэх холбоо ажиллахгүй байгаа болохоор аав, ээж нар аргаа ядаад хийж байгаа нэг арга хэмжээ байхгүй юу. Тэгэхээр энэ дээр яг ямар ажил хийж байгаа вэ гэдгийг би яг бүх ректоруудаас асуумаар байгаа юм. Энийг дараа нь бүр ингээд асуулга болгож тавимаар байгаа юм ер нь.

О.Батнайрамдал: Эхлээд 5 их сургуулийн аудитын хязгаарлалттай дүгнэлт энэ юу болж байна гэдэг асуултад хэн хариулах вэ? Батжаргал дарга 4 номер.

Х.Батжаргал: Өнгөрсөн жилүүдэд Батнайрамдал гишүүний хэлсэн бол яг үнэн. Зөвхөн 1 удаа биш зарим нь бас давхардаж жил дараалж бас хязгаарлалттай дүгнэлт авсан асуудал ч бас байдаг. Тэгээд Дээд боловсролын тухай хуульд орсон нэмэлт энэ шинэчилсэн найруулгын гол бас өөрчлөлт их сургуулиудад бие дааж, хагас бие дааж, санхүүгийн хувьд хагас бие дааж бүрэн академик эрх чөлөөг Удирдах зөвлөлөөр нь дамжуулж оруулсан. Менежментийн асуудал бас үүнд хамаатай. Ректоруудын томилгоо тэгээд жилийн тухайн жилийнх нь менежмент, бизнесийн төлөвлөгөө, оюутны хяналтын тоо энэ бүхэн Удирдах зөвлөл дээр өөрснөө шийдээд, өөрснөө явдаг үүнийг дагаад бас адилхан хариуцлагын асуудал ч Удирдах зөвлөл дээр бүрэн эрх нь шилжиж ирсэн байгаа. Түүний дагуу 2024 оноос 25 оны хичээлийн жил дэх Удирдах зөвлөлүүд хурлаа хийж, өнгөрсөн жилийнхээ тайлан гүйцэтгэлийг бүгдийг нь дүгнэж, холбогдох албан тушаалтан хариуцлага тооцох энэ асуудлыг бас хурлаараа шийдвэрлэгдээд, дараа жилийн төлөвлөгөөгөө батлахдаа бас өмнөх алдаа, дутагдлыг бас залруулж засах, шинэчилсэн стратеги төлөвлөгөөгөө бас нэлээн сая саяын таны хэлсэнчлэн санхүүгийн асуудлаас зөвхөн хараат биш, хамтарсан эрдэм шинжилгээний судалгаа хийх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хүчтэй оруулж ирэх, эрдэм шинжилгээний судалгаагаа эдийн засгийн эргэлтэд оруулах тал дээр төр, хувийн хэвшилдээ түншлэх гэх мэт энэ томоохон шинэчлэлийн асуудлуудыг энэ шинэ Удирдах зөвлөл шинэ хуулиараа энэ 2024-25 оны хичээлийн жилд бас төлөвлөөд ингээд ажиллаж байгаа.

Тэгэхээр холбогдох албан тушаалтнууд болон бас холбогдох зүйл, заалт гарсан аудитын зөвлөмжийн дагуу гүйцэтгэл нь хангагдаад ингээд явж байгаа гэж хэлж болно.

Ч.Ундррам: Сая яг тодорхой асуулаа шүү дээ 5 их сургууль байна гэж байна. Тэгээд яг аль аль сургууль нь яаж арга хэмжээ авчихсан юм уу, яачихсан юм гээд. Яг тодорхой хариулаа.

Х.Батжаргал: Монгол Улсын их сургууль. Монгол Улсын их сургууль дээр бас 2 жил дараалан энэ аудитын дүгнэлт гарсан. Хязгаарлалттай дүгнэлт. Үүний хүрээнд бас бас хариуцлагын асуудлууд яригдаж Удирдах зөвлөл болоод гүйцэтгэх удирдлага бүрэн бүрэлдэхүүнээрээ бас солигдож, бүтцийн хувьд ч гэсэн шинэчлэл хийгдэж, стратеги төлөвлөгөө бүх зүйлийг бас өөрчилж өмнөх алдаанаасаа бас сургамж болсон зүйлүүдийг ч гэсэн бас өөрчилж шинэчилсэн байгаа.

Хөдөө аж ахуйн их сургууль байгаа. Хөдөө аж ахуйн их сургуулийн хувьд бас элсэлтийн тоо, оюутны тоо өмнөх жилүүдэд хуримтлагдсан өр, авлагын асуудал, санхүүгийн менежментийн бас алдаатай байсан асуудлууд бас байдаг. Тэгээд энэ хүрээнд бас нэлээн өөрчлөлтүүд бас хийгдсэн. 11 тэрбум төгрөгийн ийм өрийн асуудлыг санхүүгийн бас сайн гэж, зөв гэж хэлж болохоор

менежментийг өнгөрсөн 1 жилийн хугацаанд хэрэгжүүлж, 8 тэрбумын өрийг.../минут дуусав./

Ч.Ундрам: Хариултаа гүйцээе. Хөдөө аж ахуйн 11 тэрбумаас 8 тэрбумынхаа өрийг дарчихсан явж байгаа. Дараагийн 4 номерт дахиад.

Х.Батжаргал: ШУТИС бас энд хамрагддаг. ШУТИС, манай их сургуулиуд бас харилцан адилгүй, өөр өөрийн онцлогтой. Тэгээд бас зөвхөн өөрсдөөс менежментээс үл шалтгаалах байдлаар бас энэ аудитын дүгнэлтэд бас өртсөн тохиолдлууд байдаг. Бүүр өмнөх жилийн нөгөө эргэж төлөгдөх боломжгүй болсон ийм авлагууд, хуримтлагдсан ийм авлагууд байдаг санхүүгийн. Өөрөөр хэлэх юм бол тухайн үеийн хэрэглэгдэж, мөрдөгдөж байсан хууль, журмын өөрчлөлт, хариуцаж байсан этгээд, хуулийн байгууллага татан буугдсан, оюутнууд бас энэ асуудлууд нь чөлөөлөгдсөн боловч баланс дээрээ энэ асуудал өөрчлөлтүүдээ хийгээгүй ийм асуудлууд байдаг. Эд нарыг бас бүгдийг нь залруулаад энэ шинэ хичээлийн жилдээ хэрэгжилт ингээд хангагдаад явж байгаа. Манай мөн СУИС бас энд хамрагддаг. СУИС ингээд мөн.../минут дуусав./

Ч.Ундрам: 4 номер дахиад минут өгье. Та товчхон гялс гүйцээчих.

Х.Батжаргал: СУИС Удирдах зөвлөлийнхөө хурлыг хийж, Удирдах зөвлөл дээрээ энэ асуудлыг бас өнгөрсөн жилийнхээ аудитын дүгнэлт, холбогдох алдаа оноогоо дүгнэж, цэгнэж ярилцахаар хүлээгдэж байгаа.

Ч.Ундрам: 5 дахь нь

Х.Батжаргал: Тэгээд Боловсролын их сургууль байгаа. Монгол Улсын боловсролын их сургууль. Боловсролын их сургууль дээр бас Удирдах зөвлөл дээр энэ хариуцлагын асуудлуудыг ярьж энэ баланс дээр бас гарсан зарим нэгэн өглөг, авлагыг бас зөв болгох энэ асуудал үүрэг, чиглэлүүд өгөгдөж гарсан алдаа, дутагдал залруулагдсан байгаа. Энэ балансын өөрчлөлтүүд байсан. Авлага барагдуулах чиглэлээр шийдвэр нь гараад явсан Удирдах зөвлөл дээр.

Ч.Ундрам: Яг энэ саяын 5 сургуультай холбоотой аудитын дүгнэлт, үүний араас авсан арга хэмжээнийхээ талаар бичээд тэгээд Байнгын хороонд хүргүүлье. Дараа нь гишүүддээ хүргүүлчихье.

Карьер хөгжлийн төвтэй холбоотой хэн хариулт өгөх вэ? Ариунболд дарга.

Ж.Ариунболд: Манай хувийн болон төрийн өмчийн их, дээд сургуулиуд дээр ихэнхэд нь байгаа Карьер хөгжлийн төв. Та хэлж байх шиг байна түрүүн энэ их, дээд сургуулиудын олдог орлогын энэ бараг ихэнх нь бол энэ алиумни/alumni/ буюу төгсөгчдөөсөө олдог орлого байх ёстой шүү гэдэг энэ санааг хэлж байна.

Тэгэхээр манай яг одоогийн нөхцөл байдлаар яг их, дээд сургуулиуд дээр энэ төгсөгчдийн өгч байгаа хандив, тусламж энэ зүйл маш бага байгаа. Бараг байхгүй гэхэд болно. Ийм зүйл байгаа.

Ч.Ундрам: Цаашид энэ тэр төгсөгчтэйгөө холбогдож ажиллах, карьер хөгжлийн төвдөө ч гэсэн төгсөгчдөө ашиглах гээд энэ асуудлыг бас бодлогын хүрээнд Ариунболд дарга та бас их сургуулиудтайгаа хамтарч ажиллах ёстой. Тэгээд Батнайрамдал гишүүнтэй бас уулзаад тэр Харвардад бас яадаг юм байна,

ийдэг юм байна судлаад. Тэгээд бас манайхан авах юмыг нь аваад суралцаад явах ёстой гэж бодож байна. Ер нь төгсөгчид гэдэг чинь аймаар том хүч шүү дээ. Монгол Улсын их сургуулийн хэдэн төгсөгч жишээлбэл энэ Их Хуралд гэхэд л зөндөө байна, ШУТИС-ийнх зөндөө байна, Хөдөө аж ахуйн их сургууль байна, Анагаахынх байна. Багшилж байсан хүмүүс нь хүртэл энд ингээд сууж байна гээд. Тэгэхээр та зөвхөн энэ дээр хязгаарлагдахгүй, бизнесийн байгууллагууд бас зөндөө олон мундаг төгсөгчид байгаа шүү дээ. Тэгэхээр энэ төгсөгчидтэйгөө яаж эргэж холбогдож ажиллах юм? Ай Ти системдээ ч гэсэн энийг нэвтрүүлж байх ёстой гээд ийм ажил дээр бас гадаадын шилдэг туршлагыг нэвтрүүлэх дээр анхаарч ажиллах ёстой шүү.

Батнайрамдал гишүүн тодруулъя. 1 минут.

О.Батнайрамдал: Тэгэхээр энэ төгсөгчид гэхээр төгсөгчид ингээд л аль ингээд л мөнгөн хандив өгдөг юм шиг ерөөсөө ойлгож болохгүй шүү. Энэ гогцооны нэг нь байхгүй юу. Хамгийн гол нь жишээлбэл энэ том аж ахуйн нэгжүүд байна юу гэдэг юм АПУ ч гэдэг юм уу, энэ том корпорац. Эд нар чинь бүгдээрээ дандаа хамгийн сайн хүний нөөц хайж байгаа л компаниуд шүү дээ. Тэгэхээр тэр хүний нөөцийг энэ их сургуулиуд бэлдэж өгнө. Тэгэхээр энэ чинь тэр сургуулиуд чинь хэн хэндээ ашигтай хувилбар байхгүй юу. Тэгэхээр тэр сургуулиудтай хамтарч ажиллаад, тэр тэр компаниудтай, тэр аж ахуйн нэгжүүдтэй. Тэр битгий хэл аж ахуйн нэгжүүдээр дамжуулаад, томоохон бас төгсөгчдөөр дамжуулаад томоохон цогцолбор хүртэл барих мөнгийг босгож болдог байхгүй юу. Тэгэхээр энд энэ дээр сургуулиуд өөрөө харин хоорондоо өрсөлдөөд хөөцөлдөж байх ёстой байхгүй юу. Ер нь эндээс босгож болох мөнгө, буцаад сурагчдаа ажилд оруулах тэр потенциал та нарын бодож байгаагаас илүү шүү. Тэрнээс биш хэдэн аав, ээж нь таньдаг, мэддэггүй хүн рүү утас цохиод л хүүхдэдээ ажил олдог энийг бүгдээрээ халах хэрэгтэй. Энэ аав, ээж нарын хийх ажил биш. Та нарын хийх ажил шүү.

Ч.Ундрам: Үг хэллээ. Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Сайн байцаана уу? Би 2 асуудлыг тодруулахыг хүсэж байна. 2 асуултаа эхлэхийн өмнө эхлээд нэгдүгээрт, манайх Боловсролын ерөнхий хуулийн 4.1 дээр боловсролын ерөнхий зорилго нь хүн бүр чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж ажиллах гээд яг тодотгохыг хүсэж байгаа ойлголт болохоор ёс, суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлнэ гэсэн байгаа. Дээд боловсролын тухай хуулийн 2.1-ийг харахлаар мөн зорилгоо томъёолоод хамгийн сүүлд нь ёс суртахуунтай иргэнийг бэлдэхэд оршино уу гэсэн байгаа.

Тэгэхээр ер нь бид нар энэ хуульдаа нэгдүгээрт энэ ёс суртахуун болон сайн зан чанартай иргэн гэдгийг хуульдаа заагаад өгчихсөн байдаг. Нөгөө талд өнөөдөр манайд их сургуульд сурч төгссөн хүнтэй ажилладаг салбарын энэ олон мэргэжилтнүүдийн дунд ёс зүйн харилцаа, хандлагын маш их алдаа дутагдлууд гарч, нийгэмд их бас бухимдлуудыг үүсгэдэг маш том хүчин зүйл байгаа. Тэгэхээр энэ асуудлыг шийдвэрлэхэд одоо байгаа хууль, эрх зүйн нөөц боломжийнхоо хүрээнд ер нь ямар шинэчлэл, ямар зүйлийг хийхээр төлөвлөж байгаа вэ? Энэ талаар Боловсролын яамны байр суурь, төлөвлөгөөг сонсмоор байна.

Хоёрдугаарт, их, дээд сургуулиудын хүрээнд эдгээр саяын ярьсан энэ ёс суртахуун энэ сайн зан чанартай иргэн гэдгийг төгсөгчдөө хэвшүүлэхэд ер нь яг энэ асуудлаар чинь Монголд 7 төрлийн хууль нь тодорхой хэмжээгээр заагдчихсан

байгаа байхгүй юу. Тэгэхээр их, дээд сургуулиуд нэгдүгээрт төрийн байгууллага болохынхоо хувьд, нөгөө талаасаа хүүхдийн орчин шүү дээ, хүүхэд тийм нас нь бас их, дээд сургуульд сурч байгаа оюутнууд байгаа.

Тэгэхээр хүүхдийн орчин болохынхоо хувьд манай их, дээд сургууль өөрсдөө эдгээр энэ сэтгэл зүйн энэ боловсрол, эерэг сэтгэлгээний дадал зэргийг сайжруулахын тулд ямар арга хэмжээг хэрэгжүүлж байна вэ? Ер нь юу хийхээр төлөвлөж байгаа вэ? Энэ карьер хөгжлөөс өшөө давсан зүйлүүд байгаа. Сайн ур чадвартай мэргэжилтнүүд хатуу ур чадваруудтай байж болно. Гэтэл бид нарт зөөлөн ур чадвар юу юунаас чухал байна. Хүнлэг харилцаатай хүмүүс хэрэгтэй байна, нийгмийн олон талт ялгаатай байдалд ажилладаг мэргэжилтнүүд хэрэгтэй байгаа.

Тэгэхээр их, дээд сургуулиуд энэ дээр хичээлийн хөтөлбөрт интеграцчилдаг юм уу, эсвэл практик сургалт үйл ажиллагаа байдаг юм уу, сайн дурын ажлаар дэмждэг юм уу, эсвэл тэр хөтөлбөрийн зөвлөлүүд дотроо уялдуулдаг юм уу гээд ингээд олон улсын өчнөөн сайн туршлагауд байгаа байхгүй юу. Тэгэхээр манай их, дээд сургууль энэ дээр ер нь ямар төлөвлөгөө байдаг юм бол? Ер нь цаашдаа бас хийж байгаа оролдлогуудыг нь бас сонсохыг хүсэж байна. Ингээд 2 асуулт байна.

Ч.Ундрэм: Боловсролын яамнаас хэн хариулах вэ? Батжаргал дарга 4 номер.

Х.Батжаргал: Гишүүний эхний асуултад хариулъя. Энэ ёс зүйн асуудал маш чухал асуудлыг гишүүн хөндөж асуулаа. Боловсролын яамны тухайд 2025 оны энэ эхэлж байгаа шинэ жилийг ёс зүйн жил болгон зарлаж, зөвхөн зарлана гэдэг маань цаана нь энэ чиглэлээр авах арга хэмжээг эрэмбийн нэгдүгээрт тавьж бас нэлээн эрчимжүүлэхээр энэ 25 оныхоо төлөвлөгөөг төлөвлөөд ажиллаж байгаа. Мэдээж хууль, эрх зүйн орчин маш тодорхой байгаа.

Тэгэхээр үүнийг хэрэгжүүлэх илүү хүртээмжийг нь нэмэгдүүлэх, илүү соён гэгээрүүлэх энэ чиглэл дээр бас ажлын хэсэг гараад, мөн холбогдох зарим нэгэн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр бодлогын тодорхой төсвүүдээ тавиад ингээд төлөвлөөд ажиллаж байгаа гэж хэлэх байна.

Ч.Ундрэм: Их сургуулиудын энэ чиглэлээр хийж байгаа ажил оролдлогууд юу байна гэж асуусан. Тэгэхээр МУИС-аас эхлээд ёс зүйн эерэг хандлага, дадал гэсэн. 5 номер Очирхуяг ректор.

Б.Очирхуяг: Их сургуулийн хувьд саяын агуулгатай чиглэлээр үндсэндээ 3 чиглэлээр ажилладаг гэж хэлж болно. Нэгд албан ёсоор танхимын хичээлээр энэ чиглэлийн агуулгуудыг суралцагчдад өгөхийг хичээдэг. Энэ дээр этикүүд ордог, ёс зүй ордог тусгайлан. Бас жендер, тэгш байдал гэсэн энэ төрлийн хичээлүүд сургалтын хөтөлбөрт байгаа. Энэ суралцагчид хичээлээр дамжуулж өгч байгаа хэлбэр.

Хоёр дахь нь болохоор суралцагчдад танхимын бус шаардлага гэж манайд үйлчлээд эхэлчихсэн. Хүүхэд сурахдаа, төгсөхдөө оюутан болгон заавал 48 цагийн бус шаардлага буюу нийтийн үйл ажиллагаанд оролцох, бусадтайгаа ажиллах гэсэн ийм шаардлагыг 48 цагаар тавиад өгчихсөн байгаа юм. Энэний нэг хэсэг нь яг энэ чиглэлийн шаардлагууд орчихсон байгаа.

Гурав дахид нь оюутныг оюутнаар буюу оюутан ментор/mentor/ төвтэй оюутны байгууллагаар нь энэхүү иймэрхүү үйл ажиллагааг хэрэгжүүлнэ гээд. Оюутан хөгжлийн хөтөлбөр гэж манай дээр байгаа. Энэ.../минут дуусав./

Ч.Ундрам: Хариултаа гүйцээчих товчхон.

Б.Очирхуяг: Оюутны хөгжлийн хөтөлбөрөөр буюу оюутныг оюутнаар нь энэ чиглэлд нь эзэмшүүлнэ. Илүү зөөлөн скилл/skill/ хийнэ үүгээр суулгана гэсэн бодлогын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг юм. Тэгэхээр үндсэндээ 3 чиглэлээр иймэрхүү төрлийн үйл ажиллагаа явж байгаа ажилбар.

Ч.Ундрам: Баярлалаа. ХААИС. Баасансүх ректор.

Б.Баасансүх: Бид нар энэ жилээс эхлээд сургалтын бүх хөтөлбөр, бүх төлөвлөгөөнд өөрчлөлтүүдийг оруулсан. Энэ дээр бид нар урьд нь манай хичээлийн хөтөлбөрт байдаг хүний хөгжил, харилцааны ийм хичээл байсан. Энэ хичээлээ бид нар бизнесийн ёс зүй гэсэн хичээлийг бүх мэргэжлийн ангид энэ жилээс орохоор бид нар сурлагын төлөвлөгөөндөө өөрчлөлтийг оруулж байгаа.

Хоёрдугаарт нь өнгөрсөн жилээс бид нар сургуулийнхаа дэргэд сэтгэл зүйч, мэргэжлийн сэтгэл зүйчийг бид нар ажиллуулж байгаа.

Гуравдугаарт нь өнөө энэ жил бас бид нар бас Япон Улсын Японы эелдэг ёс заншил нийгэмлэхтэй бид нар бас хамтын ажиллагааны гэрээ байгуулаад бас оюутнуудад энэ талын сургалтыг явуулах ийм бололцоог нь бүрдүүлээд бид нар ажиллаж байгаа.

Б.Дамдиндорж: Баярлалаа. АШУҮИС-ийн ректор Дамдиндорж.

АШУҮИС-д энэ. Ер нь байнга тасралтгүй явдаг. Хандлага, харилцаа, ёс зүйн бие даасан тэнхимтэй. Эмч эмнэлгийн мэргэжилтэн бэлдэж байгаа бүх оюутнууд энд хамрагддаг. Дээрээс нь оюутны хөгжлийн хөтөлбөр баталчихсан байдаг. Энд бол эх оронч оюутан, хөдөлмөрч оюутан, эрүүл, эрдэмлэг оюутан гээд. Энэ хүрээндээ бүх ёс, судалгааны ёс зүйгээс гадна харилцаа хандлагын ёс зүйн хичээлүүд тэгээд эх орноо хайрлах, аав ээж гэх мэт. Тэгээд энэ хүрээндээ Зэвсэгт хүчний Жанжин штаб тэгээд бусад юмнуудаар оюутнуудыг бодоод бүтээн байгуулалтууд, хил дээр аваачихаас өгсүүлээд эх орон, бусад юм, ийм хөтөлбөрүүд хэрэгжээд явж байгаа.

Ёс зүйн асуудлууд дээр бол дээрээс нь энэ ЮНИСЕФ/UNICEF/ болон Нэгдсэн Үндэстний байгууллагуудтай, энэ салбар байгууллагуудтай байнга харилцдаг. Тэгээд бэлгийн мөлжлөгөөс сэргийлэх ч гэдэг юм уу иймэрхүү дүрэм, журмууд бол сургууль дээрээ гаргаад анх удаа ингээд хэрэгжүүлээд явж байгаа. Жендерийн тэгш эрхийн асуудлууд гээд энэ бол хөтөлбөрүүд байнга тогтмол орж явдаг.

Ч.Ундрам: Монгол Улсын боловсролын их сургуулийн ректор Батбаатар 5 номер.

Ж.Батбаатар: Манай багш бэлтгэх хөтөлбөрүүдэд бол энэ чиглэлийн хичээлүүд юунууд илүү түлхүү тусдаг. Тэгээд орчин үеийн энэ боловсролын

хандлагатай уялдуулаад бид нар зөөлөн ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр илүү анхаарч шинэ боловсруулж байгаа, өнгөрсөн хичээлийн жилээс эхлээд шинэ боловсруулж байгаа хөтөлбөрүүддээ бол энэ зүрх сэтгэлийн боловсрол, тэгш хамруулах боловсролын хичээлүүдийг бол заавал үзэх хичээлээр оруулж байгаа.

Дээрээс нь бол манай оюутны клубүүд энэ чиглэлээр бол маш идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа гэсэн ийм хариулт байна.

Ч.Ундрэм: Соёл урлагийн их сургуулийн ректор Сонинтогос.

Э.Сонинтогос: Манайх энэ чиглэлийн байгууллагуудтай хамт нэлээд хамтарч ажилладаг уран бүтээлийн чиглэлээр. Жишээлбэл Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн үндэсний зөвлөл, энэ дүүргүүдийн, хотын энэ цагдаагийн газруудтай манайх хамтарч ажилладаг. Манай оюутнууд энэ чиглэлээр хамтарсан тэр уралдаан юунд нь нэлээн манлайлах үүрэгтэй оролцож байгаа.

Соёл, урлагийн сургууль бас соён гэгээрүүлэх нийгмийн өмнө асар том хариуцлага хүлээсэн сургууль гэдэг утгаараа бид нар энэ чиглэлээр эрхэмлэл дээдлэх үнэт зүйлсийн энэ судалгаануудыг төрийн өмчийн 6 их сургууль дээр явуулаад одоо ингээд энэ семестрийн хичээлүүд эхлэнгүүт Анагаахын Ухааны Их Сургууль дээрээс эхлээд бид нар аялгуут лекц гэдгийг зохион байгуулна. Энэ дээр бол бид нар энэ эрхэмлэн дээдлэх үнэт зүйлстэй холбоо лекцүүдийг уншаад, тэгээд тэрнийхээ дагуу бол оюутнууд уран бүтээлээ танилцуулна. Оюутан оюутандаа нөлөөлөх ажлуудыг нэлээн хийнэ гэж бодож байгаа.

Тэрнээс гадна манай их сургууль дээр хийгддэг зүйл бол энэ.../минут дуусав./

Ч.Ундрэм: Та хариултаа товчхон гүйцээчих.

Э.Сонинтогос: Оюутны уран бүтээлийг дэмжих чиглэлээр бид нар тодорхой төсвүүдийг зарлаад жил болгон 7-8 оюутны санаачилгатай төслүүдийг хэрэгжүүлдэг. Бас багшийн санаачилгатай төслүүдийг хэрэгжүүлдэг. Энэ нь голцуу тэр оюутны ёс суртахуун, уран бүтээл, хөгжих энэ ажил үйлстэй нь холбоотой зүйлүүдийг бид нар дэмжиж ажилладаг байгаа. Манай оюутны зөвлөл маш сайн ажилладаг. Энэ жилийн хувьд манайх тэргүүний оюутны зөвлөлөөр шалгарсан байгаа.

Ч.Ундрэм: Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн сургалт эрхэлсэн проектор Эрдэнэхүү.

Н.Эрдэнэхүү: Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн хувьд бакалавр оюутнуудын хувьд заавал эзэмших 11 чадамжийг бид нар тодорхойлж, үүнийхээ дагуу сургалтын хөтөлбөрт зөөлөн ур чадварыг мэргэжил болгон дээр хэрхэн яаж эзэмшүүлэхийг хичээлийн түвшинд тодорхойлсон.

Дээрээс нь нэмээд 1 хүртэл кредиттэй...хэлбэрийн зөөлөн ур чадвар, ёс зүйн чиглэлийн хичээлүүдийг оюутан сайн дураараа судлахаар бэлтгэж, нэмж сургалтын хөтөлбөр дээр оруулж ирж байгаа.

Дээрээс нь дипломын нэмэлт хавсралт олгохдоо нийгмийн хариуцлагын чиглэлээр дээр 4 жилийн хугацаанд хийсэн үр дүнг дагалдах хавсралт байдлаар

олгохоор бас төлөвлөөд, энэ хавсралт эхнээсээ өгөгдөж явж байгаа учраас эргээд бас оюутнууд энэ талд идэвхтэй болж байгаа гэж харж байгаа.

Ч.Ундрэм: Саранчулуун гишүүн тодруулъя. 1 минут.

О.Саранчулуун: Маш их баярлалаа. Би яг тодруулж, одоо ингээд мэдээж хэрэг нарийн мэдээлэл энэ тэр байх, бэлэн биш байгаа байх л даа. Ер нь миний хэлээд байгаа санаа бол аягүй сайн мэргэжилтэн байсан ч гэсэндээ хүнийг хүндэлдэггүй, хүнлэг биш, энэрэнгүй биш, хүний ялгаатай байдлыг ойлгодоггүй хүн бол аягүй сайн мэргэжилтэй байсан ч хол явахгүй, сайн төгсөгч байж чадахгүй гэж үзээд байгаа.

Тэгэхээр энэ дээр ерөнхийдөө манай сургуулиуд өөрсдөө оюутнуудын энэ хийсэн ажлуудынхаа үнэлгээнүүдийг эргээд хийх, оюутнууд өөрсдөө хэр их стресстэй байна вэ, курсийн ялгаа байна уу? Ямар мэргэжлийн оюутнууд илүү их суралцахтай холбоотой хам шинж, стрессийн хам шинж байна гэдгийг байнга үнэлж ингэж гаргадаг байх хэрэгтэй. Тэрнийхээ үр дүнг саяынхаа хөтөлбөртэйгөө холбох юм бол энэ чинь яг жинхэнээсээ энэ Боловсролын хуулийн хэрэгжилтийн бас яг шалгуур байхгүй юу. Тэгэхээр би цаашдаа ийм мэдээллийг бас дэлгэрэнгүй авах бас хүсэлтэй байна.

Ч.Ундрэм: Сургуулиуд дээр энэ саяын ёс зүй болон харилцаа, хандлагатай холбоотой ямар ажил хийж байгаа талаар мэдээ нэгтгээд Байнгын хороонд Ариунболд даргаа ирүүлъя.

Дараагийн асуулт Алтаншагай гишүүн.

Н.Алтаншагай: Өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын хэмжээнд дээд боловсролын 65 байгууллага байна гэж байгаа. Их, дээд сургууль, коллеж. Энэ коллежид тоо зөрүүтэй байгаа юм уу л гэж бодогдож байна мэдээллээс харахад. Хөдөө орон нутагт яг хэдэн их, дээд сургууль байгаа вэ? Монгол Улсын хэмжээнд 150 мянган суралцагч байна их, дээд сургуульд магистр болон докторын хөтөлбөр, дипломын хөтөлбөрт гэсэн. Энэнээс яг хэд нь хөдөө орон нутагт суралцаж байна вэ? Энэ хотын төвлөрлийг бууруулах дээр ингээд энэ бас уялдах ёстой ажил. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь Боловсролын зээлийн сантай холбоотой асуулт байгаад байгаа юм. Оюутан яг ямар журмаар энэ тэтгэлгийг авч байгаа вэ? Яаж хамрагдаж байгаа вэ? Энэ дунд яг энэ гэр хороолол болон энэ хөдөө орон нутгийн хүүхдүүд, оюутан залуучууд хамрагдаж чадаж байгаа юу?

Дараачийнх нь энэ яг энэ яг энэ дарга ангийн хүүхдүүдэд зориулагдсан юм шиг ийм хөтөлбөр гэсэн ийм ойлголттой болчихсон. Энийг яаж энэ жирийн иргэдийн хүүхдүүдэд олгох вэ? Энэ журам дахиж шинэчлэгдсэн үү, хэзээ шинэчлэгдэх вэ? Энийг яаж нээлттэй, ил тод болгох вэ? Дотроос өгч байгаа мэдээллээр шүү энэ Боловсролын сангийн зээлтэй холбоотой архив бичиг баримт нэлээн, хадгалалт, хамгаалалт би сул гэж ойлгосон. Яг энэ программд шилжиж чадсан уу?

Дараачийнх нь энэ их, дээд сургууль маань яг энэ бүтэн Англи хэл ч юм уу энэ гадаад хөтөлбөр рүү шилжсэн сургалттай их, дээд сургууль байгаа юу?

Кембрижийн хөтөлбөртэй 10 жилийн сургуулиас л бараг л долоон дор байгаа шүү дээ. Кембрижийн хөтөлбөрөөр сурсан хүүхдүүд чинь төгсөөд, шалгалт өгөөд гадагшаа, дотогшоо яваад өгдөг ийм нөхцөл байдалтай байгаа.

Их, дээд сургуулийн оюутнуудын дунд хүний эрхийн зөрчил ямар түвшинд байгаа вэ? Энэ бол байгаа. Ил гардаггүй л болохоос далд хэлбэрт шилжсэн, мөнгө санхүүтэй холбоотой, хүний эрхтэй холбоотой бэлгийн дарамттай холбоо ч гэсэн холбоотой ч гэсэн мэдээллүүд байдаг. Энэ дээр яг үнэлэлт, дүгнэлт, судалгаа хийсэн ийм суурь мэдээлэл байна уу? Хөдөө аж ахуйн сургуулийн элсэгчдийн тоо би жилээс жилд багасаж байна л гэж ойлгож байгаа. Хөдөө аж ахуй болон энэ мал аж ахуйн чиглэлийн боловсон хүчин бэлтгэх энэ дээр жилээс жилд багасаж байгаа гэсэн ийм статистиктай байгаа гэж би мэдээлэл ойлголттой байгаа. Энэ асуулт дээр хариулт авъя.

Ч.Ундрам: Хөдөө орон нутагт хэдэн их сургууль байна? Хэдэн оюутан хөдөө суралцаж байна? Батжаргал дарга 4 номер.

Х.Батжаргал: Орон нутгийн хэмжээнд 11 мянган оюутан суралцаж байна. 12 их сургууль их, дээд оролцуулаад тооны хувьд.

Хоёрдугаар асуулт Зээлийн сантай холбоотой. Зээлийн сангийн гол сонгон шалгаруулалтыг хийдэг баримталдаг журам Засгийн газрын 102 дугаар журам байдаг. Энэ журмын шинэчлэлийн ажлууд яг ид хийгдэж байгаа. Бас өнгөрсөн өнгөрсөн долоо хоногт Улсын Их Хурал дээр байгуулагдсан, Байнгын хороон дээр байгуулагдсан ажлын хэсэг бас Зээлийн сан дээр ажиллаж журмын боловсруулалт, өөрчлөлтийн ажил бас бус мэдээллийг авсан байгаа. Энэ шинэ журмын гол өөрчлөлт яг таны хэлсэнчлэн илүү ил тод, нээлттэй болгох, мөн түүнчлэн ялангуяа сонгон шалгаруулалтыг аль болох хүний оролцоогүй цахим ялангуяа Эй Ай байдаг юм уу энэ цахим системийг ашиглаж нээлттэй бид нар цахимаар энэ шалгалтыг аваад ер нь хэвшсэн жишээлэх юм бол ЕБС-ийн ЭЕШ-ыг жишээ нь шууд цахимаар аваад илэрхий ил тод, нээлттэй байдагтай адилхан шууд хариу нь гардаг, жагсаалтыг нь хүн хийдэггүй, программ хийдэг энэ чиглэл рүү явж байгаа.

Харин яг шалгаруулалтын яг энэ ажил журамд заасан оюутны эрх ашиг хохирох, журмаас шалтгаалаад ямар нэгэн ээдрээтэй асуудал үүсдэг энэ бүх асуудлууд шийдвэрлэгдэж байгаа. Жишээлэх юм бол 1 гэр бүл, 1 өрхөөс ямар нэгэн зээлийн сангаас ямар нэгэн тооцоотой, бүртгэлтэй байх юм бол хүүхдэд нь зээл олгогдож чаддаггүй явдал байсан. Жишээлбэл, хүүхэд ямар нэгэн зөрчилгүй тухайн үед жишээ нь ингээд шагнал гээд төрөөс шагнасан баланс дээр нь зээлийн санд бүртгэгдсэн мөртөө ингээд холбоотой байна гээд зээл авч чаддаггүй оюутнууд ихээр, хэд хэдэн кэйсүүд гарсан гэх мэтчилэн ингээд оюутнуудын асуудлыг илүү нээлттэй шийдвэр хүссэн журам шинэчлэгдэж гарч байгаа гэж хэлж болно.

Ч.Ундрам: Сийлэгмаа дарга 5 номер.

О.Сийлэгмаа: Гишүүний асуултад хариулъя. Орон нутгийн их, дээд сургуулиуд сургалтын төлбөрийн хувьд 2024 оны 102 дугаар тогтоолоор олгогдож эхэлсэн. 24 оны гүйцэтгэлээр 1853 оюутанд 3.2 тэрбум төгрөгийг зарцуулсан. 25 онд 4.9 тэрбум төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн байгаа. Нэгдүгээр асуултын тухайд.

Хоёрдугаарт нь ямар журмаар орон нутгийн болон төрийн өмчийн их, дээд сургуулиудын суралцагчид сангийн санхүүжилтэд хамрагддаг вэ? Сургуульдаа хүсэлт гаргаснаар тухайн суралцагчийн голч оноо болон мэргэжлийн зэрэг мөн журамд заасан шалгуур болох хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, сургуулийн магадлан итгэмжлэлийг харгалзан санхүүжилт олгодог байгаа. Жилд 9-12 дугаар сард 40 хувийн. 1-6 сард 60 хувийн санхүүжилтийг хуваарилж олгодог байгаа.

Дараагийн асуулт нь Боловсролын зээлийн сангийн тухай асуудлаар хэд хэдэн асуудал дээр хариулт өгье гэж бодож байна. Архив.../минут дуусав./

Ч.Ундрэм: Хариултаа гүйцээе. 5 номер.

О.Сийлэгмаа: Архив хадгалалтын тухайд ерөнхий газраас орсон 24 оны шалгалтын дүнгээр албан шаардлага ирсэн. Тэрдээр тусгайлан ажиллаж байна. 2 сарын 7-нд албан шаардлагын хариу хүргүүлэхээр бид төлөвлөн ажиллаж байгаа.

Мэдээллийн систем буюу цахимжилтын асуудал дээр 25 оны төсөв дээр дүн тавигдаагүй. Энэ чиглэлээр яамтай хамтраад зээлийн сангийн бүх мэдээллийг цахимжуулах асуудал дээр яамны хөрөнгө оруулалтаар шийдвэрлэхээр одоогийн байдлаар 25 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон яамны хөрөнгө оруулалт төлөвлөгөөнд тусгаад ажиллаж байна.

Ч.Ундрэм: Цахим руу орсон гэсэн үү?

О.Сийлэгмаа: Оруулахаар бэлтгэл ажлууд хийгдэж байгаа.

Ч.Ундрэм: Англи хэл рүү шилжсэн хөтөлбөр хэд байгаа вэ их сургуулиуд дээр? Ариунболд дарга 2 номер.

Ж.Ариунболд: Одоогоор яг бүрэн Англи хэл дээр 100 хувь явагдаж байгаа ийм сургууль байхгүй. Яг манай төрийн өмчийн 6 их сургууль дээр 300 орчим хичээлийг Англи хэл дээр явуулж байна.

Ч.Ундрэм: Хөдөө аж ахуйн их сургуулийн элсэлттэй холбоотой Баасансүх дарга 3 номерын микрофон дээр суучих. 3 номерын микрофон.

Б.Баасансүх: Хөдөө аж ахуйн их сургууль элсэлтийн маркетингийн бодлого шинэчилсний үр дүнд өнгөрсөн жил бид нар 1645 буюу өнгөрсөн хичээлийн жилээс бид нар 707 оюутнаар бид нар илүү элсүүлсэн. 1645 оюутан элсүүлсэн байгаа. Энэ жил 2085 оюутан элсүүлнэ. Элсэлт сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа. Сүүлийн 1, 2 жил.

Ч.Ундрэм: Элсэлт нэмэгдэж байгаа. Бас дарамт гэсэн. Хүүхдүүд нэг нэгнээ дарамтлах асуудал их сургуулиуд дээр хэр байна вэ гээд хэнээс нь хариулт авмаар байна Ариунболд дарга.

Ж.Ариунболд: Манай дээд боловсролын газар дээр бол бас мэдээллүүд ирдэг. Гэхдээ яг нийт бид нарын яг хамгийн сүүлийн байдлаар бол яг тэр сургууль дээр ийм оюутан ингэж ингэж ийм дарамт ирлээ гэдэг яг энэ мэдээлэл албан ёсоор бичгээр ирсэн юм алга байна одоогоор. Яг бид нар дээр.

Ч.Ундрaм: Хариулт хангалттай юу Алтаншагай гишүүн? Тодруулах уу? 1 минут тодруулъя.

Н.Алтаншагай: Би энэ нөгөө ажлын хэсэгт ороогүй болохоор энэ тодруулж асууж байгаа юм шүү Боловсролын зээлийн сангийн талаар. Энэ хөтөлбөр чинь яг хэдэн оноос хэрэгжсэн хөтөлбөр вэ? Нэгдүгээрх нь. Хоёрдугаарт нь өдийг болтол энэ нээлттэй, ил тод биш тэгээд цахимжиж энэ программд шилжээгүй байгаа, архив хамгаалалт нь би нэлээн сул л гэж л ойлгосон. Одоо excel дээр байна гэж ойлгож болох уу?

Ч.Ундрaм: 5 номер, Сийлэгмаа дарга.

О.Сийлэгмаа: Орон нутгийн хөтөлбөр суралцагчдын сургалтын төлбөрийн хөнгөлөлт бол 2022 оноос хэрэгжиж эхэлсэн байгаа. 22 оноос хойш орон нутгийн их, дээд сургуулиудын төрийн өмчийн их, дээд сургуульд суралцагчдын зээл бол Оюутны хөгжлийн зээл гэж нэрлэгддэг зээл бол одоо ч гэсэн нээлттэй ямар нэгэн шалгуур үзүүлэлтгүй. Зөвхөн тэтгэлэг нь амьжиргааны түвшнээс доош орлоготой иргэдээ эгээд 50 хувийн тэтгэлэг гэдэг нь 24 оны 3 сараас эхэлж хэрэгжиж эхэлсэн байгаа.

Гадаадын их, дээд сургуулиудын тухайд гэх юм бол суралцагчдын сонгон шалгаруулалтын асуудал жил болгоны одоог хүртэл үйлчилж ирсэн журмаар сонгон шалгаруулалт нь нээлттэй, ил тод байхаар журамласан хэдий ч яг сонгон шалгаруулалтын процессын хувьд, шалгаруулалтын хувьд субъектив нөлөө болох шалгалтын суралцагчдаас шалгалтын асуудал хөндөж байгаа. 25 оноос эхлээд ямар нэгэн субъектив оролцоо байхгүйгээр зөвхөн сургуулийн эрэмбэ, сургуулийн суралцах мэргэжлийн чиглэлээс хамааруулсан цахим шалгаруулалт хийхээр төлөвлөөд ажиллаж байгаа.

Ч.Ундрaм: Хариултаа гүйцээе 5 номер.

О.Сийлэгмаа: Гадаадад суралцагчдын олгосон санхүүжилт болон суралцагчдын судалгаа мэдээлэл excel программ дээр байгаа. Тэрийг цахимжуулах буюу системд оруулахаар бид 25 онд төлөвлөөд ажиллаж байгаа.

Дотоодод суралцагчдын мэдээлэл бол нийтдээ 2012, 16, 20 онуудад хийгдсэн программууд дээр байгаа.

Ч.Ундрaм: Энэ Боловсролын зээлийн сан бас нэлээд асуудал болоод хэд хэдэн хүмүүс шүгэл үлээгээд, одоо ингээд цэгцрэх замдаа ороод ажлын хэсэг байгуулагдаад явж байгаа. Тодорхой хугацааны дараа нэлээн цэгцэрнэ гэсэн хүлээлт бид нарт байгаа. Ер нь цаашид энийг бүүр нээлттэй телевизийн оролцоотойгоор Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизтэй хамтраад олон нийтэд нээлттэй сонгон шалгаруулалтыг нь хийгээд ингээд явж болдоггүй юм уу гэсэн саналыг хүртэл Ганбаатар гишүүн гаргасан санагдаж байна. Тэгэхээр энэ чиглэлээр ер нь дараагийн сонгон шалгаруулалтаа хийх нь зөв болов уу л гэж Сийлэгмаа даргад хэлмээр байна.

Дамдинням гишүүн асуулт асууя.

Г.Дамдинням: Гишүүддээ энэ өглөөний мэнд хүргэе.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо өнөөдөр Дээд боловсролын хуулийн хэрэгжилтийн асуудлыг ярих гэж байгаа юм. 2023 оны 7 дугаар сарын 7-нд батлагдсан хууль. Өнөөдөр Боловсролын сайдаас өгсөн ийм 5 хуудас слайд дээр хуулийн хэрэгжилттэй холбоотой олон юм алга даа. Монголын дээд боловсрол 5 хуудас слайдны танилцуулгад багтчихна гэж би бодохгүй байна. Сайд нь ч алга. Салбарын Байнгын хорооныхоо хурлыг хүндэлдэггүй Засгийн газрын гишүүн юу хийж явахыг мэдэхгүй байна. 5 асуулт байна. Тэгээд бид нар энэ бодлого ярих гээд сууж байгаа юм.

Нэгдүгээрт, боловсролын бүх тогтолцоонд Англи хэлийг үндсэн гадаад хэл болгоно гэж оруулсан. Дээд боловсролын тогтолцооны хувьд энэ ажил хэрхэн хэрэгжиж байгаа юм? Сайд нь хариулах ёстой байх.

Хоёрдугаарт их, дээд сургуулиудын ранкийг өөрөөр хэлбэл чанар үзүүлэлт нь ер нь ямар байгаа юм, нийтэд нээлттэй зарладаг байх тухай хуулийн заалт байгаа. Энэ хуулийн заалт яагаад хэрэгжихгүй байна? Энэ аав, ээжийн хүүхдүүд мэдлэг, боловсролоо сонгоод, сургууль сонгоод орохын тулд хэн нь хаана яваа, аль мэргэжил, аль чиглэлээрээ мундаг сайн байгааг нь харж байгаад сонгож байх ёстой байхгүй юу. Дэлхийн аль ч улсад ийм л байгаа. Бид нар хуулийг хийхдээ яг ингэж хийсэн шүү дээ. Хуулийн энэ заалт яагаад хэрэгжихгүй байгаа юм?

Гуравдугаарт энэ хувийн сургуулиудын гадна, дотнын их том том мундаг мундаг хөтөлбөртэй гээд баахан реклам хийнэ. Аав, ээжүүдээс мөнгийг нь авна. Зах дээр зогсож жилийн турш олсон мөнгөө хүүхдийнхээ сургалтын төлбөрт аваачаад өгчхөж байгаа шүү дээ. Биеэ үүрэн, эрүүл мэндээ үүрэн сууж байгаа. Тэгтэл тэр олон улсын хөтөлбөр нь тэр яг үнэхээр олон улсынхаа хөтөлбөрийн чанарыг хангаж байгаа юу, үгүй юү гэдгийг Боловсролын яам тэр хувийн сургуулиудаас нь шахаж шаардаж байгаад аваад олон нийтэд зарладаг байх тогтолцоог бид нар хуулиар хийж өгсөн. Энэ заалт яагаад хэрэгжихгүй байгаа вэ? Ард түмнийхээ сайн боловсрол авах чиглэлд, бодитой сонголт хийх боломжийг бид нар нээх тал дээр нь бас ажиллах ёстой гэж энэ хуулийг хэлсэн шүү дээ.

Дөрөвдүгээрт, энэ жалгаар докторууд боллоо Монголд. Чулуу аваад шидвэл доктор ононо. Хуулалтын эсрэг үндэсний байгууллага, ёс зүйн зөвлөл байгуулах ёстой ийм хуулийн заалт байгаа. Байгууллага байх ёстой? Бүх судалгааны ажлуудыг хянадаг, нийтэд зарладаг ийм байгууллага байх ёстойг хуульд зааж өгсөн. Энэ яагаад хэрэгжихгүй байгаа вэ?

Тавдугаарт, Монгол Улсын хөгжил, дэвшилд нэн шаардлагатай, бүтээн байгуулалтад хэрэгтэй мэргэжилтнүүдийг Засгийн газрын тогтоолоор зарлаж, тэрэндээ тэтгэлэг олгодог байх хуулийн заалт байгаа. Тэр хэрхэн хэрэгжиж байгаа вэ? Ийм 5 асуултад хариулт авъя. Тэгээд сайд нь байхгүй тэгээд хэнээс ч асуугаад байгаа юм бол доо.

Ч.Ундрам: Сайд нь байхгүй юм чинь. Дээд боловсролын газрын дарга Ариунболд хариулт өгье.

Ч.Ундрам: Нэгдүгээрт, нь Англи хэл дээр хөтөлбөрүүд байгаа. Монголын их, дээд сургуулиуд дээр хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийн 20 хүртэлх хувийг энэ 4 жилд Англи хэл дээр хэрэгжүүлнэ гэдэг ийм зорилтыг дэвшүүлээд явж байгаа.

Одоогоор бол 300 орчим хичээлийг англи хэл дээр яг хэрэгжүүлж байна төрийн өмчийн 6 их сургууль дээр.

Хоёр дахь нь ранкыг бол 2023 он болон 22 он болон 24 онуудад хийсэн. 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр бүх төрийн өмчийн болон хувийн их, дээд сургуулиудыг бол цуглуулаад энэ мэдээллийг бол сургуулиудад хүргэсэн. Учир нь юу болсон бэ гэхээр сургуулиуд хувийн болон төрийн өмчийн зарим их, дээд сургуулиуд 2 гомдлыг тавьсан. Ямар гомдол байсан бэ гэхээр энийг яг хууль дээр байгаа юм. Дээд боловсролын тухай хуулийн 12.9 дээр олон улсын байгууллага, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар хийлгүүлнэ гэдэг энэ зүйлийг хийлгэх процесстоо Үндэсний чанарын баталгаажуулалтын хүрээлэн гээд ийм дотоодын байгууллага болон Боловсролын үнэлгээний төвөөр ингээд хийлгүүлчихсэн учраас энэ бол яг олон улсын хөндлөнгийн ийм хараат бус яг хийлгэсэн гэж бид үзэхгүй байна гэдэг энэ их, дээд сургуулиудын ийм гомдол бол ирээд тухайн сургуулиудад бид нар яг энэ мэдээллийг хүргэсэн байгаа. Хоёр дахь асуудал нь.

Гурав дахь асуудал нь бол хуулалтын эсрэг ёс зүйн зөвлөл хуульд заасан асуудал байгаа. Хуулалтын эсрэг Монгол Улсад бол нийтдээ их, дээд сургуулиуд дээр 19 их, дээд сургууль дээр 39 дэд зөвлөл, доктор хамгаалуулах зөвлөл ажиллаж байна. Энэ хүрээ энд Дээд боловсролын тухай хууль дээр зааснаар хуулалтын болон докторын нэгдсэн бүртгэлийг Шинжлэх ухаан, технологийн сантай бид нар хамтарч хийгээд нэгдсэн санг бүрдүүлж байна одоогоор. Хуулалтын ажиллах ажлын журмыг яг сайд ингээд сайдын тушаал гарах гээд бэлтгэл ажил явж байгаа. Ёс зүйн зөвлөл дээд боловсролын ёс зүйн зөвлөл ингээд байгуулагдчихсан одоо ийм процесстой явж байгаа.

Дөрөвдүгээрт нь хөтөлбөрийн чанарын асуудал дээр байгаа. Дээд боловсролын тухай хууль болон Боловсролын ерөнхий хууль дээр 5 жил тутам эрэлттэй болон тэргүүлэх мэргэжил мөн аргачлалыг бол Засгийн газраас батална гэсэн байгаа. 2023 оны Дээд боловсролын тухай хууль, Боловсролын багц хууль батлагдахаас өмнө 2023 оны 3 дугаар сард бол нийт эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлийн жагсаалтыг баталсан байсан. Яг одоогоор бол эрэлттэй тэргүүлэх 131 мэргэжил байгаагаас одоо бид нар бүх яамнууд болон ажлын хэсэг гараад бусад газруудаас саналаа аваад Засгийн газраар эхний улиралдаа эрэлттэй тэргүүлэх мэргэжлийг бид нар нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулахаар ингээд ажиллаж байна.

Ч.Ундрам: Дамдинням гишүүн тодруулъя.

Г.Дамдинням: Та нар энэ бас хэмжээ, хязгаартаа бурцгаана шүү. Энэ Англи хэлийг 20 хувь хүргэх ажлыг чинь наад ШУТИС чинь аль эрт хийчихсэн шүү дээ. Тийм биз дээ? Танайх чинь аль эрт нэлээн нэлээн олон хичээлүүд хийчихсэн явж байгаа шүү дээ. Энэ бусад сургуулиудыг хийж байгаа шүү дээ. 20 хувь, 4 жилд 20-хон хувь байх даа яах вэ дээ та нар. 300-хан хөтөлбөр шүү дээ. Дор нь шүү дээ наадах чинь. Бүүр дээд боловсролын байгууллагууд юм бол хий л дээ наадхаа. Хурдан хий л дээ. ЕБС биш шүү дээ та нар. Хугацаа тавиад өөрсдөө өөрсдөө 4 жилийн хугацаа өгчихсэн ч байх шиг. Тийм гэж юу байдаг юм?

Хоёрдугаарт энэ их, дээд сургуулиудын ранкийг та нар мэдээд тэгээд гомдол гарсан гээд суугаад байх уу? Үндэсний магадлан итгэмжлэлийн байгууллагаа олон улсын акардаци авчихлаа гээд реклам хийхээрээ баахан

тавьдаг. Олон улсын гишүүнчлэлтэй шүү дээ наад байгууллага чинь. Тийм биз? Зарлаач энийгээ. Тэгээд та нар зарла. Хэн хаана ороод байгаагаа мэдэг, хэн хаана явж байгаагаа хараг.

Гуравдугаарт энэ хувийн сургуулиудын хөтөлбөрүүд энэ Кембрижийн гээд л олон хөтөлбөрүүдтэй хувийн сургуулиудын энийг зарла гэж байгаа шүү дээ. Зарлуулах үүргийг та нар.../минут дуусав./

Ч.Ундрэм: Ариунболд дарга 2 номер.

Ж.Ариунболд: Бид нар төрийн өмчийн 6 их сургууль дээр би өөрөө яг очиж уулзсан. Энэ нийт хөтөлбөрийн 20 хүртэлх хувийг яг одоогоор бол АШУИС дээр 4 хөтөлбөр нь Англи хэл дээр яг явагдаж байгаа. Яг хөтөлбөрөөрөө хичээлээрээ биш. Бусад сургуулиуд Монгол Улсын их сургууль дээр 2 хөтөлбөр байгаа. Монгол Улсын боловсролын их сургууль дээр 1 хөтөлбөр байгаа. Хөдөө аж ахуйн их сургууль дээр 1 хөтөлбөр, ШУТИС дээр бол 2 хөтөлбөр гэж ирсэн. Ийм хөтөлбөрүүдийн хүрээнд бол явж байгаа. 4 жилийн хугацаанд нийт хөтөлбөр гэхээр нийтдээ 60 орчим жишээлбэл ШУТИС дээр 60 хөтөлбөр байхыг, 60 орчим хөтөлбөрийн 20 хувь гэхээр арван хоёр, гурав. 12-15 хөтөлбөрийг бол Англи хэл дээр оруулахаар ингэж явж байгаа ийм зүйл байгаа.

Ранкийн асуудал дээр ийм яг ийм асуудал үүссэнийг 2 удаа яг сайдад болон сайдтай мөн хувийн их, дээд сургуулиудын холбооны төлөөлөл орж уулзсан. Тэгээд миний хувьд ийм л мэдээлэл байгаа.

Ч.Ундрэм: Энэ Дамдинням гишүүн энэ чухал юм асуугаад байна шүү дээ. Энэ манай Үндэсний магадлан итгэмжлэх төв чинь өөрөө олон улсын гишүүнчлэлтэй, олон улсын улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага байхгүй юу. Их сургуулиудыг эрэмбэлэх ийм хуулийн шаардлагыг хангачихсан байгууллага. Энэ байгууллага маань их сургуулиудыг эрэмбэлээд зарлах ёстой. Бид нар их сургуулиудын эрх ашиг гэхээсээ илүүтэй энэ ард, иргэдийн хүүхдүүдийн эрх ашгийг хангах ёстой. Энэ хүүхдүүд ямар эрэмбэтэй сургуульд би мөнгөө төлөөд орж байгаа юм бэ гээд хэрэглэгчийн эрх ашиг гэсэн үг шүү дээ. Энэ хүүхдүүдийн эрх ашиг. Үүнийгээ мэдэх ёстой. Ээж, аав нь хэдэн толгой малаа зараад, зах дээр өдөр шөнөгүй зогсоод хуримтлуулж байгаа мөнгөө манай монголчууд яадаг хүүхдийнхээ их сургуулийн төлбөрт л өгдөг. Тэгэхээр мэдэх ёстой. Ямар чанар чансаатай их сургуульд би энэ махаа идэж олсон мөнгөө өгч байгаа юм бэ? Хүүхдийнхээ ирээдүйн баталгаа болгож авч байгаа үйлчилгээ маань ямар чанартай юм бэ гэдгийг мэдэх ёстой.

Тэгэхээр энийг Ариунболд даргаа, Батжаргал даргаа та энэ хуулийг хэрэгжүүлэх ёстой шүү. Танай, та нарын хийх ёстой ажил чинь энэ байгаа. Тэгээд хариултыг нь гүйцээгээд авчихъя Дамдинням. Байхгүй байхгүй байхгүй. 1 л удаа. Ариунболд дарга.

Ж.Ариунболд: Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр энэ эрэмбэ, чансааг тогтоолгох ажлыг хийлгээгүй. Боловсролын үнэлгээний төвийг ТББ болох Боловсролын чанарын үндэсний судалгааны хүрээлэн гэсэн байх ийм ТББ-тай хамтарч хийлгүүлсэн байсан. Хууль дээр бол олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар хийлгүүлнэ гэдэг, тогтоож олон нийтэд зарлана гэсэн хуульчилсан байх.

Тэгэхээр энийг яг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл яг өөрсдөө хийгээгүй юм шүү гэдгийг би энэ дээр тодруулаад хэлчихье.

Ч.Ундрам: Тэгэхээр Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөр ер нь хийлгээрэй. Одоо тэгэхдээ байгаа юмаа хуульд заагаагүй ч гэсэн зарлаж болох байхгүй юу. Зарлаж болно шүү дээ яам бодлогоороо.

Эцэст нь би бас хэдэн асуулт байна. Энэ их сургуулиуд дээрх хөтөлбөрийн давхцалыг дахиж харах хэрэгтэй шүү. Тэгээд их сургуулийн ректоруудтай сууж байгаад Ариунболд даргаа дээд боловсролтой Монгол Улсын иргэн гэж ямар мэдлэг, чадвартай хүн байх ёстой юм. Ямар софт скилл/soft skill/ байх ёстой юм, ямар ёс зүйтэй байх ёстой юм бэ гэдэг энэ суурь ерөнхий боловсролыг хамтдаа сууж байгаад та хэд хоорондоо ярих ёстой. Тэр босгыг тавьсны дээшээгээ мэдээж их сургуулиуд өрсөлдөж болно. Тэр босго бодлогыг та хэд яаман дээр барьж авч явах ёстой гэдгийг хэлмээр байна. Тэгэхээр энийг та хэд цаашид ярилцах ёстой.

Байнгын хорооны гишүүдэд энэ дээд боловсролын бодлогын шинэчлэл, эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл гээд бүгдэд нь хүргэсэн. Энэ дээр эрэлттэй мэргэжил, тэргүүлэх мэргэжил, Дээд боловсролын тухай хууль, Засгийн газрын тогтоолууд, өнгөрсөн 4 жил парламентын хугацаанд хийсэн ажил, Засгийн газрын хийсэн ажил энэ дээр бүгд байгаа. Энэ дээр нэмэгдэх ажлууд яаман дээр түүнээс хойш энэ хагас жил жилийн хугацаанд хийгдсэн юмнууд байж магадгүй. Энэ яг өнгөрсөн 4 жилийн материалууд байгаа. Та бүхэн танилцаарай гэж хэлмээр байна.

Элсэлтийн бодлоготой холбоотой юу хийгдэж байгаа вэ яг өнөөдөр гэдгийг Ариунболд даргаас асуумаар байна. Би хэлээд байгаа шүү дээ Боловсролын үнэлгээний төв бол 12 дугаар ангийн бүх хүүхдүүдэд ямар мэдлэг, чадвар суучихсан, мэдчихсэн байх ёстой юм бэ гэдэг ерөнхий агуулгын шалгалт заавал авах ёстой. Энэ дээр олон удаа шалгалтаа мөнгөө төлөөд ч хамаагүй өгөх боломжоор бид нар хангах ёстой. Гадаадын Эс Эй Ти, Эс эй Ти шалгалт шиг ийм боломжийг өгөх ёстой шүү.

Хэлний шалгалт ч гэсэн Монгол хэлний шалгалтыг бас олон удаа өгөх боломжоор нь хангах ёстой. Хүүхэд сайжраад 1 сарын дараа дахиад өгөөд ингээд явах ёстой гэдэг энэ зүйлийг би хэлээд байгаа. Энэтэй холбоотой ямар ажил хийгдэж байна вэ?

Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүд болон энэтэй холбоотой дүрэм журам өөрчлөгдөх гээд явж байна гэсэн. Яг ямар бодлого чиглэл та хэд дээр явж байгаа вэ? Энэ докторын чанарыг бид нар бас нэлээн бодож үзэх хэрэгтэй. Магистр, ахисан түвшний ер нь сургалтын чанарыг нэлээн сайн авч үзэх ёстой. Энэтэй холбоотой ямар бодлого, чиглэл яаман дээр хэрэгжих гээд явж байна, яригдаж байна вэ гэсэн ийм асуудал.

Энэ Дархан руу Хөдөө аж ахуйн сургуулийг нүүлгэх асуудал, Хөдөө аж ахуйн сургуулийн багш нарыг та хэд Дархан руу аваачаад хурал хийгээдхээч. Тэнд ямар ч түгжрэл алга. Бүх дэд бүтэц байна, тэнд утаа алга. Барилга байгууламжийг нь бариад өгье гээд. Тэнд оюутнууд илүү сайхан орчинд сурах8 багш нар илүү сайхан таатай орчинд сурах, дээрээс нь судалгааныхаа объектод ойрхон байх ийм боломжууд нь байгаа байхгүй юу. Тэгэхдээ энд байгаа барилга байгууламж, газраа алдчихна гэдэгт санаа зовохгүйгээр тэнд нэг хэсгээ нүүлгэж болно шүү дээ. Энд нэг хэсэг нь байгаад, тэнд нэг хэсэг нь очих боломж байгаа байхгүй юу. Энийг

та хэд жоохон идэвхтэй судлаад, багш нартайгаа очоод үзээд ингээд ажиллах шаардлагатай гэж бодож байна шүү Баасансүх ректор. Тэгэхээр энийг бас хэлмээр байна.

Тэтгэлгийн бодлогоо бид нар бас улсын хэмжээнд нэгтгэмээр байна. Одоо энэ Боловсролын зээлийн сангаар Монголд бэлтгэхгүй байгаа тийм бакалавр гадагшаа гаргаж болох юм. Бэлтгэж байгаагаа бол бид нар Монголдоо л бэлдчих хэрэгтэй. Тэгээд магистр, доктор ахисан түвшиндээ гадагшаа явуулж болж байна. Ерөнхийлөгчийн тэтгэлэг Ерөнхий сайдын тэтгэлгийг ч гэсэн ийшээ чиглүүлмээр байна. Тэгэхээр энийг бас та хэд нэлээн идэвхтэй тэр Ерөнхийлөгчийн зөвлөхүүдтэй, Ерөнхий сайдын зөвлөхүүдтэй ч гэсэн сайн ярьж, засаг дээрээ ярьж байж энэ тэтгэлгийн улсын бодлогоо нэгтгэмээр байна гэсэн ийм бас сана л байгаад байна.

Тэгэхээр саяын миний энэ асуултад Ариунболд дарга хариулъя. 2 номер.

Ж.Ариунболд: Нэгдүгээрт нь элсэлтийн бодлоготой холбоотой ямар ажлыг хийж байна вэ гэхээр нэгдүгээрт нь бид нар та бүхэнд түрүүн танилцуулсан элсэлтийн бодлоготой холбоотойгоор жил болгон элсэлтийн босго оноог тодорхой тоогоор нэмэгдүүлэх энэ ажлыг нэгдүгээрт нь хийж байн.

Хоёрдугаарт нь элсэлтийн шалгалтыг 2026 оноос эхлээд байгалийн ухаан болон нийгмийн ухаанаар багцалсан байдлаар авах ийм орсон, ийм журам гарчихсан байгаа. Байгалийн математик, физик, хими, биологи гээд багцалсан байдлаар байгалийн ухааны чиглэл, нийгэм, хүмүүнлэгийн ухааны чиглэлээр авах ийм бодлогыг барьж байгаа.

2024-25 оны хичээлийн жилд ЭЕШ-ыг жилд 2 удаа авдаг. Энэ ч гэсэн таны яг хэлдгээр цаашдаа олон авах ёстой. САТ-ын шалгалтыг Америкт жилд 7 удаа авдаг. Үүнтэй адилхан хүн өөрөө өгөөд л ингээд явдаг ийм бодлого байх ёстой гэж бодож байна.

Хоёрдугаарт нь докторын зэрэг хамгаалуулах зөвлөл дээр ямар асуудал үүсэж байна вэ гэхээр ер нь 2025 оны 1 дүгээр сараас эхлээд докторын зэрэг хамгаалуулах зөвлөл дээр 2 юм орж ирсэн юм. Нэг дэх нь бол докторын удирдаж байгаа, хамгаалуулах зөвлөлийн доктор удирдаж байгаа хүн бол өөрөө доктор удирдаж хамгаалуулсан байх ёстой гэсэн ийм 1 шалгуур орж ирсэн.

Хоёр дахь нь болохоор хэрвээ доктор удирдаагүй бол ямар нэгэн улсын болон олон улсын хэмжээний төсөл удирдсан байх ёстой гэсэн ийм шалгуур орж ирсэн. Тэгээд бид нар ингээд яах вэ 2024 онд явж байсан чинь энэ Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар гээд. Эндээс бол энэ докторын хамгаалуулах зөвлөл дээр чинь хуулиас давсан шалгуур тогтоосон байна гэдэг ийм юу бичиг ирсэн. Тэр нь гол зүйл нь юу байна вэ гэхээр сургуулиуд дээр дэд зөвлөл байгуулж болохгүй. Учир юу вэ гэхээр Дээд боловсролын болон Боловсролын ерөнхий хууль дээр дэд зөвлөл гэдэг ойлголт байхгүй байхад хуулиас давсан та хэд энэ шалгуур тавьсан байна гэдэг нэг асуудал.

Хоёрдугаарт нь Хамгаалалтын зөвлөлийн бүрэлдэхүүнд байгаа хүмүүст хууль дээр шаардлага тавиагүй байхад та хэд тусгайлан журмаар юу тавьсан байна, ийм шалгуур тогтоосон байна гээд. Тэгээд бид нар яг үүнтэй холбогдуулаад 6 их сургууль болон тэр 19 хамгаалуулах дэд зөвлөл байгаа сургуулиудтайгаа

уулзаад, саналыг нь аваад ингээд нэгтгэх ажлыг одоогоор ингээд хийгээд явж байгаа ийм ажил байна.

Гурав дахь нь бол ахисан түвшний бодлого. Энэ бол маш чухал. Манай Боловсролын яамнаас төрийн өмчийн их, дээд сургуулиуд дээр 6-7 үндсэн ийм чиглэл хүргүүлсэн. Ахисан түвшний сургуулиудын энэ асуудлыг цэгцлэх шаардлага байна. Энийг бид нар яг зөв ойлгомоор байна. Өнөөдөр ахисан түвшний сургууль гэдэг бол улс үндэстний өмнө томоохон судалгааны ажил хийж, хөрөнгө татдаг ийм сургуулиудыг хэлдэг. Манайд байгаа энэ ахисан түвшний сургуулиудын ихэнх нь доктор хамгаалуулж байгаа сургуулиуд байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл доктор хамгаалуулдаг л сургууль бий болгоод байгаа юм. Ахисан түвшний сургууль гээд. Тэгэхээр энийгээ бодлогоор өөр болгооч. Яг олон улсын жишигтэй та бүхнийг ойртуулж хараач гэдэг ийм чиглэлийг өгчхөөд явж байгаа.

Дараагийнх нь бол.../минут дуусав./

Ч.Ундрам: Хариултаа дуусгая. 2 номер нэмж хариул.

Ж.Ариунболд: Тэтгэлгийн бодлого яг түрүүн та бүхний яг хэлдэг саналтай бас сайд, манай бас яамныхан бас санал нэгтэй бид нар ярилцсан. Тэр нь юу вэ гэхээр ер нь Монгол Улсад энэ бакалаврын түвшний оюутнуудыг бэлтгэх асуудлыг улс өөрөө бэлддэг байя. Тэр магистр, доктор, пост докторын түвшний, ахисан түвшний тэр докторын түвшинд сурч байгаа оюутнуудыг бид нар бэлтгэх дээр бол нэгдсэн ийм бодлоготой байя гэдэг ийм зүйлийг яриад ихэнх Монголд бэлтгэж байгаа, энэ Монголд бэлтгэж чадахгүй байгаа энэ мэргэжлүүдийг гаднын их, дээд сургуулиудад бэлтгэж, Монголдоо өөрсдөө бэлтгэж чадаж байгаа бол үүнийгээ бол яг улс, үндэстэн өөрсдөө ингээд дотооддоо бэлтгэх нь чухал юм л гэдэг ийм яг саналтай явж байгаа.

Ч.Ундрам: Хэлэлцэж байгаа асуулт асуудалтай холбоотой үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Хэрлэн гишүүнээр тасалъя. Дамдинням гишүүн үг хэлье. Нэрсийн дарааллаар. Рэгдэл гишүүн үг хэлье.

Д.Рэгдэл: Баярлалаа. Эрт ирчихсэн учраас ингээд та нөхдийнхөө урдуур орчихлоо уучлаарай. Тэгэхдээ зэрэг өнөөдөр энэ батлагдаад хагас жил гаруй болж байгаа Боловсролын багц хуулийг хэрэгжилтийн тухай л сайдыг мэдээлэх байх гэж бодож орж ирсэн. Дамдинням гишүүнтэй санал нэг байна. Тэр мэдээлэл хийгдсэнгүй. Яах вэ дээд боловсролын шинэчлэлийн асуудлаа тойруулаад харин нэлээн сууж ярилаа.

Тэгэхээр энэ дээд боловсролын шинэчлэл ч юм уу, түрүүн ярилаа шүү дээ бид нар нэг юман дээр бүгд санал нэг байгаа. Дээд боловсрол, шинжлэх ухаан 2 дэлхийн жишиг рүү харж явж байж л энэ хөгжлийнхөө суурийг тавина, бодлого зорилтоо хэрэгжүүлнэ. Тэгэхээр бид нар дэлхийн жишиг рүү харж байж энэ ажлаа хийж явах нь их чухал юм.

Тэгэхээр зэрэг өнөөдөр сайдын оруулж ирсэн энэ 5 хуудас танилцуулга дээр дээд боловсролын шинэчлэлийн нэгдүгээр асуудал судалгааны их сургууль юм шиг оруулж ирж байгаа юм. Тэгэхээр та бүхэн би мэдэж байгаа байх гэж бодож байна энэ ажлын хэсгийг. Судалгааны их сургууль гэдэг бол их сургуулийн

хөгжлийн үе шат болохоос биш зохион байгуулалтын бүтэц биш дэлхийн жишгээр. Тодорхой түвшинд хүрсэн сургууль судалгааны их сургууль болдог дэлхийн жишиг байж байхад бид нар хүчээр тийм сургууль байгуулуулчих гээд үзээд байдаг. Ингэж болохгүй шүү дээ. Хүчээр сургууль байгуулж болохгүй. Үзүүлэлтээ хангаж байгаад судалгааны их сургууль болдог. Дэлхий дээр энэ жишиг жил болгон шилдэг судалгааны 10 их сургууль энэ тэр гээд л зарлаад байгаа шүү дээ Тэр чинь их сургууль. Тэгэхдээ судалгаа их хийдэг учраас ингэж зарлагддаг. Тийм учраас хүчээр их сургууль байгуулна гэдэг асуудлыг би дэмжихгүй байгаа. Энэ хөгжлийнхөө шатанд л бий болъё, болгох нь зөв юм гэж ингэж бодож байгаа.

Харин өнөөдөр тэгвэл дээд боловсролын салбарын хөгжлийг бид нар оюутны сургалтын төлбөрөөр үндсэндээ авч яваад байгаа явдал бол энэ хөгжлийн хамгийн том саад гэдэг дээр санал нэг байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ нэмэлт санхүүжилтийн асуудлаар Байнгын хорооны гишүүд сая Их Хурлын гишүүд маань бас тодорхой саналууд хэлж байна. Энэ их оюуны потенциал цуглуулсан их сургуулиуд маань орлого олдог чадавхтай байх ёстой. Үйл ажиллагаагаараа ч орлого олдог байх ёстой, сургалтын төлбөрөөс гадна тэр спонсор дэмжлэгээ ч олж чаддаг. Сая Батнайрамдал гишүүн маш тодорхой яриад байна шүү дээ. Ийм чадавх суух ёстой. Ингэж байж энэ чинь хөгжлийн тухай ярихаас биш улсын төсвөөр мөнгө авч байгаад сургууль хөгжүүлнэ гэж бодвол ингээд л суугаад байх болно. Энэ чинь хувийн сургуулиуд үүний чинь эсрэг Үндсэн хууль зөрчиж байна гэдэг асуудал тавьдгийг та нар мэдэж байгаа. Өмч ялгахгүйгээр төрийн дэмжлэг үзүүлэх ёстой шүү дээ. Тэгэхээр энэ чадвараа хангах талаар та нар маань анхаарч ажиллах ёстой.

Хоёрдугаарт, энэ сургалтын зээлийн сан гээд их чухал сан байгаа юм. Их асуудалтай. Тэгээд гол шүгэл үлээгч хүн нь захирал нь болчихсон болохоор цаашдаа бас ажлаа жигдрүүлэх талдаа нэлээн юм хийх байх гэж найдаж байгаа. Миний бодож байгаагаар энэ бакалаврын түвшний сургалтыг Монголдоо хийдэг чадавхтай болмоор байгаа юм. Тэгээд тэндээ энэ сургалтын зээлийн сангийн ихэнх хэсгийг тэр Монголд бэлдэж байгаа тэргүүлэх чиглэл гэнэ үү, ямар бакалавртаа өгч явдаг болж байж бид нар дээд боловсролын сууриа сайжруулна.

Гадаадад бол мэдээж хэрэг энэ мастер, докторын сургалт эд нарыгаа бэлтгэхэд ахисан түвшний мэргэжилтэн бэлтгэх энэ сургалтын зээлийн сангаасаа энд дэмжлэг үзүүлж явбал энэ бол хүртээмж нь сайжирна, дээд боловсролын хөгжилд ч нэмэр болох ийм талтай ийм юм байгаа.

Гурав дахь асуудал. Би юуг хэлэх гээд байна вэ гэвэл энэ багш бэлтгэх асуудал дандаа яригдаж байгаа. Тэгэхдээ зэрэг багш, их сургууль болгон тэр их сургууль коллеж гэдэг шатлал руугаа орсон ч ялгаа байхгүй, их сургууль коллеж болгон, 1 минут авчихъя.

Ч.Ундрам: Чухал юм ярьж байгаа учраас 1 минут нэмээд өгчихье Рэгдэл гишүүнд.

Д.Рэгдэл: Баярлалаа. Тэгэхээр их сургууль биш коллеж болгон багш бэлддэг болмоор байгаа юм. Би бас их сургууль төгссөн хүн л дээ. Тэгэхдээ Монгол Улсын их сургууль биш. Бид нар төгсөхдөө заах арга, сэтгэл судлал гэж баахан юм үзэж байгаад тэгээд хичээл заах дадлага хийгээд, би Оросын сургууль төгссөн л дөө. Оросын дунд сургуульд 1 сар хичээл заагаад заах аргын дадлага энэ тэр гээд бүгдээрээ шалгалт шүүлэг өгөөд тэгээд төгсөөд гараад ирэх дээр

зэрэг шууд багшлах эрхтэй гаргаад байгаа юм. Манайд одоо үнэхээр тэр суурь мэдлэгийг нь авчихсан хүнийг багш болгохын тулд бүтэн жил МУБИС дээр сургалт явуулах гээд үзээд байгаа юм. Энэ цаана нь бас мөнгөний сонирхол байгаад байгаа байхгүй юу. Тэгээд Наранбаяр сайдын 45 хоногийн дамжаагаар багш бэлдье гэдэг энэ санаачилгыг би их дэмжсэн л дээ. Тэгээд одоо 45 хоногийн дамжаагаа болиод сургууль болгон багш бэлддэг.../минут дуусав./

Ч.Ундрам: Баярлалаа. Ганбаатар гишүүн үг хэлье.

А.Ганбаатар: Баярлалаа. Өнөөдөр Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжилтийг ярьж байна л даа. Үйл явцын тэгээд бас шүүмжлэлтэй хандах юмнууд байгаа юм байна. Эхлээд хуулийн дагуу хэрэгжээд ч явж байгаа юмнууд байна. Тэгээд энийгээ хэмжээд танилцуулчихсан бол Англи хэлний хөтөлбөр нь ийм байна, ингээд ийм ийм гээд тийм хувь зэрэглэлтэй юмнууд цөөхөн яригдаж байх шиг байна. Ер нь бол Дамдинням гишүүн түрүүн дурдаад байсан энэ Боловсролын яам энэ яам чинь өөрөө нөгөө бодлогын яам учраас сайд заавал байх ёстой. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, сайд ингээд танилцуулга ингээд уншчихаад гараад явах шаардлагагүй. Бид нар тэртээ тэргүй уншчихсан байгаа энэ. Харин бодлогын газар энэ манай Боловсролын яамны мэргэжилтнүүд сайдыгаа цэнэглэж өгмөөр байгаа байхгүй юу. Цэнэглэж өгмөөр байгаа юм. Тэгэхээр цаашаа бид нар энэ хөгжилтэйгөө боловсролоо уях, энэ шинжлэх ухаан, боловсролоо хөгжилтэйгөө уях, мэдлэгийн эдийн засаг, мэдлэгт суурилсан эдийн засгаар Монгол хөгжинө гэж харж байгаа Боловсролын яам энэ реформын шинжтэй бодлогын санал оруулмаар байна л даа. Тэгээд үүн дотор байж байгаа болж байгаа юмнуудыг хэлэхгүй байгаа шүү. Зөв ойлгоорой. Миний хэлэх гээд байгаа санаа бол хэрвээ бакалаврын зэрэгтэй боловсон хүчнээ Монголдоо бэлтгэдэг ийм бодлого цаашаа хийх юм бол гадагшаа бакалаврын зэрэгт суралцъя гэсэн хүмүүсийн хүний эрхийг нь зөрчинө. Тэгэхээр ингэж хатуу хийж болохгүй. Тэгэхдээ яах вэ бодлогын хувьд нөгөө юугаар нь хийчхэж болно шүү дээ, гаднын сургуулиудын салбарууд бакалаврын зэрэглэл боловсрол олгодог ийм гаднын сургуулийн франчайзууд ороод ирвэл бас болж байгаа юм гэх мэтээр ингээд тийм системтэй бодлого харуулмаар байгаа юм.

Статистик судалгаанаас харахад энэ уул уурхай, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал ингээд цаашаа цаашаа манай тэргүүлэх чиглэлийн салбарууд байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр ямар тоо хэмжээний ямар шаардлагатай боловсон хүчнүүд Монголд хэрэгтэй юм бэ гээд энэ тоогоо гаргаж ирээд, гаргачихсан байгаа байх л даа. Тэгээд энэ салбарт боловсон хүчин авдаг,... хийдэг энэ компаниудтайгаа маш сайн уялдаж ажиллах ёстой. Ганц компаниудын жишээ хэлж байна. Баруунд тэгдэг биз дээ оюутнаар элссэн оюутан тэгээд ажлын байр нь бэлэн болчихсон тухайн компани нь тэр оюутнаа бойжуулаад цаашаа аваад явчихдаг.

Тэгэхээр энэ манайд хэр байдаг юм болоо? Дандаа гадаадад төгсөөд ирсэн хүмүүсийн араас хөөцөлдөх тэд нар нь ирэх эрхгүй ийм байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр хувийн хэвшлийн захиалгыг нэн тэргүүндээ тавиац. Монгол Улсын тэргүүлэн хөгжилд шаардлагатай боловсон хүчнийг хувийн болон улсын сургуулиуд нь бэлтгэх дээр ийм уялдаа холбоо дутагдалтай харагдаад байна. Судалгаа гэж хэлэх гээд байгаа юм.

Дараа нь энэ гадагшаа сургахаас гадна бас мөнгө төгрөг, хүн хүчний асуудал яригдах байх л даа. Олон улсын жишээ болж байгаа бүтэж байгаа жишээг татахад буруудахгүй. Катар, Унгар юу гэдэг юм, Япон, Солонгос гээд энэ бар болчихсон орон бол гадаадын сургуулиудын франчайзыг хийж байна шүү дээ. Тэгээд төр, хувийн хэвшилтэйгээ хамтраад том компаниудтайгаа өөрсдийнх нь чиглэлээр заавал иж бүрэн сургуулиа биш гэхэд тухайн салбарын чиглэлээр нь юу яаж болдоггүй юм уу франчайзыг байгуулж болдоггүй юм уу? Герман Монголын инженерийн сургуулийн сайн жишээ байж байна. Тэр болж байна гэх мэтээр ингээд сургуулиуд маань тэртээ тэргүй төрөлжчихсэн юм чинь энэ чиглэл рүү нь жоохон хөрөнгө мөнгө хаяад явбал яадаг юм бэ гэсэн ийм санаа байна.

Тэгээд төвлөрлийн асуудал өнөөдөр яригдахгүй ч гэсэн шууд холбоотой. Түрүүн дарга жишээ татаад хэлж байна. Энэ их, дээд сургуулиудыг хотоос гаргаж, салбар гэдэг юм уу орон нутагт нь, боломжтой газар нь салбарыг нь ч ядаж байгуулах юм энэ бид нарын утаа, түгжрэл үүний асуудлыг бас шийдэхэд давхар боловсон хүчний асуудлаас гадна ийм бодлогын асуудал хэрэгтэй харагдаад байна л даа. Тэгээд ахиад товчхон хэлэхэд Боловсролын яам яамны сайдад бодлогын шинж чанартай юм дахин боловсруулж тавих шаардлагатай цаг болчихсон байна гэж. Баярлалаа.

Ч.Ундрам: Ер нь гишүүд хэлж байна шүү Батжаргал даргаа, Ариунболд даргаа нэгдүгээрт, сайд нь байх ёстой. Өнөөдөр Засгийн газрын хурал маргааш хуралдах байсан нь өнөөдөр татагдчихаад ялт ч үгүй дуудагдаад явсан учраас Байнгын хороог 8.30-д бид нар зарласан юм. Тэгээд амжсангүй. Танилцуулга нэлээн хангалтгүй байна гээд гишүүд бас анхнаасаа хэлээд байна. Ер нь бид нар дахиж энийг Дээд боловсролын хуулийн хэрэгжилтийн асуудлыг ер нь ярих ёстой юм байна. Өнөөдөр хангалттай танилцуулга хийгдээгүй гэж үзсэн учраас. Ер нь гишүүдийн хэлж байгаа саналыг нэлээн сайн сонсож, тэмдэглэж аваарай гэж хэлмээр байна.

Дараагийн үг Эрдэнэбат гишүүн.

Д.Эрдэнэбат: Ер нь энэ их, дээд сургуулиудын талаар дэлгэрэнгүй дата мэдээллийг бид нарт авч байж ер нь дараа дараагийн хурлаар ерөнхийдөө асуулт асуугаад зовлон юу ярихаасаа илүү шийдэл хэдүүлээ яривал их байх. Байнгын хорооны гишүүд маань бас санал, шүүмж хэлээд байгаа нь эргээд энэ та бүгд л нэг талаар туслах гээд байгаа үүднээс нь л ингэж яриад байгаа гэж бас ойлгоорой гэдгийг хэлмээр байна.

Нөгөө талаар энэ хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлуудыг хийх ёстой. Сая тэгээд журам батлаагүй учраас судалгааны сургууль байгуулаагүй энэ тэр гээд л тийм тэгээд тэр нь хэн ч батлах ёстой юм, яамнаас болоод байдаг юм уу гээд ийм нэг талаараа тийм бүүр хүнд суртлын ийм төвөгтэй юмнууд оруулж ирчхээд журам батлаагүй учраас тэр яваагүй, энэ ингээгүй гээд байдаг чинь бас би хангалтгүй байна гэдгийг хэлмээр байна.

Ер нь энэ дээд сургуулийг юу яахад 10 жилээ төгсөөд ирчихсэн хүүхдүүдийг аваад ерөнхийдөө 4 жил ингэж байгаад гаргая гэдэг байдлаараа биш энэ 10 жилийн сургуулийнхаа боловсролын бодлоготой нягт уялдаж ажиллах ёстой, шаардлагатай. Байгалийн шинжлэх ухааны элсэгч нар байхгүй байна л гээд байдаг 10 жилд нь үндсэндээ энэ хичээлийг сонирхдог, энэ чиглэлээрх

мэргэжилтэй боловсон хүчин, техник, бааз нь байхгүй болчихсон учраас энэ яг л тийм байдал руугаа л орж байна л даа.

Тийм учраас энэ тал дээр энэ их ерөнхий боловсролынхоо сургуулиудынхаа, ингээд төрөлжсөн сургуулиуд байдаг, хуучин бол олон байгалийн шинжлэх ухааны анги, тийм төрөлжсөн сургуулиуд байдаг. Тэд нартайгаа хамтарч дэмжиж ажиллах, боловсон хүчнүүдийг нь дэмжиж өгөх тал дээр их, дээд сургуулиуд маань ажиллаж байж л цаашаа явах болов уу гэж би бодож байна.

Тогтмол зардлыг дэмжиж байсан. Би ч гэсэн дэмжиж байсан гишүүний нэг. Одоо энд байгаа Ундрам гишүүн, Дамдинням гишүүн эд нарт санал өгөөд л энэ их, дээд сургуулиуд чинь төлбөрөөс хараат, төлбөрийг нэмж чадахгүй учраас багш нар цалин бага, гайгүй багш нараа овоо бэлдэж байгаад алдаад явуулчихдаг байсан. Тийм учраас энэний гол юу нь нэгдүгээр болохлоор оюутнууд руу чиглэдэг, багш, ажилчдын цалин, нийгмийн асуудал руу түрүүн ШУТИС-ийн ректорын хэл үү, үгүй юү цалингаа бас ингээд нэмлээ гэж. Тэр бол зүйтэй байх. Тэгэхгүй бид нар хоёрын хооронд юман дээр хэмнэж байгаад тэгээд олон жил бэлдсэн багш, боловсон хүчнүүдээ алдаа туугаад явуулчихдаг. Тийм учраас энэ тал дээр юу байгаа.

Зарим сургуулиуд дээр бас очоод ажилласан бас хангалтгүй байлаа шүү. Тэр багш ажилчдад өөрсдөө их хаалттай байдаг юм уу, тэр ажилчидтайгаа уулзах, ярих, тэр хамтын гэрээ хэлэлцээрийн юмаа шийдэх, дотоод засаглал бас жоохон асуудалтай байна. Багш, ажилчдаас ч гэсэн нэлээн бас санал гомдлууд ирдэг. Энэ тал дээр та бүгд маань анхаарч ажиллаарай гэдгийг хэлмээр байна.

Нэг зүйлийг бас тодруулж хэлэхэд энэ оюутны эрүүл мэндийн асуудал дээр нэлээн анхаарал хандуулахгүй бол бас болохгүй болчихсон юм байна лээ. Оюутнууд маань үндсэндээ өөрсдөө сайн дураараа гэдэг, төлдөг хүн байдаггүй, тэгээд эмнэлэгт үзүүлдэг хүн байдаггүй. Сайн сургууль, боловсрол төгсдөг, эрүүл мэндийн хувьд цэргийн юугаар эрчүүд нь очоод үзүүлэхэд маш хангалтгүй гээд эмч нар ярьж байна лээ. Энэ оюутнууд чинь эрүүл мэнд ерөөсөө тун аюултай байдалд ирчихсэн юм байна гэж.

Тийм учраас энэ их, дээд сургуулиудын бас асуудал энэ оюутнуудын тэр төлбөр дотор нь шингээж авдаг байна уу, бас тодорхой хэмжээгээр тэгж авч зохион байгуулахгүй бол болохоо байчихсан юм байна лээ.

Дараагийн нэг асуудал нь энэ мега төслүүд дээр ингээд л ТЭЗҮ, боловсруулах, судалгаа хийх, ингэх, тэгэх гээд л манай энэ яамнууд маань хэчнээн тэрбумаар нь л оруулж ирээд л батлуулаад л байгаа. Манай энэ судалгаа шинжилгээ их, дээд сургуулиуд энэ юунууд яачихсан юм? Янз бүрийн ТЭЗҮ, элдэв янзын юм хийхээр л ерөөсөө гаднын компаниуд гээд л хэдэн тэрбумаар, авто замын түгжрэл гээд л гэхэд 50 тэрбумын ТЭЗҮ гээд л батлуулаад авч байгаа байхгүй юу. Тэгэхээр манай энэ чиглэлээр бэлтгэчихсэн боловсон хүчнүүд ядаж наад талын суурь судалгаа, ТЭЗҮ-гийн энэ чиглэлээр тэр судалгаа, эдийн засагжуулах чиглэлээр нь өөрсдийгөө бэлдэхгүй бол. Бид нарт боломж, бололцоо бас байгаа. Энэ төсөв дээр хүртэл энэ та бүгд маань энэ ажилладаг уу ер нь? Ирэх жилүүдийн төсөв дээр орж ирэх гэж байгаа юмнууд байна, энэ хэсгийн судалгаанууд байна, ийм их, дээд сургуулиуд нийлээд бид нар авчихъя. Тэгээд энэ төсвөөс 6 тэрбумын ашиглалтын зардал нэхээд сууж байхынхаа оронд бид

нар ийм судалгааг нь хийгээд өгөх учраас энийг нь хуваагаад бид нар авъя гэдэг ийм санал оруулаад ирвэл бид нар ч гэсэн дэмжээд эргээд тэр эрдэм шинжилгээ, судалгаа хөгжих юм руугаа зарцуул гэдэг.../минут дуусав./

Ч.Ундрам: Энэ мега төсөлтэй холбоотой том том төсвүүд бол ер нь нэлээн байгаа. Тэгээд э энэ мэргэжлийн зөвлөлүүд байгаа шүү дээ барилга, замын чиглэл, уул уурхай. Энд ШУТИС-ийн багш нар л ер нь сууж байдаг юм шүү дээ. Тэгээд бүгдээрээ компанитай хувийн, энд тэнд ийм хам хамаарал бүхий компанитай. Тэд нар нь энэ төслүүдийг авч байгаа энэ багш нар. Сургуульд бол орлого орохгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр нь тэр харилцааг сургуулийн удирдлага бас бодох ёстой шүү. Яах ёстой юм? Хэрвээ сургуулиас цалин аваад, сургуулийн нэр хүндийг ажил, амьдралдаа ашигладаг бол сургуулиараа тодорхой төсөл заавал оруулж ирэх ёстой. МУИС-д профессор больё гэж байгаа хүн заавал гаднаас төсөл оруулж ирсэн байх ёстой гэсэн журамтай байдаг.

Тэгэхээр ШУТИС ч гэсэн журмаа тэгж өөрчилж, их сургуульдаа мөнгө авчирдаг хүн профессор гэдэг нэр хүндийг зүүх ёстой байхгүй юу. Тэгэхгүй их сургуулиа идэж амьдардаг паразит профессор гэж байж болохгүй. Тийм, тэгэхээр энийг бусад их сургуулиуд ч гэсэн анхаарах ёстой. Мөнгө авчирдаг хүн профессор байдаг юм. Авчирч чадахгүй хүн бол ахлах багшаа хийгээд явж байсан нь дээр. Тэгэхээр ийм зүйлийг бас бодолцох ёстой шүү.

Дараагийн үг Хэрлэн гишүүн.

Б.Хэрлэн: Би хоёрхон асуудал дээр тогтож ярья. Түрүүн Ариунболд дарга хэллээ л дээ. Ерөнхийдөө судалгааны их сургууль болно гэвэл ер нь олон улсын жишгээр санхүүжилтийн бараг 70-80 хувь нь төрөөс байгаад байдаг гээд байсан. Тэгсэн үү? Би тэгж ойлгосон уу тээ? Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол яг Монгол Улсад судалгааны их сургуулийг бий болгоё гэх юм бол энэ их, дээд сургуулиудын санхүүжилтийн энэ хуульд бас өөрчлөлт орох нь. Бүүр бараг жаахан цаашаа харах юм бол бараг Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, яг судалгааны их сургууль болгоно гэх юм бол төрөөс санхүүжилтийг нь хариуцчихдаг болгоно гэх юм бол бүүр бараг Үндсэн хуульд өөрчлөлт орохоор их хэмжээний тэр ийм зүйл хэлж байна лээ л дээ. Тэгэхээр үнэхээрийн одоо яг байгаагийн өнөөдрийн нөхцөл байдал угаасаа өөрийнхөө үйл ажиллагаанаас 100 хувь санхүүжээд явж байгаа тохиолдолд багш, оюутны харьцаа бол бакалаврынх нь сургалтын төлбөрөөрөө амьдарна, багш оюутны харьцаа эрс ялгаатай байна. Яг энэ утгаараа судалгааны их сургууль болох, ахисан түвшний сургалт явуулах, судалгаа, шинжилгээ хийх бол үнэндээ боломжгүй болоод явчихна гэсэн үг.

Тэгэхээр асуудлыг чинь бүүр ингээд угт цаанаа аваад үзэх юм бол энэ санхүүжилтийг чинь8 санхүүжилтээ шийдэхтэй холбоотой энэ дээрээ гол анхаарлаа ер нь цаашдаа ер нь хандуулаад явбал яасан юм бэ. Яагаад энэ хамтарсан засгийн үед том том асуудлыг шийддэг шиг, шийдээд явж байгаа шиг яагаад яг боловсролын яг энэ амин чухал юман дээр энэ дээр жаахан ийм дорвитой өөрчлөлт хийчхэж болохгүй гэж? Ийм зориг байж болох уу? Энийг би нэгдүгээрт, асуумаар байна.

Хоёрдугаарт ер нь их, дээд сургуулиуд тэр ахисан түвшний сургалт буюу магистр, докторын сургуульд нэлээн бас асуудалтай байгаа тухай сая бид нар ингээд ярьж байна шүү дээ тээ? Тэгэхээр энэ бүх юм эцсийн дүндээ ердөөсөө би багштай холбоотой л гэж бодоод байгаа л даа. Багш бол сайн багш байх ёстой,

сайн судлаач байх ёстой. Тэгээд эрдэм шинжилгээнийхээ бүтээлээ сайн хэвлүүлж чаддаг байх ёстой. Сая Ундрам даргын хэлж байгаагаар бас тодорхой хэмжээгээр улстай болоод олон улсын түвшиндээ бас хүлээн зөвшөөрөгдөж өөрийнхөө сургуульд бас тодорхой хэмжээний төсөл, хөтөлбөрүүдийг татаад чангаагаад аваад ирэхээр хэмжээний ийм чадвартай хүн байх ёстой.

Тэгэхээр энэ хүнийг хөгжих гол эх үүсвэр нь ердөөсөө л мөнгөтэй холбоотой буюу судалгааны их сургуулийн санхүүжилттэй холбоотой болох гээд байна. Тэгэхээр энэ асуудлыг бүгдээрээ хамтдаа ярьж үзэж болох уу гэж би нэгдүгээрт хэлмээр байна.

Хоёрдугаарт нь өнөөдөр дээд боловсролын асуудлыг ярихад чинь тэр коллежийн сургалтын асуудал бас өнөөдөр бид нар огт хөндсөнгүй шүү дээ. Тэгэхээр хувийн их, дээд сургуулиуд, дээр нь коллежийн асуудлууд гээд ингээд их олон юмнуудыг бид нар хамарч бас энэ дээд боловсролын асуудлын хүрээнд ярих байх. Тэгэхээр магадгүй яг энэ Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжилтийн асуудал дараа дараагийн өшөө олон удаагийн уулзалт, хурал цуглааныг бас хэрэгтэй болж байх шиг байна. Тэр дээр өшөө их нарийн асуудлууд гарах байх. Тэгээд тэр үед нь тогтож ярья.

Гурав дахь нэг юм. ЕБС-ийн багшийн нийгмийн асуудал, цалин хөлсний асуудал аягүй гайгүй сайн шийдэгдээд явчхаж байгаа юм. Гэтэл дээд боловсролын сургуулийн багшийн хүүхэд яагаад ЕБС-ийн багш шиг хүүхэд нь их, дээд сургуульд сурах тийм боломжоор яагаад хангагдахгүй байгаа юм? Яагаад хөдөө, орон нутагт ажиллаж байгаа тэр их, дээд сургуулийн багшийн цалин хөлс 40 хувиар ч гэдэг юм уу, 20 хувиар ч юм уу нэмэгдэх боломж байхгүй байгаад байгаа юм бэ? Тэгэхээр энэ дээд энэ боловсон хүчний асуудлыг бас яг жигд сайн анхаарахгүй бол болохгүй нь.

Өнөөдөр ерөнхийдөө яг хөдөлмөрийн зах зээл дээр ингээд дээд боловсролтой боловсон хүчнүүдийн ингээд цалин хөлсийг ингээд харьцуулаад аваад үзэх юм дээд сургуульд ажиллаж байгаа багшийн цалин би их дээшээ явахгүй байх. Тэр битгий хэл бараг ер нь автобусны жолооч, аягүй бол гудамж цэвэрлэж байгаа ажилтны цалингийн дайны цалин аваад явж байж бас магадгүй шүү дээ. Тэгэхээр яагаад оюуны хөдөлмөрийг ингэж хямдхан үнэлээд байгаа юм бэ гэхээр энэ асуудлыг бид нар бас ер нь бодож, гаргаж ирж тавихгүй бол алсдаа их сургуульд багшлах багш олдохгүй болж магадгүй шүү л гэж би хэлмээр байна. Болсон.

Ч.Ундрам: Хэрлэн гишүүн түрүүнээс хойш энэ багш нарын нийгмийн баталгаа, цалингийн асуудлыг яриад байгаа. Тэгээд ирэх жил ЕБС төгсөгчийн тоо нэлээн их байгаа. Өндөр байгаа. Хэдэн мянга байгаа билээ? 47 мянга тэгээд өшөө өсөөд явчихна. Тэрнээс хойш өсөөд явчхаж байгаа. Эрэлт бол нэлээн нэмэгдэж байгаа. Тэгэхээр эрэлтийг дагаад үнэ яах билээ? Бүгдээрээ их сургууль удирдах зөвлөлөөрөө тодорхой асуудлуудаа оруулах ёстой. Өнөөдөр зарим их сургуулийн сургалтын төлбөр зарим хувийн цэцэрлэгээс доогуур байгаа шүү. Тэрийг та хэд маань бодолцоод, тодорхой хэмжээнд өөрсдийнхөө зардал, багшийн цалингаа бодоод энэ дээр өөрчлөлт хийх ёстой шүү.

Мэдээж төр сайн чадварлаг хүүхдүүдэд тэтгэлэг өгөх ёстой. Хүнийг онц сурах чадвартай хүүхдэд татвар төлөгчдийн мөнгийг зарцуулах ёстой шүү дээ.

Чадваргүй хүүхдийг толгойг нь илж бас болохгүй. Тэгэхээр энэ тал талын энэ бас санхүүтэй холбоотой бодлогоо та хэд маань ярьж цэгцлээрэй гэж хэлмээр байна.

Батнайрамдал гишүүн үг хэлье.

О.Батнайрамдал: Баярлалаа. Тэгэхээр боловсролын бас томоохон шинэчлэлийг авчрах багц хууль батлагдсан. Тэгэхээр тэрний бас амин сүнс нь Дээд боловсролын тухай хуулийн хэрэгжилтийг яг үнэнийг хэлэхэд өнөөдөр аягүй хангалтгүй байлаа гэж миний хувьд дүгнэж байна л даа. Яг үнэнийг хэлэхэд ийм том хуулийн хэрэгжилт, үүний ард чинь бид нар 150 мянган оюутны амьдрал ярьж байгаа шүү дээ. Тэрний ард нь 300, 400 мянган аав, ээж нарын асуудал байхгүй юу.

Тэгэхээр Монгол Улсын ирээдүйг тэр чигээр нь тодорхойлох ийм том салбарын хуулийн хэрэгжилт 5 слайд дотор багтаад, тэн дотор бид нар ингээд асуудлаа ярина гэж байхгүй. Тэгэхээр энийгээ маш сайн бэлдэж дахин орж, дахин ээлжит бус зарлаад ч хамаагүй үүнийг бид нар ярилцах ёстой гэж бодож байгаа.

Дээрээс нь бас нэг асуудал бол түрүүн хэлсэн аудитын дүгнэлт гарч байна, тэр аудит. Яг үнэнийг хэлэхэд Монголын явж явж энэ институт дотроос аудит хамгийн сайн ажилладаг нэртэй юм байна лээ шүү. Ажлаа бол яс хийдэг. Тэр нь хамгийн гол нь хэрэгжилтийг нь шаардахгүй, хэрэгжилт нь хийгдсэн үү, үгүй юу гэдэг дээр Засгийн газрын зүгээс ер нь маш хангалтгүй ажиллаж ирсэн юм байна лээ. Үүний хамгийн тод жишээ бол Боловсролын зээлийн сан шүү. 10 жилийн турш Боловсролын зээлийн сан дээр ямар асуудал байсныг аудитын жил болгоны санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитаар бүх дүнгүүд нь бүр яг нэр устай бүх юм нь гардаг байсан.

Харин энийг тухайн үедээ боловсролын үе үеийн сайд нар энийг ажил болгож хэрэгжүүлээгүйн улмаас өнөөдөр яг үнэнийг хэлэхэд хөндлөнгөөс миний хувьд ч гэсэн тэнд бас шүгэл үлээж сууж байна. Хөндлөнгийн хүмүүс гарч ирж шүгэл үлээж энэ асуудлыг гаргаж ирж байгаа шүү дээ. Тэр аудитын дүгнэлтээр тэр асуудлуудыг шийдээд шийдээд явсан бол өнөөдөр бид нар ийм асуудалд орохгүй л байсан.

Тийм учраас энэ аудитын дүгнэлттэй холбоотой хэрэгжилтэд сайд анхаарлаа хандуулж энэ дээр бид нар бас хариуцлагатай хандах ёстой гэж бодож байгаа юм.

Боловсролын асуудал гэдэг яг үнэнийг хэлэхэд их эмзэг асуудал байхгүй юу. Ялангуяа дээд боловсрол байна. Яагаад гэх юм бол энэ 150 мянган хүүхдийн сургалтын төлбөрийг нь хэдэн аав, ээж нь л насаараа хуримтлуулж олсон хэдэн төгрөгөө, эсвэл банкны зээлийн хүүд өгч байна. Эсвэл хэдэн хүүхдийнхээ боловсролд зарцуулж байгаа байхгүй юу.

Тийм учраас үүнийг ингээд нэг асуудлаар ч юм уу ингээд л толгой илээд өнгөрөх ерөөсөө асуудал ерөөсөө биш. Энэ ингээд ард нь маш олон 150 мянган суралцагч шүү дээ тээ? Тэгээд тэр дундаа яг төрийн их, дээд сургуулиуд дийлэнхийг нь авдаг. Тийм учраас энэ дээр бид нар маш хариуцлагатай хандах ёс.

Дээрээс нь энд гол гол ректорууд бүгдээрээ сууж байна. Тэгэхээр ер нь их сургуулийн менежментийн гүйцэтгэлийг бас нэг зүйлтэй уях ёстой юм. Тэр

хүүхдүүдийг бакалавр, магистр, доктор болгоод төгсгөж байгаа нь ажлын 50 хувь шүү. Гүйцэтгэлийн тэр Кэй Пи Ай-ын 50 хувь нь юун дээр үндэслэх ёстой гэдэг юм бол тэр төгссөн хүүхдүүд ажилд орсон уу, үгүй юү гэдэг нь тухайн ректорын, тухайн менежментийн яг хамгийн гол Кэй Пи Ай-ийн байх ёстой байхгүй юу.

Тэгэхээр энийг бид нар Кэй Пи Ай тэр гэрээн дээр нь тусгаад өгчих юм бол яг их сургуулиуд хоорондоо тэр хүүхдүүдээ ажилд оруулж өгөх гээд Карьер хөгжлийн төвтэйгөө уяад, тэр хэдэн компаниудыг авчраад хэдэн хүүхдүүдээ сурталчлаад, тэр аж ахуйн нэгжүүдэд шаардлагатай яг тэр ангийг нь ч юм уу, тэр дадлагыг нь ч юм уу хийлгэх гээд ингээд хоорондоо өрсөлдөөд явж байх ёстой байхгүй юу. Энэ бол зүгээр хүүхдүүдийг ажилд оруулж өгөх асуудал биш юм байгаа юм. Энэ хэрвээ зөв механизм, зөв ажиллаж чадах юм бол та бүхэн зөвхөн төсөв, тэдэн хүүхдийн сургалтын төлбөрөөс гадна маш том орлогын эх үүсвэрээ баталгаажуулж урт хугацаандаа авах маш том сувгийг нээж чадах байхгүй юу. Энэ Монголын дээд сургуулийн хамгийн том шинэчлэл. Дараагийн жилдээ энэ байх юм шүү. Энийг Америк хамгийн сайн хийж чадсан. Хамгийн сайн хийж чадсан сургууль нь Харвард байхгүй юу. 50 тэрбум долларыг өнөөдөр Харвард индаментдаа төвлөрүүлж чадсан шүү дээ. Зөвхөн хувийн сургуулиуд биш төрийн.../минут дуусав./

Ч.Ундрам: Индамент сангийн асуудлыг анх удаа хуульд сая Боловсролын багц хуулийг шинэчилж батлахад оруулж өгсөн байгаа. Тэгэхээр их сургуулиудад энэ маш том боломж. Сайн туршлагауд байгаа талаар сая Батнайрамдал гишүүн хэлж байна. Тэгээд индаменттай холбоотой журам ч гэсэн яаман дээр өнгөрсөн 4 жилийн Засгийн газар батлаад ингээд хэрэгжих боломж бүр бүрдчихсэн байгаа шүү. Тэгэхээр их сургуулиуд, мөн дээд боловсролын газар энэ дээр нэлээн сайн анхаарч ажиллах ёстой.

Алтаншагай гишүүн үг хэлье.

Н.Алтаншагай: Энэ их, дээд сургуулийн боловсролын манай Монголын дээд боловсролын энэ систем л бүрхэг харагдаж байна шүү. Энэ 70, 80 ондоо л үлдчихсэн л байх шиг байгаа юм бид нар. Үүнийг дорвитойхон системийг нь шинэчилж өөрчилж, олон улсын жишиг рүү, дэлхийн жишиг рүү ойртохгүй бол энийгээ дагаад Монгол Улсын хөгжил ч гэсэн яг л хойшоогоо л явна. Өнөөдрийн энэ танилцуулга хангалтгүй, маш муу. Би аягүй өндөр хүлээлттэй байсан.

Тэгээд энэ гаднын их, дээд сургуулийн салбарыг оруулж ирэх тал дээр бид бүхэн бас эрэлхийлэх ёстой юм байна. Монголд анхны энэ ерөнхий боловсролын Финляндын франчайз сургууль ороод ирлээ шүү дээ. Тэр 12 жил сураад төгссөн сурагч үнэхээр маш сайн боловсон хүчин болж бэлтгэгдэнэ. Тэгэхээр энэний их, дээд сургуулиудыг оруулж ирэх тал дээр бас дорвитойхон хөдлөх бодлого гаргах хэрэгтэй.

Тэгээд боловсролын зээлийн санг нь нөгөө алдарт яригдаад байгаа ил тод, нээлттэй болгоод залуучуудаа Монголдоо энэ гадаад боловсролыг эзэмшье л дээ, инженерүүдээ, эмч нараа, багш нараа бэлдье л дээ. Энэ дээр үнэхээр дорвитойхон шинэчилье гээд цаашдаа явахгүй өдөр хоногийг аргацаасан, нэгэндээ тохсон, ацагласан энэ байдлаар ингээд өдрөөс өдөрт л бид бүхэн энэ дэлхий ертөнцөөс хойшоогоо 1, 1 алхмаар ухрахаар байна. Ажлын хэсгийг шинээр бас дахиж гаргадаг юм уу сайд энэ яаман дээр энэ бодлогынх шүү дээ. Аж ахуй руугаа бас их оролцоод байгаа шүү. Энэ бодлого боловсруулах, энэ бодлого гарах

яам маань аж ахуй руу оролцоод л, сургууль, цэцэрлэгийн эрхлэгч нартай томилгоо дээр ноцолдоод л, сургууль, цэцэрлэгийн ширээ, сандал, хүүхдийн орны даавуу тендер худалдан авах ийшийгээ л оролцоод байгаа юм. Яаж энэ дэлхийн энэ том сургуулиудтай харилцаа холбоо тогтоох вэ, яаж энэ хөтөлбөрийг Монголын хөрсөн дээр буулгах вэ гэдэг дээр онцгойлон анхаарах ёстой. Энэ чиглэлээр том том бодлого гаргаасай гэж бодож байна.

Тэгэхгүй бол энэ нийгэм маань бас маш харанхуй байна шүү. ЕБС суурь мэдлэгээ сайн аваад их, дээд сургуульдаа ороод ингээд уялдаа холбоотой байх юм нэг л ийм заагтай болчихсон. Тэгээд энэ их, дээд сургуульд суралцаж байгаа 150 мянга орчим оюутан байна. Үүний 8.5 хувь нь л хөдөө орон нутагт байна. Хөдөө орон нутгийн энэ их, дээд сургуулиудынхаа энэ салбаруудыг улам чадавхжуулаад, чадваржуулаад хөдөө орон нутагт энэ суралцагчдыг 20-25 хувь болгомоор байна шүү дээ бид бүхэн. Тэрийгээ дагаад тэр тухайн орон нутгийн бүсийн эдийн засаг хүртэл дагаад хөгжинө шүү дээ. Хотын түгжрэл буурна, хотын ачаалал багасна. Нөгөө бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал чинь яг энэнтэй таарч байгаа. Энэ бүсүүд дээрээ энэ сургуулиудаа улам сайн шинэчлээч. Би Анагаахын салбар сургуулийг Дорноговьд байдаг байх, өөр байхгүй тээ? Дархан, Говь-Алтай багшийн сургууль юун дээр байгаа Ховдын Багшийн их сургууль, Архангайд байгаа. Баян-Өлгий. Хөдөө аж ахуйн сургууль бий юу салба? Дархан, Баянхонгор. МУИС-ийнх, Эрдэнэтэд байдаг тийм ээ? Ховд, Дорнод. Өшөө ингээд төрөлжүүлээд нэммээр байгаа юм. Хувийн их, дээд сургуулиудын салбар нээгдэхэд бас болохгүй юм байхгүй гэж бодож байгаа юм. Энэ дээр та бүхэн томоохон дорвитой бодлого гаргаач.

Энэ коллежийг ерөөсөө яригдсангүй. Хувийн коллежууд маш ихтэй. Энийг яаж бид бүхэн төрөөс дэмжих юм? Жинхэнэ нөгөө ажилчин ангийг маань бэлдэж байгаа шүү дээ.

Ч.Ундрам: Гишүүддээ хэлэхэд ирэх долоо хоногийн 2 дахь өдөр үдээс өмнө ШУТИС дээр ажиллана. Үдээс хойш Хөдөө аж ахуйн их сургууль дээр ажиллахаар ажлын төлөвлөгөө гарч байгаа шүү.

Дамдинням гишүүн үг хэлье.

Г.Дамдинням: Гишүүдтэйгээ санал нэг байна. Танилцуулга бол тун хангалтгүй. Тун хангалтгүй. Боловсролын багц хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулиуд бол муу хууль гараагүй юм шүү дээ.

Монголын боловсролын тогтолцоог цогцоор нь авч байж үзэж араа шүдийг нь тааруулаад бас дэлхийн түвшин рүү ойртуулчих хэмжээний үүд хаалгыг нь нээж өгөөд, их, дээд сургуулиуддаа эрх чөлөөг нь олгочихсон л ийм хууль байгаа. Хэрэгжилт чухал байхгүй юу. Хэрэгжилтээ л сайн хийх хэрэгтэй байгаад байгаа юм.

Харамсалтай нь яамныхан маань ялангуяа энэ удирдаж байгаа хүмүүс нь хуулийнхаа үзэл санаа, зүйл, заалт яаж хэрэгжих ёстой талаар нь санаа бодол, ойлголт нь хүрэхгүй байгаа юм уу даа. Яаж байгаа юм мэдэхгүй байна. Танилцуулгын байдлаас харахад бол тэгж л харахаар байна. Олон ч гишүүн хэлж байна шүү дээ хангалтгүй байна. Анх хуулийн хэрэгжилтийг хангуулах ёстой. Хуулийн хэрэгжилтийг хангуулах, салбарын бодлогыг барих, салбарыг бодлогын

түвшинд төрийн эрх барих дээд байгууллагад ажиллах газар бол Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Төрийн хамгийн дээд бүтэц нь бол энэ юм байгаа юм. Энэ юм. Түрүүн би бол асуулаа шүү дээ. Боловсролын тогтолцоонд энэ Англи хэлийг оруулах дээд боловсролын түвшинд юу болоод байгаа юм? Их, дээд сургуулиудын ранкийг зарлах гэхтэй зэрэг хүмүүс орж ирээд гомдол тавилаа гээд хууль хэрэгжүүлэхгүй байгаа байдлууд яригдаж байна.

Ерөнхий боловсрол болон дээд боловсролын тогтолцоонд энэ гаднын нэртэй реклам хийж аав, ээжүүдийг худлаа ярьж хулхидаж байдаг сургуулиудад, эсвэл үнэн бодитой хийгээд байгаа үгүйг нь үнэлүүлээд тэрийг нь зарлуулдаг ажлууд хуулийн энэ заалтууд хэрэгжих ёстой. Энэ байхгүй. Энэ жалгаар байгаа судлаачид нэртэй докторуудынхаа эсвэл энэ судалгааны ажлуудынхаа чанар, үнэлэмжийг бид нар мэддэггүй. Шинжлэх ухаан, технологийн сан гээд сан байна. Бараг хавтсыг нь солиод л өгөөд л мөнгө авчихна. Эргээд ярьдаг юм юу ч байхгүй. Тэгээд л мундаг эрдэмтэд гээд. Сайн эрдэмтэд байгаа.

Гэхдээ энэ гажуудал байгаа шүү дээ. Сургуулийн нэрээр мөнгө олж байна л гээд л ярьж байна. Үгүй тэр хүмүүст буруу байхгүй шүү. Тэр хүмүүстэй хамтарч ажиллах ажлыг л энэ салбар өөрөө хийж явах ёстой байхгүй юу. Ёс зүйн зөвлөл гэдэг юм түр хугацааны зөвлөл биш. Байнгын ажиллагаатай бүх их, дээд сургуулиудаасаа зардал гаргаад бүх судалгаанууд дээр ёс зүйн зөвшөөрөл авч байж судалгаа хийж байдаг, дэлхийн их, дээд сургуулиудад байдаг загварыг хуульд хийж өгсөн байхгүй юу. Яамных нь ойлгож байгаа байдал бол хэдэн докторын зөвлөл томилоод л тэр нь ёс зүйн зөвлөл гэж хараад байх шиг байна. Үгүй л дээ. Хуулиа нэг мөр ойлгомоор байгаа юм. Зөндөө танилцуулгууд хийсэн шүү дээ бид нар.

Тэгээд л их л юм сонсогдох юм даа. Сая Алтаншагай гишүүний хэлээд байгаатай ойролцоо. Намын харьяалалтай баахан цахим байгууллагуудыг аймаг, орон нутгууд руу шахлаа ч гэх шиг янз янзын юмнууд сонсогдоод байгаа шүү. Энийгээ больцгоож үзээрэй. Тэгээд би ер нь өмнө нь энэ Боловсролын ерөнхий хуулийг тэр чигт нь хэрэгжилтийг нь эрчимжүүлэх чиглэлийн ажлын хэсэг байгуулъя гээд саналаа өгчих нь өгчихсөн байсан юм даргаа. Одоо хэдүүлээ энэ танилцуулгыг сонссоныхоо хүрээнд тэр ажлын хэсгээ шууд тогтоолоороо байгуулаад араас нь шахаад явчихъя Байнгын хороо ажлаа хийгээд. Би санал гаргаж байна. Надаар ахлуулчих. Энд байгаа гишүүд оролцоно биз. Тэгээд хэдүүлээ энэ урт хугацаанд Байнгын хороо өөрөө бодлогоо бариад явъя тэгэх үү? Тэгээд энэ тогтоолын төсөл хэлэлцэх санал гаргаж байна гишүүд ээ.

Ч.Ундрам: Санал хураалт явахаар боллоо шүү. Сая горимын санал гаргасан учраас. Тэгэхээр Саранчулуун гишүүн үг хэлчхээд тэгээд санал хураалт явах нь байна.

О.Саранчулуун: Асуултдаа түрүүн хариулт авсны дагуу бас дахиад хэдэн санал хэлмээр байгаа. Ер нь зүрх сэтгэлийн боловсрол дээр хүнлэг байх, нийгмийн олон талт харилцаанд ажиллах чадвартай мэргэжилтнийг бэлдэх нь гэдэг нь олон улсад сайн жишээгээр үзэх юм бол хичээлийн хөтөлбөрийн интеграцлал хэрэгтэй байгаад байна. Дээрээс нь практик сургалт үйл ажиллагаагаар дамжуулан оюутныг төлөвшүүлэх хэрэгтэй гэж байгаа. Жишээлүүлэх юм бол энэ дотор амьдралын ур чадварын сургалт, сайн дурын үйл ажиллагаа, тэгээд сэтгэл зүйн зөвлөгөө гээд. Тэгэнгүүт харилцааны ур чадварыг

хөгжүүлэх дээр багийн ажил, харилцааны ур чадвар гээд энэ дээр ба заавал нэмэгддэг нэг зүйл юу вэ гэхээр сургууль дахь тэр эерэг орчин маш чухал байдаг.

Дээрээс нь эерэг орчин гэдэгт нь тэр оюутны клуб, хамтын ажиллагааны тэр уралдаан тэмцээн зэргүүдийг нэмээд технологийн хэрэглээг нэммээр байгаа юм. Технологи дотроо дижитал платформ болон оюутнуудад зориулсан мэргэжилтнүүдийн лекц, сургалтын видеог сургуулийн цахим орчиндоо байршуулах ийм ажлуудыг хийх хэрэгтэй байна.

Нөгөө талдаа сургалт явуулах багш нарын чадавхыг сайжруулах хэрэгтэй байгаад байгаа. Яг энэ чиглэлийн хичээл заадаг багш нар мэргэжлийн зөвлөхүүдээ ажиллаад эргээд жил болгон их сургуулиуд оюутныхаа энэ асуудлыг үнэлгээ хийдэг болъё. Ингэх юм бол бид нар хүнлэг, ёс суртахуунтай иргэнээ бэлдэх энэ боловсролын хуулийн 2 хуульд заасан заалтуудын хэрэгжилт илүү жинхэнэ утгаараа л хэрэгжих учиртай байхгүй юу.

Тэгэхээр саяын их, дээд сургуулиудын хувьд нөөц, бололцоогоо ашиглаад хийж байгаа оролдлого, хийж байгаа сайн жишээнүүдийг миний хувьд мэдэж байна. Гэхдээ эдгээр энэ сайн жишээнүүдээс жишээлэх юм бол тэр заавал тусгайлсан хөтөлбөр болгож, хичээлийн хөтөлбөрт интеграцчилах гэдэг дээр Монгол Улсын боловсролын их сургууль тусгай зүрх, сэтгэлийн боловсролын хичээлийг оруулдаг гээд заачихсан. ШУТИС болохлоор 11-ийн ур чадварынхаа нэгэнд оруулаад дипломынхоо ард заавал тусгадаг. Монгол Улсын сургуулийн тэр 48 цаг заавал тусгадаг энэ тэр гэдэг сайн туршлага. Одоо энэ эхэлсэн зүйл дээрээ үргэлжлүүлээд сургууль өөрсдийнхөө нөөц бололцоогоороо энэ сэтгэл зүйн, сэтгэл зүйчийнхээ үйлчилгээг жаахан сайжруул явмаар байгаа юм.

Яагаад гэхлээр сургуулийн багш нар өөрсдөө нийгмийн үйл ажиллагаа хийснээрээ тодорхой оноо авдаг шүү дээ. Тэр оноо нь өөрөө оюутанд чиглэсэн ажил байх ёстой. Тэрний оноог жоохон сургууль өөрийн дүрмээрээ жоохон нэмээд өгчихвөл болмоор юм уу гэж би боддог байхгүй юу. Яагаад гэхлээр би жишээлбэл оюутнуудад өчнөөн илүү цагаар зөвлөгөө өгсөн ч тэр оноо эрдэм шинжилгээний оноо юм уу, ном орчуулах оноотой тэр...цагийн оноо ирж байна шүү дээ. Аягүй бага байдаг байхгүй юу. Ядаж л тийм маягаар зохицуулж ингэж зохион байгуулалтад оруулж бас болно шүү дээ.

Ер нь бол энэ оюутнуудыг практик сургалт үйл ажиллагаагаар дамжуулах ажил хийдэг гэж байгаа. Энэ тэр миний хэлээд байгаа энэ хүнлэг, зүрх, сэтгэлийн боловсрол, ёс суртахууны хичээлүүдийг оруулах энэ төлөвшүүлэхэд л арга нь байхгүй юу. Ганцхан л арга. 1 Сэтгэл зүйчтэй боллоо гээд энэ шийдэгдэх асуудал биш. Дээрээс нь хөтөлбөртэй боллоо гээд шийдэгдэх асуудал биш.

Тэгэхээр оюутанд чиглэсэн энэ ажлыг илүү цогц байвал энэ чинь төгсөгч нь чанартай. Шууд л хамаатай шүү дээ. Тэгэхээр гадаадад ингээд очоод сурахаар энэ ажил бараг аягүй том. Орон зай эзэлж оюутнуудын сурах орчныг бүрдүүлдэг учраас сурлагын чанар, дээрээс нь тэр бүтээмж сайтай байдаг. Ялангуяа энэ оюутанд чиглэсэн үйл ажиллагаа нь хамгийн бас алаг цоог хэрэгжээд байдаг нь манай их, дээд сургуульд хаана байдаг вэ гэхлээр магистр, докторуудад байдаг юм шүү дээ. Магистрт сурч байгаа, докторт сурч байгаа оюутнуудад бүүр байхгүй энэ асуудал бол. Хамгийн их дарамттай, ачаалалтай сурдаг ийм оюутнууд. Ялгаагүй оюутан. Тэгэхдээ Дээд боловсролын энэ хуулийн заалтын дагуу тийм чиглэл ерөөсөө байхгүй байгаа.

Тэгэхээр энэ асуудлуудаар заавал тодорхой төлөвлөгөө гаргаад зөвхөн 1 жил 25 онд он болгож зарлаад зогсохгүй жоохон ийм стратегитай юм хийе гэсэн ийм саналыг хүргүүлж байна. Энийг заавал ярилцаж байгаад хийх хэрэгтэй байна даа.

Ч.Ундрам: Ер нь манай улсын их сургуулиудын чанар, чансаа улсынхаа асуудлыг хэрхэн шийдэж байгаа юм бэ. Тэрүүгээр л харагдаж байгаа. Монгол Улсад өнөөдөр утаа, түгжрэл, орчны бохирдол гээд л олон асуудал байна. Тэгээд л замын чанар, барилгын чанар гээд л энэ та хэдийн л бэлдэж байгаа төгсөгч чинь очоод л ажил хийж байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ дээрээ та хэд маань дүгнэлт хийгээд, тэгээд чанараа сайжруулмаар байна. Чанараа сайжруулмаар байна. Дүрэм, журмуудаа сайжруулмаар байна. Хэрэггүй юмнуудаасаа, хэрэггүй хөтөлбөрүүдээсээ салмаар байна, хэрэггүй багш нараасаа салмаар байна. Тэрнээс хэмнэгдэж байгаа мөнгөө хэрэгтэй хөтөлбөртөө, хэрэгтэй багшдаа зориулмаар байна. Ингэж байж бид нар дээд боловсролын байгууллага чинь сайжирна. Энэ ажлыг би өөрөө МУИС-д ажилласан учраас мэдэж байгаа байхгүй юу. Хийсний үндсэн дээр өнөөдөр 1500-д жагсаж байна шүү дээ 30 мянган сургуулиас дэлхийн. Өшөө урагшаа явах ёстой. Дахиад өшөө сайжруулаад л ингээд л энэ чинь 1 өдөр хийчих алга эргүүлэх төдий ажил биш. Дахиад л урагшаа явах ёстой.

Тэгэхээр энэ дээр их сургуулийн захирлуудаа та нар бас ингээд ажилламаар байна. Ажиллаж чадахгүй бол дараагийнхаа мундаг залууд ажлаа тавьж өгөөд ажлыг нь хийлгэмээр байна. Энэ Монгол Улсын ирээдүй байхгүй юу. Ирээдүйн асуудал. Тэрнээс хэн нь дарга, цэргийн ажилтай байлгах асуудал ерөөсөө биш. Нийтийн эрх ашиг. Энэ бол ард түмнээс сонгогдсон Их Хурлын гишүүдийн үг шүү.

Сая Дамдинням гишүүн зарчмын санал гаргалаа. Тэгэхээр бид нар санал хураалгана. Их Хурлын тухай хуулийн 24.5 дугаар заалт бол Байнгын хороо шаардлагатай бол хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий гишүүдээс бүрдсэн ажлын хэсгийг дангаар буюу хамтран байгуулж, энэ асуудлаар Байнгын хорооны тогтоол гаргана гэсэн ийм заалт. Их Хурлын тухай хуулийн 116.3 Байнгын хороо энэ хуулийн 116.1-д заасан мэдээллийг хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлого төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр тогтоол гаргаж болно гэсэн энэ 2 заалтыг үндэслээд бид нар Боловсролын багц хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулъя гэсэн Дамдинням гишүүний санал байна.

Тэгэхээр энэ ажлын хэсгийг Дамдинням гишүүн ахлаад өөр энэ ажлын хэсэгт орох саналтай Их Хурлын гишүүд байна уу? Саналаа өгье. Бум-Очир гишүүн, Батнайрамдал гишүүн, Эрдэнэбат гишүүн, Саранчулуун гишүүн, Хэрлэн гишүүн, Алтаншагай гишүүн. Энэ гишүүд маань ажлын хэсэгт орж ажиллах юм байна.

Ийм ажлын хэсэг байгуулъя гэсэн саналаар дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулах юм байна. Тийм байна. Тэгэхээр нөгөө намын Ардчилсан намаас Хосбаяр гишүүнийг оруулъя. Мөнхтуяа, Мөнхтуяа гишүүнийг оруулъя. Мөн Үндэсний эвсэл Мягмардашийн Сарнай гишүүнийг оруулъя. Хүн намын сайдтай

юм чинь яах вэ тээ? Ингээд ажлын хэсэг байгуулахыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Нийт гишүүдийн 66.7 хувь нь дэмжсэн учраас ажлын хэсэг байгуулагдлаа.

Өнөөдөр хэлэлцэх асуудал дууссан учраас өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа.

11.49 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР